



Funded by
the European Union



Akademie



MEDIA
COUNCIL OF
MONGOLIA



МОНГОЛ УЛСЫН

ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ЭГЭХ ХАРИУЦЛАГА, ИЛ ТОД БАЙДАЛ, МЭДЭЭЛЭЛ ХАРИЛЦААНЫ ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН СУДАЛГАА

Энэхүү судалгааг Хэвлэл Мэдээллийн Зөвлөлөөс ХБНГУ-ын Дойче Велле Академитай хамтран Европын Холбооны дэмжлэгээр хэрэгжүүлж буй "Өөрчлөлтийн дуу хоолой: Иргэний нийгмийн байгууллагууд эгэх хариуцлага, ил тод байдал, олон нийтийн ойлголтыг сайжруулахын төлөө хүчээ нэгтгэх нь" төслийн хүрээнд явуулав.

Энэхүү судалгааг Хэвлэл Мэдээллийн Зөвлөлөөс ХБНГУ-ын Дойче Велле Академитай хамтран Европын Холбооны дэмжлэгээр хэрэгжүүлж буй “Өөрчлөлтийн дуу хоолой: Иргэний нийгмийн байгууллагууд эгэх хариуцлага, ил тод байдал, олон нийтийн ойлголтыг сайжруулахын төлөө хүчээ нэгтгэх нь” төслийн хүрээнд явуулав.

Тус судалгаанд орсон тоо баримт, түүнтэй холбогдох мэдээлэл, дүн шинжилгээ, үзэл бодол зэрэг нь Европын Холбооны байр суурь, бодлоготой холбоотой байх албагүй бөгөөд тэдгээрийн төлөө тус байгууллага хариуцлага хүлээхгүй.

Судалгааг бэлтгэн, хянан тохиолдуулсан:

Хэвлэл Мэдээллийн Зөвлөлийн “Өөрчлөлтийн дуу хоолой: Иргэний нийгмийн байгууллагууд эгэх хариуцлага, ил тод байдал, олон нийтийн ойлголтыг сайжруулахын төлөө хүчээ нэгтгэх нь” төслийн баг

АГУУЛГА

Удиртгал	5
Судалгааны үндэслэл, шаардлага	7
Өнөөгийн байдлыг тодорхойлох нь	29
Дүгнэлт	65
Зөвлөмж	68
Эх сурвалжийн жагсаалт	71
Хавсралт	72

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ХМЗ	Хэвлэл Мэдээллийн Зөвлөл
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
ИНБ	Иргэний нийгмийн байгууллага
НҮБ	Нэгдсэн Үндэсний Байгууллага
НҮБХХ	НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр
ТББ	Төрийн бус байгууллага
ҮСХ	Үндэсний Статистикийн Хороо
ХЗДХЯ	Хууль Зүй, Дотоод Хэргийн Яам
DWA	Дойче Велле Академи

1. УДИРТГАЛ

XX зууны сүүлээр Монгол Улсад өрнөсөн ардчилсан хувьсгал, түүний үр дүнд батлагдсан шинэ Үндсэн хууль нь иргэдийн эвлэлдэн нэгдэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, эрх чөлөөг хангахад үнэтэй хувь нэмэр оруулсан байдаг.

Энэ үед бий болж эхэлсэн нийтийн эрх ашгийг хамгаалсан байгууллагууд, халамжийн болон хүмүүнлэгийн байгууллагууд, сайн дурын байгууллагууд, сангууд, мэргэжлийн холбоод зэрэг ашгийн бус, ТББ-уудыг нийтлэг шинжээр нь “Иргэний нийгмийн байгууллага (цаашид: ИНБ)”-д хамааруулан ойлгох болсон. Улмаар нийгэм, эдийн засгийн амьдралд гарсан өөрчлөлт, шилжилтийн үйл явц гүнзгийрч, нийгмийн олон талт харилцаа хөгжихийн хэрээр дээр дурдсан байгууллагуудын зорилго, үйл ажиллагааны онцлог, нийгмийн өмнө хүлээсэн чиг үүрэг зэргээр өөр хоорондын зааг ялгаа улам тодрох болсон. ИНБ-ууд нь ардчиллыг бэхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн гэдэгт эдүгээ маргах хүн ховор билээ. АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн (USAID) дэмжлэгтэйгээр 2022 онд Бүгд Найрамдахчуудын Олон Улсын Хүрээлэн (The International Republican Institute)-гээс явуулсан олон нийтийн санал асуулгаар монголчуудын 60 хувь нь ИНБ-ын талаар эерэг үзэл бодолтой буюу тэднийг улс төрийн намуудаас илүүд үзэхээс гадна аль ч төрийн байгууллагаас рейтинг өндөртэй байгааг тодотгосон байдаг. Энэ нь ИНБ-уудын Монголын ардчилалд оруулсан хувь нэмэр, үнэ цэнийг улам бататгаж байна.

Үндэсний Статистикийн Хорооны 2023 оны Аж ахуйн нэгжийн тооллогоор 31130 ТББ тоологдсон боловч үүний зөвхөн 23 хувь буюу 7405 нь үйл ажиллагаа явуулдаг; 6148 нь үйл ажиллагаа явуулаагүй; 17277 нь түр хугацаанд үйл ажиллагаагаа зогсоосон; 269 нь үйл ажиллагаагаа бүрэн зогсоосон; 31 байгууллагын мэдээлэл олдсонгүй; гэж бүртгэжээ. Статистикийн судалгаанаас харахад 2011 оноос хойш идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа ИНБ-уудын тоо нэмэгдэхийн хэрээр үйл ажиллагаа нь зогссон байгууллагын тоо ч огцом өсчээ.

“Үйл ажиллагаа явуулж байгаа” гэж бүртгэгдсэн байгууллага бүрийг, тогтмол, хариуцлагатайгаар үйл ажиллагаа явуулдаг гэж үзэх нь учир дутагдалтай. Тэдгээрээс төр засаг, иргэд олон нийттэй хэлэлцэж, зөвлөлдөж, зөвшилцөн ил тод, нээлттэй үйл ажиллагаа явуулдаг нь цөөхөн. Тухайлбал, МУИС, Конрад Аденауэрын сангийн судалгаанд “нийт ИНБ-уудын 80-аас дээш хувь гадны эх үүсвэрээс санхүүждэг ба үлдсэн хэсгийн санхүүжилтийн эх үүсвэр нь тодорхойгүй байгаа нь эдгээр байгууллага нийгмийн эрх ашгийн төлөө ажиллахаас илүүтэй ашгийн төлөөх байгууллага болж хувирсан гэх шүүмжлэл дагуулж байна” хэмээн тодотгосон байна. Энэ судалгаа нь ИНБ-уудын ил тод бус байдал нь олон нийтийн ойлголтод сөргөөр нөлөөлж буйг харуулах тод жишээ бөгөөд иргэний нийгмийн тухай зөв ойлголт, иргэд олон нийтийн сайн дурын оролцоо зэрэг олон боломжийг цаашид хязгаарлах нөхцөл болох талтай.

Харин ИНБ-уудын эгэх хариуцлага, ил тод байдлыг хангаснаар тэдгээрийн тогтвортой байдал, бие даасан байдалд сэргөөр нөлөөлж болзошгүй хүчин зүйлүүдийг багасгах төдийгүй мэдээлэл харилцааны сувгийн тусламжтайгаар “Иргэний нийгмийн хумигдаж буй орон зай”-г тэлэх, иргэний нийгмийн таатай орчныг олон нийтийн хүчээр бүрдүүлэх боломжтой талаар олон улсын хандивлагч байгууллагуудын зөвлөмж болон бусад судалгааны эмхэтгэлд олонтой тэмдэглэжээ.

Энэхүү тайланд ИНБ-ын мэдээлэл харилцааны хүрээнд, төрийн байгууллага, хэвлэл мэдээлэл, олон нийт зэрэг бусад оролцогч талуудтай харилцахад тулгарч буй бэрхшээл, мэдээлэл харилцааны боломжуудын талаарх ойлголт болоод түүнд тулгуурлан нийгмийн эгэх хариуцлага, ил тод байдлыг хангах арга барилуудыг багтаалаа. Түүнчлэн Монгол Улсын ИНБ-уудын мэдээлэл харилцааны өнөөгийн нөхцөл байдал, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх санал бодлыг тусгаснаас гадна ИНБ-уудын эгэх хариуцлага, ил тод байдал, олон нийтийн ойлголтыг сайжруулах зөвлөмжийг тусгав.

Өнөөгийн байдлын судалгааны үр дүнд үндэслэн төслийн багийн зүгээс ИНБ-уудыг чадавхжуулах, мэдээлэл харилцааны зураглалыг Монголын болон олон улсын экспертүүдийн чиглүүлэгт тулгуурлан боловсруулж, хэрэгжүүлнэ. Эдгээр нь:

- ИНБ-уудын хэвлэл мэдээлэл, мэдээллийн боловсрол, эх сурвалж, баримтыг нягтлан шалгах зэрэг сэдвийн хүрээнд чадавхыг сайжруулан бэхжүүлэх, тусгайлсан сургалтын арга зүй боловсруулах
- Иргэний нийгмийг хөгжүүлэх улс төр, эрх зүйн таатай орчныг бүрдүүлэхийн тулд төрийн байгууллага, хэвлэл мэдээлэл зэрэг оролцогч талуудтай хамтрах, харилцан нөлөөлөх
- Иргэний нийгмийн үйл ажиллагааг олон нийтэд таниулахын тулд хэвлэл мэдээлэл, олон нийт, бусад иргэний нийгмийн байгууллагатай хамтран ажиллах
- Тогтвортой хөгжлийн зорилтуудтай иргэний нийгмийн үйл ажиллагааг нийцүүлэн хөгжүүлэх
- Иргэний нийгмийн үйл ажиллагаанд тохирсон цахим шийдэл бүхий цахим платформыг бий болгох зэрэг үйл ажиллагааг багтаах юм.

2. СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ, ШААРДЛАГА

Судалгааны энэ хэсэгт ИНБ-ууд мэдээлэл харилцааны хүрээнд, төрийн байгууллага, хэвлэл мэдээлэл, олон нийт төдийгүй бусад ИНБ зэрэг бусад оролцогч талуудтай харилцахад тулгарч буй бэрхшээл, мэдээлэл харилцааны боломжуудын талаарх ойлголт болоод түүнд тулгуурлан нийгмийн эгэх хариуцлага, ил тод байдлыг хангах аргуудыг танилцуулав. Үүнд, ИНБ-уудын мэдээлэл харилцааны төлөв байдлын талаарх онолын судалгаа, олон улсын болон манай улсын хоёрдогч судалгаануудын үр дүн, түүврийн судалгааны үнэлгээг тусгалаа.

ИНБ-УУДЫН МЭДЭЭЛЭЛ ХАРИЛЦАА, СУВГУУД

ИНБ-ууд мэдээлэл харилцааны сувгаар дамжуулан төрийн үйл ажиллагааг шүүмжилж, иргэдэд мэдээлэл түгээж улмаар төр, засгийн болон холбогдох байгууллагуудын шийдвэрүүдийг өөрчилсөн тохиолдлууд дэлхий дахинд түгээмэл. Монголд ч мөн ялгаагүй ихэнх ИНБ-ууд мэдээлэл харилцааны сувгаар дамжуулан төрийн үйл ажиллагаа, бодлогыг шүүмжилж, нийгмийн тулгамдсан асуудлаар дуу хоолойгоо идэвхтэй илэрхийлэх, хяналт тавих, үнэлгээ хийх зэрэгт ашиглаж байна. Гэвч үзэл бодол, үйл ажиллагааг иргэд олон нийтэд хүргэх, иргэдийн санал бодлыг үйл ажиллагаандаа тусгах зэрэгт мэдээлэл харилцааны сувгуудыг хэрэглэж буй байдал нь хангалттай түвшинд биш буйг өмнөх судалгааны дүнгүүдээс харж болно. Түүгээр зогсохгүй ИНБ-ууд мэдээлэл харилцааг цахим платформ төдийхнөөр ойлгон, уламжлалт сувгийг огт хэрэглэдэггүй болон хэрэглэх аргаа мэдэхгүй талаар ч өмнөх судалгаануудад дурдсан байна.

Мэдээлэл харилцааны сувгийг хэрхэн үр дүнтэй ашиглах талаар олон төрлийн онол судалгаа байдаг баерөнхий дөрвөн хэлбэртэй гэж үзэж болно: хэвлэлийн агент, олон нийтэд зориулсан мэдээлэл, хоёр урсгалт тэгш бус харилцааны, хоёр урсгалт тэгш харилцааны загвар гэж ангилжээ.²

Хэвлэлийн агент буюу хэвлэл мэдээллийн төлөөлөгч загвар (Press Agency - Publicity) нь зорилтот бүлгийн бодол санаа, үзэл бодлыг бий болгохын тулд олон нийтийн харилцааны сэтгэл зүйд суурилсан ятган үнэмшүүлэх, удирдан жолоодох зэрэг манипуляцийн (eng:manipulation) аргуудыг түлхүү ашигладаг. Орчин үед манипуляци гэдэг нь тодорхой зорилго чиглэлийн дагуу олон нийтийн сэтгэл зүй, хувь хүний ухамсар ба зөн билэгт нөлөөлөн зан үйлийг нь удирдах урлаг хэмээн тодорхойлдог. Германы социологч Франке манипуляцийг “далд хэлбэрээр явагддаг сэтгэл зүйн

² Theunissen, Petra, and Khairiah A. Rahman. "Dialogue and two-way symmetrical communication in public relations theory and practice." In Australian and New Zealand Communication Association Annual Conference, pp. 1-20. 2011.

үйлчлэл” гэж тодорхойлоод реклам, зар сурталчилгааг манипуляцийн энгийн жишээ гэж үзжээ.³ Мөн сэтгэл санаагаар сүрдүүлэх, олон нийтийн анхаарлыг нийгмийн амин чухал асуудлуудаас сатааруулах, дотоод мэдрэмжийг буруугаар ашиглах манипуляци сүүлийн үед газар авч байгааг энд дурдах нь зүйтэй. Энэ загварт зорилтот бүлгийг нарийвчлан тодорхойлох нь чухал биш бөгөөд тэдгээрийн санал хүсэлтийг эрэлхийлдэггүй, зориудаар үүсгэсэн асуудал, үлгэр дууриалал, итгэл үнэмшил, бүлгийн сэтгэл зүй, нэг загварт мэдээлэл болон хэв маяг зэрэгт тулгуурлан зорилтот бүлэгтэй харилцах нь элбэг байдаг байна.

Олон нийтийн мэдээллийн загвар (Public Information) нь хэвлэлийн төлөөлөгчийн загвар бүхий манипуляцийн тактикаас татгалзаж, илүү үнэн зөв мэдээллийг зорилтот бүлэгт өгөхийг эрмэлздэг. Гэсэн хэдий ч мэдээлэл харилцааны хэв маяг нь зорилтот бүлэг буюу үзэгч уншигч руу чиглэсэн нэг урсгалт мэдээлэл байх нь элбэг ба түүх хүүрнэл зохиох (eng:storytelling) аргаар мэдээ мэдээллийг бэлдэн түгээдэг байна. Түүх хүүрнэл зохиолын мэдээ нь барууны орнуудын мэдээлэл хүргэх гол арга зам болж ирсэн замналтай бол Монгол, ялангуяа хуучин социалист орнуудын хувьд утга бүтээх (eng:make sense) арга нь мэдээ, мэдээлэл түгээх үндсэн арга зам болж ирсэн билээ. Зарим хэвлэлийн мэдээ, хэвлэлийн бага хурал зэргийг энэ загварт үндэслэн зохион байгуулдаг ба энэ нь зорилтот бүлгийн хүссэн мэдээллийг урьдчилан онилсон эсвэл урьдчилан судалсан байхыг шаардсан харилцааны загвар биш ч, өмнөх хэвлэлийн агент буюу хэвлэл мэдээллийн төлөөлөгч загвараас ялгаатай нь ёс зүйтэйгээр мэдээлэл түгээхийг шаарддаг. Олон улсад АНУ-ын Олон нийттэй харилцах нийгэмлэг (PRSA)-ийн Ёс зүйн дүрэм, Сэтгүүлчдийн нийгэмлэгийн Ёс зүйн дүрэм -ийг дагаж мөрдөн үнэн зөв мэдээлэл түгээх, ёс зүйтэй илэрхийлэх чиг хандлага төлөвшсөн байдаг. Манай улсад хэвлэл мэдээллийн байгууллагууд сайн дурын зарчмаар ХМЗ-ийн хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмыг баримталж байна.

Харин хоёр урсгалт тэгш бус харилцааны загвар (Two-way asymmetrical) нь зорилтот бүлэгтэй илүү шинжлэх ухааны арга замаар харилцдаг. Зорилтот бүлгийн хандлага, зан үйлийг илүү сайн ойлгохын тулд судалгаа, шинжилгээ хийдэг бөгөөд энэ нь эргээд тэдгээрт түгээх мессежний стратеги, хүргэх мэдээллийг бий болгодог. Энэхүү загвар нь олон нийтийн мэдээллийн загварт байдаг мэргэжлийн хэм хэмжээний сайн чанаруудад суурилж, итгэл үнэмшилтэй мессежийг бий болгоход зорилтот бүлгээс ирсэн санал хүсэлтийг шингээн ашигладаг. Гэвч энэхүү загварыг зорилтот бүлэгт гэхээсээ илүүтэйгээр тухайн байгууллага өөрийнхөө зорилгод илүү ашигтай байхаар хэрэглэдэг учир тэгш бус буюу тэнцвэргүй гэж үздэг.

Хоёр урсгалт тэгш харилцааны загвар (Two-way symmetrical) нь олон нийттэй харилцах хамгийн боловсронгуй, ёс зүйтэй мэдээлэл харилцааны арга гэгддэг байна. Энэ загвар нь байгууллага болон түүний гол оролцогч талуудын хооронд харилцан ашигтай харилцааг бий болгон тэдгээрийн байнгын тогтвортой яриа хэлэлцээнд төвлөрдөг.

³ ШУТИС-ийн Нийгмийн технологийн сургууль. Олон нийттэй харилцах ажил 2013 х.139

Энэхүү загвар нь олон нийтийн харилцааны тэгш бус загварт байдаг байгууллага болон оролцогч талуудын хооронд үүсч болзошгүй эрх мэдлийн тэнцвэргүй байдлыг багасгахыг эрмэлздэг бөгөөд нийгмийн эгэх хариуцлагын хэтийн төлөвийг өргөн хүрээнд авч үздэг. Үүний үр дүнд тухайн байгууллага нь олон нийттэй харилцах ажиллагааны үндсэн ашиг хүртэгч гэж тооцогддоггүй. Харин оролцогч талууд болон тухайн байгууллага нь нийгэмд хамтдаа үйлчлэх адил нэгж гэх ойлголт дор мэдээлэл харилцааны үйл ажиллагаа явуулдаг.

Мөн хоёр урсгалт тэгш харилцааны загварын гол бүрэлдэхүүн хэсэг нь оролцогч талуудын хоорондох харилцан ашигтай яриа хэлэлцээр юм. Харилцан ашигтай яриа хэлэлцээр нь ёс зүйн хэм хэмжээн дор удирдан чиглэгдэх шаардлагатай ба ёс суртахуунт яриа хэлэлцээрийг нэг тал нь давамгайлах бус, харин өгөх, авах хоёр урсгалт харилцааны хэлбэрийг сонгох шаардлагатай гэж үздэг. Ёс зүйтэй яриа хэлэлцээр нь харилцан бие биедээ нээлттэй, хүндэтгэлтэй хандах үед үүсдэг. Мөн зайлшгүй шаардлагатай дараах дөрвөн шалгуурыг тодорхойлсон байх ба харилцаанд оролцогчид аль аль нь:

- Харилцааг эхлүүлэх, дуусгах боломжтой байх
- Ярилцах сэдвийг санал болгох, эхлүүлэх, сэдвийг өөрчлөх боломжтой байх
- Хариулт өгөх чадвартай байх бөгөөд хариулт гэж авч үзэх үндэслэлтэй байх
- Харилцааны сувгийг сонгох боломжтой болон чадвартай байх, тийм нөхцөлийг бүрдүүлэх хэрэгтэй талаар тодотгожээ.

Гэвч хоёр урсгалт тэгш харилцааны загварын мэдээлэл харилцааг голчлон ашигласан ч, ИНБ-уудын мэдээлэл харилцаа нь бизнесийн байгууллага болон төр засгийн байгууллага зэрэг бусад төрлийн байгууллагуудын мэдээлэл харилцаанаас ялгарах зүйл олонтой ба түүнд нөлөөлөх хүчин зүйлүүд ч бусад салбараас ялгаатай нь харагддаг.

⁴ ШУТИС-ийн Нийгмийн технологийн сургууль. Олон нийттэй харилцах ажил 2013 х.200

⁵ <https://www.prsa.org/about/prsa-code-of-ethics>


⁶ <https://www.spj.org/ethicscode.asp>

⁷ <https://www.mediacouncil.mn/p/7>

⁸ Kutay, Acar. "After governance: a normative reflection on civil society participation in policy processes." *Introduktion* (2015): 24.

⁹ Kutay, Acar. "Global Governance, Public Sphere, and CSOs." In *NGOs, Civil Society and Structural Changes*, pp. 153-180. Cham: Springer International Publishing, 2021.

Зураг 1. ИНБ-уудын мэдээлэл харилцаанд нөлөөлөх хүчин зүйл



Тухайлбал улс төрийн хүчин зүйл нь ИНБ-ын удирдлагын төдийгүй хүний нөөцийн бодлогод тодорхой хэмжээгээр нөлөөлж (ерөнхийдөө нөлөөлөх нь ховор гэж үздэг) болох ч олон нийттэй харилцах мэдээлэл харилцааны агуулгад нөлөөлөх нь ховор. Харин төрийн байгууллагын хувьд удирдах албан тушаалтан, гишүүд, баг хамт олны өөрчлөлт зэрэг хүний нөөцийн төдийгүй бодлогын олон асуудал нь мэдээлэл харилцааны агуулгад хөндлөнгөөс шууд бусаар нөлөөлдөг. Энэ талаар Liu & Horsley (2007)¹⁰ нь “Төрийн байгууллагын мэдээлэл харилцаанд улс төрийн нөхцөл байдал тэдгээрийн шийдэл, асуудал ихээхэн нөлөөлдөг ба төрийн байгууллагын мэдээлэл харилцаа бус төрийн байгууллагын удирдагчдад зориулсан мэдээлэл харилцаа болон хувирах нь олонтой” гэжээ.

Хууль тогтоомжийн хүчин зүйлийн хувьд ИНБ нь мэдээлэл харилцааны сувгуудыг ашиглан олон нийтэд хандан мэдээлэл түгээн, өөрсдийн үйл ажиллагааг онцлон илэрхийлэх, үйл ажиллагааныхаа талаар мэдээлэл түгээх эрх нь өргөн хүрээтэй ойлголт байдаг ч, ийн мэдээлэл түгээхдээ худал мэдээлэл эс тараах зэрэг үзэл бодлоо илэрхийлэхийг хязгаарлах хууль тогтоомжийг дагаж мөрдөх шаардлагатай. Харин бизнесийн байгууллагын хувьд мэдээллийг түгээх явцад “Зар сурталчилгааны тухай” хууль, “Өрсөлдөөний тухай” хуулийг мөрдөх шаардлагатай. Төрийн байгууллагын хувьд шударга, төвийг сахисан агуулга бүхий байх нь нэн тэргүүний асуудал ба төрийн байгууллагын бусад хууль тогтоомжийн дагуу мэдээлэл харилцааны үйл ажиллагааг явуулах хэрэгтэй байдаг.

Хэвлэл мэдээллийн нөлөөллийн тухайд бизнесийн байгууллага томоохон компани биш бол хэвлэл мэдээллийн хэрэгсэл тухайн байгууллагын тухай мэдээллийг хэрхэн түгээж буй талаар хяналт тавих нь ховор. Бизнесийн байгууллага харилцагчдын санаа бодол, үзэл бодолд нөлөөлөхийн тулд олон нийтийн харилцааны сэтгэл зүйд

¹⁰ Liu, B. F., & Horsley, J. S. (2007). The government communication decision wheel: Toward a public relations model for the public sector. *Journal of Public Relations Research*, 19(4), 377-393

суурилсан ятган үнэмшүүлэх, удирдан жолоодох зэрэг манипуляцийн арга буюу хэвлэл мэдээллийн төлөөлөгч загварт тулгуурлан хэвлэл мэдээлэлтэй харилцах нь элбэг. Төрийн байгууллагын хувьд хэвлэл мэдээллийн хэрэгсэл хяналтын үүргийнхээ хувиар Засгийн газар, түүний гүйцэтгэх нэгжийн үйл ажиллагаанд шүүмжлэлтэй хандах хандлагатай байдаг. Эдгээрийг харгалзан мэдээлэл харилцаа явуулах шаардлагатай байдаг. Харин ИНБ-ын хувьд тогтмол зар сурталчилгаа, ухуулга гэх мэт явуулах шаардлагагүй ба мэдээллийн ил тод байдал болон хүртээмжийг нэмэгдүүлэх нь тэдгээрийн харилцаанд эергээр нөлөөлнө гэж үздэг. Мөн хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй нээлттэй ил тод харилцах нь олон давуу талыг авчирдаг байна.

Бусад адил төстэй байгууллагын нөлөөллийн хувьд бизнесийн байгууллагууд групп компаниудтай уялдаа холбоотой ажилладаг тул мэдээлэл харилцаа нь тэдгээр байгууллагуудын үйл ажиллагаатай нягт уялдах шаардлагатай. Харин төрийн байгууллагын хувьд мэдээлэл харилцааны агуулгад ялангуяа дээд шатны захиргааны байгууллагын мэдээлэл шууд нөлөөлдөг. Харин ИНБ-уудын хувьд бусад ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг ИНБ-уудтай харилцан мэдээлэл солилцох сүлжээг бий болгох нь мэдээлэл харилцаанд чухал нөлөөтэй гэж үздэг байна.

Зорилтот бүлгийн нөлөөллийн хувьд бизнесийн байгууллагын мэдээлэл харилцааны гол зорилго нь үйл ажиллагааны орлого ашгийг нэмэгдүүлэх байдаг бөгөөд зорилтот бүлэгт хандах мэдээ, мэдээллийг үндсэн чиг болгон чухалчлан үздэг. Тиймээс зорилтот бүлгийг магтах, сайшаах, шүүмжлэх гэх мэтээр тэдгээрт нөлөөлөхийг бизнесийн байгууллага тогтмол тооцоолон харгалзсаны үндсэн дээр мэдээлэл харилцаагаа явуулах шаардлагатай болдог. Төрийн байгууллагын хувьд иргэд төрөөс өгч буй мэдээлэлд шүүмжлэлтэй хандах, хамтран ажиллахаас татгалзах, үл тоомсорлох тохиолдол цөөнгүй гардаг. Иргэд, олон нийтийн шүүмжлэлийн хувьд Liu & Horsley (2007) нар “Төрөөс өгсөн мэдээллийг иргэд шүүмжлэлт сэтгэлгээгээр хандах, шийдвэрт эсрэгээр нөлөөлөх гэж оролдох, хамтран ажиллахаас татгалзах, үл тоомсорлох нь ховор хачин зүйл биш бөгөөд эрүүл үзэгдэл юм” гэжээ. Жишээ нь: Төрийн байгууллагын хувьд 2011 онд Япон Улсын Сага мужийн Такео хот нь тус хотын захиргааны албан ёсны нүүр хуудсыг Фэйсбүүк хуудас руу шилжүүлж, Фэйсбүүкд төвлөрсөн олон нийттэй харилцах үйл ажиллагааг эхлүүлсэн байна. Гэвч ийнхүү Фэйсбүүк буюу сошиал платформ руу шилжсэн нь олон нийтийн мэдээллийн хэрэгслээр цацагдаж, томоохон маргаан үүсгэсэн төдийгүй иргэдийн шүүмжлэлтэй ч тулгарч байв. Иймд аль ч цаг үед иргэд олон нийтийн шүүмжлэл байдаг ба олон нийттэй харилцах харилцааг зорилтот бүлэгт илүү амраар хүлээн зөвшөөрөгдөх байдлаар төлөвлөж, хөгжүүлэх нь давуу тал болдог. Харин ИНБ-уудын хувьд тодорхой бүлэгт ашигтай хэмээн мэдээллийг хязгаарлах нь дараагийн олон давуу боломжийг хязгаарлах аюултай тул зорилтот бүлэг төдийгүй зорилтот бус бүлэгт ч хамаарал бүхий байхаар мэдээлэл харилцааг хөгжүүлэх шаардлагатай. Мөн ИНБ-ууд иргэдийн

¹¹ Reed, S. R. (2010). Japanese prefectures and policymaking. University of Pittsburgh Pre.

шүүмжлэлийг хэт эмзэг хүлээн авах хандлага байдаг ба үүнтэй холбоотой шийдлийг мэдээлэл харилцааны журамд тусгах шаардлагатай байдаг.

Хүний нөөцийн хүчин зүйлийн тухайд бизнесийн байгууллагууд олон нийттэй харилцах хэлтэстэй байх эсэхийг эдийн засгийн үр өгөөжөөр үнэлдэг ба дотоодын нэгж гэхээсээ илүүтэй PR компанид мэдээлэл харилцааны ажлыг даатгах нь цөөнгүй. Олон нийттэй харилцах албатай байгууллагын хувьд урт хугацааны ашиг орлого, бусад зорилтын үүднээс тус алба нь гүйцэтгэх захирал болон удирдах албан тушаалтантайгаа нягт хамтран ажиллах нь түгээмэл байдаг. ИНБ-уудын хувьд хүний нөөцийн асуудал нь санхүүгийн чадамжтай шууд холбогдох нь түгээмэл. Ихэнх ИНБ-уудад олон нийттэй харилцах боловсон хүчнийг бэлтгэх хүч, санхүү, тогтолцоо байхгүй. Гаднаас мэргэжилтнүүд урьсан ч боловсон хүчний дунд ноу-хау хуримтлуулах боломж хомс байх тал бий.

Эдгээр онцлог, нөлөөлөх хүчин зүйлээс шалтгаалан ИНБ-уудын мэдээлэл харилцааг бизнесийн байгууллага, төрийн байгууллага зэрэг бусад төрлийн байгууллагын мэдээлэл харилцаатай шууд адилтгаж үзэн жиших нь зохисгүй бөгөөд амжилттай, үр бүтээлтэй харилцааг бий болгохгүй юм.

Иймд олон улс дахь ИНБ-уудын мэдээлэл харилцааны чиг үүрэг, статусын тухай ойлголт, хандлагыг Монголын өнөөгийн нөхцөл байдалтай жишин, тулгамдаж буй асуудал, сорилт бэрхшээлийн талаар дараах хэсэгт тусгалаа.

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН БАЙГУУЛЛАГАТАЙ ХАНГАЛТТАЙ ТҮВШИНД ХАРИЛЦАЖ БАЙНА УУ

Өнөөдөр Монголд ИНБ-уудын хэвлэл мэдээлэлтэй харилцах, хоорондын хамтын ажиллагааг тодорхой болгох хэрэгцээ байна. ИНБ-уудын мэдээлэл харилцааг үйл ажиллагааны чиг үүргүүдтэй бүхий л түвшинд уяан сайжруулах шаардлагатай байгааг олон улсын төдийгүй Монголын хэд хэдэн судалгаанд дурджээ. Угтаа хэвлэл мэдээлэл, иргэний нийгмийн түншлэл, хамтын ажиллагаанд харилцан итгэлцэл, тэдгээрийн засаглалын ил тод байдал хамгийн чухал нөлөөтэй.

Тус судалгааны ганцаарчилсан ярилцлагад оролцсон ИНБ-ын төлөөлөгчид хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах шаардлагатай гэдгээ илэрхийлсэн хэдий ч сүүлийн үед олон нийтийн сүлжээгээр иргэний нийгмийг гутаан доромжлох явдал газар авч байгаа нь иргэний нийгмийн хөгжилд эрсдэл учруулж болзошгүй байгааг мөн дурджээ. Тухайлбал ИНБ-ын далд эзэн нь улс төрчид байдаг гэх мэт хуурамч мэдээлэл нь олон нийтийн яриа хэлэлцүүлгийг гажуудуулж, ардчилалд итгэх итгэлийг сулруулан, үзэн ядалтыг өдөөж байна. Хуурамч мэдээлэл (disinformation)

¹² Brugnoli, E., Gravino, P., & Prevedello, G. (2023, September). Moral values in social media for disinformation and hate speech analysis. In International Workshop on Value Engineering in AI (pp. 67-82). Cham: Springer Nature Switzerland.

¹³ СИВИКУС олон улсын байгууллагаас гаргасан иргэний нийгмийн төлөв байдлын тайлан - 2023

¹⁴ Үндэсний статистикийн хороо, "Эс Ай Си Эй" ХХК (SICA LLC), Иргэний нийгмийн Консорциум. "Иргэний орон зайн төлөв байдал, түүнийг дэмжих эрх зүйн таатай орчны хэрэгцээ шаардлагыг тодорхойлох судалгаа", 2021, Улаанбаатар 59х

бүхий манипуляцын, хуйвалдааны онолын арга тактикийг ардчилсан нийгэмд хагарал үүсгэх, хүний эрхийн зөрчлийн талаар эргэлзээ, төөрөгдөл төрүүлэх зэрэгт ашиглах нь түгээмэл болжээ. Хуурамч мэдээлэл, үзэн ядсан үг хэллэг нь иргэний нийгэм, ялангуяа нийгмийн цөөнхийн эрхийн асуудлаар ажилладаг идэвхтнүүд рүү илүүтэй чиглэж байна. ИНБ-ууд үзэл бодлоо илэрхийлэх, үйл ажиллагаагаа сурталчлах зэргээр хэвлэл мэдээлэлтэй харилцаж байгаа ч хуурамч мэдээллийн хэмжээ, далайц асар их болсныг дурджээ.

Монголд иргэний нийгмийн байгууллагууд ба хэвлэл мэдээлэл хоорондын харилцааг дүгнэн хэвлэл мэдээлэл, иргэний нийгмийн үр дүнтэй хамтын ажиллагааг үнэлсэн судалгаа, тулгамдсан асуудал, сорилт бэрхшээлийг зүй зохистой тодорхойлсон дэлгэрэнгүй мэдээлэл байхгүй байна. Зарим тайлан, судалгаанд хэсэгчилсэн байдлаар тусгасан байна. Тухайлбал “Иргэний орон зайн төлөв байдал, түүнийг дэмжих эрх зүйн таатай орчны хэрэгцээ шаардлагыг тодорхойлох судалгаа (2021)”-д Улаанбаатар хотын 18.4 хувь нь, хөдөөгийн 16.9 хувь нь хэвлэл мэдээллээр үзэл бодлоо илэрхийлэх, үйл ажиллагаагаа сурталчлах зэрэгт ямарваа нэг саад бэрхшээл тулгардаг ба үнэ төлбөрийн асуудал хүндрэлтэй байдгийг онцолжээ.

Түүгээр зогсохгүй, ИНБ-ууд хэвлэл мэдээллийн сувгаар дамжуулан үйл ажиллагаагаа сурталчлах, түгээх үед л хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажилладаг хэмээн судалгааны дүнгүүдэд тусгажээ. Гэхдээ бодит байдал дээр, “Live хийх, сошиал шууд дамжуулалт хийх”, “Цахим сургалт, уулзалт, хэлэлцүүлэг олон нийтэд зохион байгуулах”, “Иргэдээс цахим хэлбэрээр санал, өргөдөл авах”, “Олон нийтэд хүргэсэн мэдээллийн цар хүрээг нэмэгдүүлэхийн” тулд хэвлэл мэдээллийн сувгийг тогтмол ашиглаж байгаа нь харагдаж байна.

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАТАЙ ХЭРХЭН ХАРИЛЦАЖ БАЙНА ВЭ?

Иргэний нийгэм, төртэй харилцан хяналттай, тэнцвэртэй оршсоноор нийгэм тогтвортой байх нөхцөл бүрддэг гэж үздэг. Төр, иргэний нийгмийн харилцаа тогтвортой нөхцөлд хувийн болон нийтлэг эрх ашиг хослон нийгэм хөгжих боломж нээгддэг. Иргэний нийгэм төрийн байгууллагаас ангид хэт давамгайлбал нийгэмд анархизм, харин төрийн эрх мэдэл нийгэмд хэт хүчирхэгжвэл тоталитаризмыг бий болгодог. Төр, иргэний нийгэм уялдаатай байж гэмээнэ нийгэмд тогтвортой хөгжил, дэвшлийг авчирдаг бол ардчилсан бус улсад иргэний нийгэм идэвхгүй, айдаст автсан эсвэл төрийн эсрэг хэт сөрөг хүчин болж хувирдаг. Иймд ИНБ-ууд төрийн байгууллагатай тогтмол харилцан тэдгээртэй мэдээлэл солилцох төдийгүй бодлогын түвшинд үзэл бодлоо чөлөөтэй солилцож, харилцан бие биенийхээ эрх ашгийг хүндэтгэн харилцан хяналттай, эв нэгдэлтэй зэрэгцэн орших нь чухал юм.

¹⁵ Walzer, Michael. “The concept of civil society.” Toward a global civil society 7 (1995).

¹⁶ Asian Development Bank. (2013). “Civil Society Brief Mongolia” <https://www.adb.org/sites/default/files/publication/503101/civil-society-brief-mongolia.pdf>

¹⁷ Almog-Bar, M., Greenspan, I., Schmid, H., & Oreg, A. (2024). The Three P's in Nonprofit Human Service Mergers: Strategic Response to Coping with a Crisis. Human Service Organizations: Management, Leadership & Governance, 48(3), 305-322.

Манай улс ардчилсан нийгэмд шилжсэнээс хойш өнөөг хүртэл төрийн албан тушаалтнуудын шударга бөгөөд нээлттэй байдлыг бүрдүүлэх, хадгалахад бие даасан ашиг сонирхлын бүлгүүд, нийгмийн хөдөлгөөнүүд үнэ цэнтэй хувь нэмэр оруулсан. Ерөнхий утгаараа ИНБ-ууд олон салбарт тулгамдаж буй асуудлыг илрүүлэх, Засгийн газарт шинэлэг санаа, санаачилга гаргахад дэмжлэг үзүүлэн манлайлан оролцдог. Өнгөрсөн хугацаанд ИНБ-ууд төрийн байгууллагын шийдвэр болон түүний хувилбарт өөрсдийн санал санаачилга, туршлагаа ил тодоор нээлттэй илэрхийлсээр ирсэн. Азийн Хөгжлийн Банкны Иргэний нийгмийн хэрэгцээ шаардлагын үнэлгээнд (2013) дурдсанаар орон нутгийн ИНБ-ууд орон нутгийн түвшинд гаргаж буй бодлогын шийдвэрт нөлөөлөх нь өсөн нэмэгдсэн байна.

Гэсэн хэдий ч төр, иргэний нийгмийн хамтын ажиллагаа тодорхойгүй хэвээр байна. Төр, иргэний нийгмийн хоорондох чиг үүрэг, харилцааны уялдаа холбоог бүх салбар, төрийн удирдлагын бүхий л түвшинд сайжруулах шаардлага буйг хэд хэдэн судалгаа онцолжээ. Оролцогч талуудтай хамтран ажиллахад тулгарч буй хамгийн ярвигтай асуудал бол өөр төрлийн харилцаа холбоо, хандлага, ойлголттой оролцогч талуудтай хамтран ажиллах явдал хэмээн тэмдэглэжээ.

Тогтвортой хөгжлийн зорилтуудын хэрэгжилтийг тайлагнадаг ИНБ-ын үндэсний тоймд дурдсанаар хөгжлийн бодлого, хэрэгжилтийг тогтмол төлөвлөх, үнэлэх, хянахад ИНБ-ын оролцоог хангах механизм хангалтгүй, иргэдийн сайн дурын ажлыг дэмжих бодлого, зохицуулалт дутагдалтай хэмээн нэгтгэн дүгнэжээ. Аль ч яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллагууд ИНБ-уудтай хэзээ, хэрхэн хамтран ажиллах талаар тодорхой бодлого, журам байдаггүй. Одоогийн байдлаар ИНБ-ын оролцоо нэг удаагийн хурал, чуулганаар хязгаарлагддаг ба төрийн байгууллагуудын ажлын хэсэг, хороод "өөрсдийн" ИНБ-уудыг татан оролцуулах нь түгээмэл байна.

Нэмж дурдахад, иргэний нийгмийн хөгжлийг гажуудуулж, тус салбарын хөгжлийг сааруулах эрх ашгийн төлөө ажилладаг байгууллагууд олширч буй бөгөөд эдгээр байгууллагууд нь нэг удаагийн, төрийн өмчит, эсвэл төрөөс санхүүжилттэй ТББ-ууд юм гэдгийг ч судалгааны дүгнэлтүүдэд нэг бус удаа дурьджээ. Угтаа төр, иргэний нийгмийн харилцаа, түүгээр дамжсан засаглалын ил тод байдал хамгийн чухал нөлөөтэй боловч өнөөдрийг хүртэл энэ сэдвийн хүрээнд эрх баригчид болон засгийн газрын эрх ашиг, хүсэл зоригийг тодорхойлсон судалгаа хийгдээгүй төдийгүй, төр, иргэний нийгмийн харилцаа хангалттай хэмжээнд бус байгаа нь олон улсын жишээн дээрээс харагдаж байдаг.

Цаашилбал, "Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай" хуулийн дагуу мэдээлэл авах эрхээ эдлэхээр 10 ИНБ тутмын 1 нь тэмцэж буй бол ИНБ-уудын 41.7 хувь нь төрийн шийдвэр, үйл ажиллагааны талаар шүүмжлэлтэй байр сууриа илэрхийлсэн мөн 17.6 хувь нь хууль дээдлэх ёсыг шаардсан ба/эсхүл хүний эрхийг хамгаалсныхаа төлөө төрийн байгууллага, албан тушаалтны хүчирхийлэл, дарамт шахалтад өртөж байна гэжээ. Иргэний нийгмийн талаарх олон янзын судалгаануудаас харахад, ИНБ-уудын идэвхтэй оролцоо, чадавхыг бэхжүүлэхэд тулгардаг нийтлэг бэрхшээлүүд нь

нэг талаас төрийн бодлогын дэмжлэг сул, нөгөө талаас төрийн байгууллагууд ИНБ-уудтай харилцахаас цааргалдаг байдалтай холбож болохоор байна.

Сүүлийн жилүүдэд ИНБ-уудын чадавх, оролцоо, шийдвэр гаргах түвшинд нэмэгдэхийн хирээр Монгол Улсын төрийн хяналт, тэнцвэрт байдалд үгүйлэгдэж буй сөрөг хүчний үүрэг ролийг иргэний нийгмийн байгууллагууд гүйцэтгэж байна гэхэд хилсдэхгүй. ИНБ-уудын хувьд энэ нь төртэй харилцах нэг төрлийн боломж байж болох юм.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд төрийн зарим чиг үүргийг ИНБ-д шилжүүлэх тухай санал санаачилгыг бодлого боловсруулагчид, ИНБ-ууд, хувийн хэвшил, олон нийт зэрэг нийгмийн оролцогч талуудын зүгээс дэвшүүлэх болж, энэ чиглэлээр зарим нэг хууль, эрх зүйн болоод бодлогын баримт бичгүүдэд тусгах болсон (УИХ, 2012). Гэвч эдгээр баримт бичгүүдэд “Иргэний Нийгмийн Байгууллага” гэдэгт юуг ойлгох, тэдгээрийн статус, чиг үүргийн талаар тодорхой, тогтсон ойлголт байхгүйгээс мэргэжлийн холбоодтой адилтган үзэн төрийн зарим чиг үүргийг шилжүүлэх гэснээр хязгаарлагдсан хэвээр байна.

Олон нийтийн эрх ашгийг хамгаалах, төрийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий олон нийтийн статустай ИНБ-ыг тухайн салбарын мэргэжилтэн, салбарын эздийн эрх ашгийг илэрхийлж гишүүддээ үйлчлэх чиг үүрэг бүхий мэргэжлийн холбоодтой холих нь эрсдэлтэй. Учир нь олон нийтийн статустай ИНБ нь олон нийтийн өмнөөс төрийн үйл ажиллагаанд хяналт тавих, дуу хоолойгоо хүргэх, нийтийн эрх ашгийг төлөөлж байх ёстой бол мэргэжлийн холбоод нь тухайн салбартаа мэргэжлийн стандартыг тогтоох, тухайн салбарт ажиллаж буй хүмүүсийн эрх ашгийг хамгаалахад чиглэдэг хоёр өөр байгууллага юм (Harvey, 2010).

Энэ тодорхойгүй байдал нь дараах эрсдэлтэй нөхцөл байдлыг бий болгож байна.

Үүнд:

1. Төрийн үйлчилгээг гүйцэтгэхдээ мэргэжлийн чадавх султайгаас гүйцэтгэж чадахгүй байх;
2. Ашиг сонирхлын зөрчилд орох, зах зээлд тэгш бус өрсөлдөөн бий болгох замаар салбарын хөгжлийг боомилох;
3. Төрөөс шилжүүлж авсан чиг үүрэг, үйл ажиллагааг гүйцэтгэж чадаагүй, эсвэл ашиг сонирхлын зөрчлийн улмаас нийт ард иргэдэд тэгш үйлчлэхгүй байх, улмаар нийгэм, эдийн засагт сөрөг үр дагавар, хохирол учруулах;
4. Авлигын лобби бүлэг үүсгэх;
5. Улс төр, ашиг сонирхлын бүлгийн нөлөөнд автах зэрэг болно.

¹⁸ <https://sdg.1212.mn/>

¹⁹ Zyl, Albert. “How civil society organizations close the gap between transparency and accountability.” Governance 27.2 (2014).

²⁰ Harvey, B. L. (2010). Speaking to power: The discursive shaping of Southern communities and institutions in international development cooperation.

Гэвч бусад оронд ИНБ-уудын үйл ажиллагааны хүрээ илүү тодорхой байна. 1992 онд Их Британийн Парламентын дээд танхим (House of Lords) ИНБ-уудын нийгмийн өмнө хүлээх үүрэг хариуцлагын талаарх саналыг хэлэлцсэн (Benson, 1992) нь ИНБ-ын нийгмийн чиг үүргийг тодорхойлоход чухал ач холбогдолтой зүйл болсон гэж хэлж болно.

Эдгээр есөн үүрэг нь:

Төрийн байгууллага нь зохих стандартын дагуу хамтран ажиллах нөхцөл тогтоох ёстой ба түүний дараа ИНБ-уудын ур чадварыг нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн стандартад нийцэж байгаа эсэхэд хяналт тавих ёстой. Суралцах үйл нь ИНБ-уудын үйл ажиллагааны карьерын хувьд тасралтгүй үргэлжилж байх ёстой.

Төрийн байгууллагын зүгээс ИНБ-уудтай үйл ажиллагаа хамтран явуулах мэргэжлийн ёс зүйн дүрэм болон стандартыг тогтоох хэрэгтэй. Энэ нь хуулиар ерөнхийлөн тогтоосон хэм хэмжээний түвшнээс илүү нарийвчлан боловсруулагдсан байх ёстой.

Төрийн байгууллагын зүгээс тогтоосон дүрэм, журам, стандарт нь зөвхөн олон нийтэд ашиг тусаа өгөхөд чиглэхээс бус ИНБ-уудад тусгайлан давуу эсвэл сул тал бий болгоход ашиглагдах ёсгүй.

Хэрэв ИНБ нь гаргасан дүрэм, журам, стандартыг дагаж мөрдөөгүй, ёс зүйн ноцтой зөрчил гаргасан, мэргэжлийн ажлаа буруу, хангалтгүй гүйцэтгэсэн зэрэг асуудал гарсан нь тогтоогдсон нөхцөлд шаардлагатай гэж үзвэл хамтрах ИНБ-аас түдгэлзүүлэх хүртэлх сахилгын арга хэмжээ авдаг байх ёстой.

Дан ганц ИНБ-ын сонирхлыг хангах, тэдэнд давуу тал олгохын тулд бус, нийтийн эрх ашгийг хамгаалахын тулд зайлшгүй шаардлагатай сургалт, мэргэжлийн ёс зүй, стандарт, хэм хэмжээг хангасан хувь хүмүүсээр ажил, үйлчилгээг гүйцэтгүүлэх хууль эрх зүйн орчныг бүрдүүлсэн байх ёстой.

Төрийн байгууллага нь мэргэжлийн нээлттэй, шударга өрсөлдөөнийг хангаж олон нийтийг болзошгүй эрсдэлээс сэргийлэх ёстой. Үүнээс үүдэн ИНБ-ууд нь тухайн ажил, үйлчилгээг эрхлэх дадлага туршлага, мэдлэг, ур чадвар, чадавх, түүнд төлөх үнэ хөлсний талаарх мэдээллээ олон нийтэд нээлттэй хүргэдэг байх ёстой.

Хамтарсан нөхцөлөөр ажил эрхэлдэг эсэхээс үл хамаараад аливаа ИНБ-ууд үзэл бодлоо чөлөөтэй, бие даан илэрхийлэх боломжтой байх ёстой. Мөн тэд ямар нэгэн айдас, хэн нэгний нөлөөгүйгээр үгээ чөлөөтэй хэлэх ёстой. ИНБ-ууд нь бие даасан байдалд сөргөөр нөлөөлөх аливаа этгээд буюу байгууллагын хяналт, ноёрхол, дарамт шахалтыг зөвшөөрч болохгүй.

ИНБ-ууд нь өөрийн мэргэшсэн төрлөөрөө тухайн ажиллаж буй салбартаа манлайлж байх нь зүйн хэрэг.

Профессор Ли Харвей ИНБ-ын чиг үүргийг маш ерөнхий байдлаар, нэгдүгээрт, олон

²¹ Dickinson, A. (1998). Restitution and the Conflict of Laws in the House of Lords. RLR, 6, 104.

нийтийн ашиг сонирхлыг хамгаалах буюу олон нийтэд аливаа чадамжийг олгох, хоёрдугаарт, ИНБ-уудын ашиг сонирхлыг төлөөлөх, тэдний мэргэжлийн хувьд өсөж дэвжих, хөгжих боломжийг хангах, гуравдугаарт, төртэй хамтрахын сацуугаар төрийн хяналт, зохицуулалтын байгууллагын хувьд өөрийн ашиг сонирхлыг илэрхийлэх (Lee Harvey, Selena Mason, 1995) гэж тодорхойлжээ.

ИНБ-ууд болон тэдгээрийн чиг үүргийг судалдаг зарим судлаачид дараах үндсэн зарчмуудыг онцолжээ:

- Дотоод ардчилал, хяналтын тогтолцоотой, улс төрөөс ангид байх;
- Дотоод сонгуульд мэдлэг, мэргэжлийн ур чадвар, ёс зүй, салбар дахь нэр хүнд, салбартаа болон нийгэмд оруулах хувь нэмэр, мөн бусад шаардлагуудыг харгалздаг байх;
- ИНБ-уудын үйл ажиллагааны болон санхүүгийн аудиторууд Удирдах зөвлөлөөс хараат бус байх. Нэгэнт нийтийн чиг үүргийг хэрэгжүүлж байгаа нөхцөлд аудит, төрийн хяналт шалгалт бол зайлшгүй шаардлагатай.

МОНГОЛ УЛСАД ИНБ-ЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН БИЙ ЮУ?

Одоо мөрдөгдөж буй эрх зүйн орчны хүрээнд иргэдийн эвлэлдэн нэгдэх эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой төрийн харилцааг зохицуулж буй гол хууль нь 1997 онд батлагдсан “Төрийн бус байгууллагын тухай хууль” юм. Мөн Монгол Улсад байгуулагдаж буй хуулийн этгээдийн хэлбэрийг 2002 онд шинэчилсэн Иргэний хуулинд “ашгийн төлөө хуулийн этгээд” ба “ашгийн төлөө бус хуулийн этгээд” гэсэн хоёр хэлбэртэй байхаар тусгасан байна.

2009 онд “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлого”-ын баримт бичиг (УИХ, 2009), “Концессын тухай” хууль (2010) тус тус батлагдаж эдгээр бодлогын баримт бичгийн дагуу төрийн зарим чиг үүргийг ИНБ-д шилжүүлэхтэй холбоотой эрх зүйн орчин бүрдсэн. Мөн салбарын хуулиудад ч төрийн зарим чиг үүргийг ИНБ-аар гүйцэтгүүлэхтэй холбоотой тодорхой заалтууд тусгагдаж хэрэгжсэнийг энэ чиглэлийн судалгааны үр дүнгээс харж болно (Цэрэндорж.Д, Ариунаа.Л, Алтайбаатар.Ж, 2010).

Дээрх нөхцөл байдал нь төрийн чиг үүргийг хариуцан гүйцэтгэх ИНБ нь тухайн салбарын ажил үйлчилгээ, чиг үүргийг гүйцэтгэх мэргэжлийн чадавх, нөөц бололцоотой байхыг шаардах болсноор ИНБ-уудыг энэ асуудалд анхаарлаа хандуулахад хүргэсэн гэж хэлж болно. Түүний зэрэгцээ төрийн зарим байгууллагын зүгээс ИНБ болон мэргэжлийн холбоодын ялгаа, гүйцэтгэх үүргүүдийг тодорхой заасан эрх зүйн орчин бүрдээгүйгээс

¹⁸ Harvey, L., Mason, S., & Ward, R. (1995). The role of professional bodies in higher education quality monitoring. Birmingham: QHE.

¹⁸ Цэрэндорж.Д, Ариунаа.Л, Алтайбаатар.Ж, Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллага, хувийн хэвшилд шилжүүлэх нь 2010 он

төрийн зарим чиг үүргийг ИНБ-д шилжүүлэхээс татгалзаж байсан тохиолдол ч гарч байв

Төрийн зүгээс ИНБ-уудтай холбоотой хамтран ажиллах, ажлын хэсэг, зөвлөлийн бүрэлдэхүүнд оролцуулах зэрэг цөөн хэдэн харилцааг тусгасан доорх хууль, эрх зүйн бичиг баримтууд байна. Үүнийг баримт бичгийн төрлөөр нь харуулбал:

- Монгол Улсын (11) хуулинд төрийн байгууллагаас ИНБ-уудтай холбоотой тодорхой чиглэлээр хамтран ажиллах, зөвлөл, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллуулах, хяналт тавих, эрх олгохтой холбоотой чиг үүргийг ИНБ-уудад шилжүүлэх харилцааг зохицуулсан заалтууд;
- Монгол Улсын Их Хурлын тогтоолоор баталсан бодлогын болон эрх зүйн бичиг баримтуудад (4) төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд зөвлөмж гаргах, дэмжлэг үзүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, сургалт зохион байгуулах ажлыг ИНБ-уудтай хамтран хэрэгжүүлэх, тусгай зөвшөөрлийг ИНБ-уудад шилжүүлэх асуудлыг судлан үзэхтэй холбоотой заалтууд;
- Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор (8) Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ИНБ-уудтай хамтран ажиллах, яам, Засгийн газрын агентлагийн хэрэгжүүлж байсан зарим чиг үүргийг ... ИНБ-уудад... - шилжүүлэх талаар санал боловсруулах, нэгдсэн сургалтад хамруулах ажлыг зохион байгуулахад ИНБ-уудыг оролцуулах, орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүнд ажиллуулах, төрөөс баримтлах бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөний төсөл болон холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар ИНБ-уудын саналыг тусгах зэргийг тус тус заажээ.

Ийнхүү өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Монгол Улсын хууль, УИХ-ын болон Засгийн газрын тогтоолоор баталсан бодлогын бичиг баримтуудад төрийн байгууллагаас ИНБ-уудтай тодорхой чиглэлээр хамтран ажиллах, төрийн зарим чиг үүргийг ИНБ-уудад шилжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулсан цөөн заалтууд тусгагдсан боловч "ИНБ" гэдэгт юуг ойлгох, түүний статус чиг үүрэг ямар байх тухай тусгайлан тогтоосон эрх зүйн орчин бүрдээгүй байна.

Харин төрийн зарим чиг үүргийг ИНБ-ууд, тэдгээрийн байгууллагуудаар хариуцуулан гүйцэтгүүлэх чиглэлээр тодорхой алхмууд хийгджээ. Тухайлбал,

1. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль (2012)-ийн хүрээнд хуульчийн мэргэжлийн эрх олгох, хязгаарлах, цуцлах гэх мэт 12 чиг үүргийг Хуульчдын холбоо гүйцэтгэх,
2. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль (2001)-ийн хүрээнд нягтлан бодох бүртгэл, хяналтын зарим чиг үүргийг сонгон шалгаруулалтын үндсэн дээр төрийн бус мэргэжлийн байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлэх,

3. Аудитын тухай хууль (1997)-ийн хүрээнд мэргэшсэн нягтлан бодогч, аудиторуудын мэргэжлийн ёс зүйг баталж, үндэсний хэмжээнд мөрдүүлэх чиг үүргийг мэргэшсэн нягтлан бодогчдын институт хэрэгжүүлэх,
4. Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хууль (2012)-ийн хүрээнд татварын итгэмжлэгдсэн хуулийн этгээд, татварын мэргэшсэн зөвлөхүүдийн мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, эрх ашгийг хамгаалах, ёс зүйн дүрмийг баталж хэрэгжүүлэх, хяналт тавих гэх зэрэг чиг үүргийг Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэг гүйцэтгэхээр тус тус заажээ.

Цаашилбал, Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан “Үндэсний хөгжлийн цогц бодлого” (2007-2021), “Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр” зэрэг баримт бичгүүдэд иргэний нийгмийн байгууллагуудыг хөгжүүлэх, үйл ажиллагааг нь өргөжүүлэх, төрийн зарим чиг үүрэг, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх талаар тусгасан байна.

2010 онд Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.3.4.2-т “Төрийн бодлого боловсруулах, төрд хяналт тавихад төрийн бус байгууллагын тэгш оролцоо, зөвшилцлийг хангах замаар иргэний нийгмийн төлөвшлийг дэмжинэ. Нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг дэмжсэн эрх зүйн орчныг бүрдүүлж, төр-иргэний нийгмийн хамтын ажиллагааны бүтээлч арга, хэлбэрүүдийг хөгжүүлнэ” хэмээн заасан байдаг.

Монгол Улсын “Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаанд иргэний нийгмийн тухай дурдахдаа иргэний нийгэм-хувийн хэвшил-төрийн гурван талт түншлэлийг бэхжүүлэх замаар үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлт, хэрэгжилтэд холбогдох талуудын оролцоог хангахад зайлшгүй шаардлагатай тогтолцоог бүрдүүлнэ гэж оруулсан. Ингэхдээ хүний эрхийг дээдэлсэн нийгэм, авлигагүй засаглал гэсэн хэсэгт иргэний нийгмийн оролцоо хангалтгүй эсвэл Монгол Улсын тогтвортой хөгжилд төр, иргэний нийгмийг хүчтэй түнш гэж үзэхгүй байгаа мэт харагдаж байна.

ИНБ-ууд иргэний нийгмийн хөгжлийн үзэл баримтлалыг боловсруулсан. Үүнийг 21 аймаг, Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ИНБ-ын 500 гаруй төлөөлөгч хэлэлцлээ. Энэхүү үзэл баримтлалд иргэний нийгмийн үзэл баримтлалаас гадна үнэт зүйл, зарчим, бодлогын хүрээ, үзэл баримтлалыг хэрэгжүүлэх тогтолцоо зэрэг багтсан. Үзэл баримтлалын төсөл нь төр, Монголын иргэний нийгмийн хамтын ажиллагаанд баттай суурь болсон гэж Ашгийн төлөө бус хуулийн олон улсын төв (The International Center for Not-for-Profit Law) - өөс дүгнэжээ. Нэмэлт засвар, сайжруулалт нь үзэл баримтлалыг эцэслэхэд хувь нэмрээ оруулж, Монгол Улсын Засгийн газар болон иргэний нийгмийн оролцогч талуудад хэрэгжүүлэх боломжтой байх баталгаа болно.

МОНГОЛ ДАХЬ ИНБ БОЛОН ТӨРИЙН ХАРИЛЦАА ОЛОН УЛСЫН ЖИШИГТ НИЙЦЭЖ БАЙНА УУ?

Олон улсад үйл ажиллагаа явуулж буй ИНБ-уудын өөрсдийнх нь тодорхойлсноор найман төрлийн 25 чиг үүргийг хэрэгжүүлж байна гэж үздэг. Үүнд:

Бодлого зохицуулалтын чиг үүрэг - дөрөв

- Тухайн үйл ажиллагаа, зорилтот бүлгийн цаашдын хөгжлийн бодлогыг тодорхойлох;
- Үйл ажиллагаанд нөлөөлөх хууль, боловсрол, технологийн хөгжлийн түвшинг тодорхойлох;
- Шаардлагатай бодлогыг боловсруулах, өөрчлөхөд оролцох, санал оруулах, санал өгөх;
- Ашигтай зах зээл олгох, экспортыг дэмжих чиглэлээр төрийн бодлогод нөлөөлөх;

Төлөөлөх, хамгаалах чиг үүрэг – дөрөв

- Зорилтот бүлэг, салбарын нийтлэг эрх ашгийг хамгаалах;
- Зорилтот бүлгийн нийтлэг эрх ашгийг төлөөлөх, хамгаалах, зорилтот бүлэгтээ үйлчлэх;
- Салбарт ажиллаж байгаа хувийн хэвшлийн нэрийн өмнөөс төрийн байгууллагын бодлого шийдвэрт хувийн хэвшлийн оролцоог бий болгох;
- Иргэдийн эрх ашгийг хамгаалах;

Нөлөөлөл, оролцооны чиг үүрэг – гурав

- Зорилтот бүлэгт хандсан хамтын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож өөрийн байр суурийг илэрхийлэх, төрийн чиг үүргийг гэрээлэн гүйцэтгэж төрийн ачааллыг бууруулж, төвлөрөл, хүнд суртлыг арилгахад оролцох;
- Төр засаг, аж ахуйн нэгжийн бодлого, үйл ажиллагаанд мэргэжлийн дэмжлэг нөлөөллийг хүчтэй үзүүлэх;
- Салбарыг хөгжүүлэх талаар төрийн бодлого, хууль эрх зүйн орчныг сайжруулах талаар үйлдвэрлэгч, эрдэмтэн судлаачдын санал бодлыг уялдуулан нэгтгэж төр засагт хүргэх;

Хөгжүүлэх чиг үүрэг – гурав

- Мэргэжлийн байгууллагуудын ажиллагсдын мэргэжил, мэргэшлийг дээшлүүлэх;
- Тухайн мэргэжлийн чиглэлээр сургалтын хөтөлбөр боловсруулах, сургалт явуулах, сургалтын агуулга, чанарыг үнэлэх, сургалт явуулах байгууллага, мэргэжилтнийг магадлан итгэмжлэх;
- Салбарын тасралтгүй судалгаа шинжилгээ инновацын судалгаа хийх, дүгнэлт гаргах;

²⁴ Draft Concept on the Development of Civil Society in Mongolia https://www.uih.mn/upload/sudalgaa/files/68_8413326.pdf 2024 он 5 сарын 14

Зөвлөх үүрэг - хоёр

- Салбарын хууль дүрэм журам, стандарт боловсруулахад мэргэшсэн болон зөвлөх үйлчилгээ үзүүлэх;
- Тухайн үйл ажиллагаа, зорилтот бүлэгтэй холбоотой асуудлаар зөвлөгөө өгөх, мэргэжлийн дүгнэлт гаргах;

Мэдээлэл, сурталчилгааны чиг үүрэг – гурав

- Салбарын бүх талын мэдээ, мэдээллийн сан бүрдүүлэх, сүлжээ байгуулах;
- Нийгэм, эдийн засагт салбарын үүрэг роль, оролцоог байнга олон нийтэд мэдээлж сурталчлах;
- Үйл ажиллагаа, салбарын эрдэм шинжилгээ, зөвлөгөөн зохион байгуулах, гадаадад төлөөлж оролцох;

Зохион байгуулалтын чиг үүрэг – гурав

- Зорилтот бүлгийн оюуны чадавхыг хөгжүүлэх, үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулах;
- Зорилтот бүлгийн гадаад, дотоод хамтын ажиллагааг зохицуулах, дэмжих;
- Салбарын гаднах макро түвшний бүх асуудлыг шийдвэрлүүлэх, зохицуулах;
- Хяналтын чиг үүрэг – хоёр
- Үйл ажиллагааны чиглэлээр мөрдөгдөж буй стандарт, журмын хэрэгжилтэд хяналт тавих;
- Тухайн үйл ажиллагаа, салбарын чиглэлээр явуулж байгаа төрийн бодлого, үйл ажиллагаанд хяналт тавих зэрэг болно.

Дээрх ИНБ-уудын үйл ажиллагааны чиг үүргийг манай улсад үйл ажиллагаа явуулж буй ИНБ-уудтай харьцуулахад зарим талаараа нийлж байгаа ч, зарим чиг үүрэг огт хэрэгжихгүй байгаа нь харагдана. ИНБ-уудын үйл ажиллагаа нь дийлэнх тохиолдолд зорилтот бүлгийнхээ мэргэжлийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, мэргэжлээрээ хөгжих боломжийг нэмэгдүүлэх, гишүүддээ зориулсан сургалт, семинар, эрдэм шинжилгээний ажлыг зохион байгуулахад чиглэж байгаа бөгөөд судалгаанд хамрагдсан нийт байгууллагын 65 хувь энэ чиглэлийн үйл ажиллагааг голлон явуулахаар дүрэмдээ тусгажээ. Мөн эдгээр ИНБ-ын ихэнх нь зорилтот бүлэг тухайн салбарынхаа хөгжилд хувь нэмэр оруулах, зорилтот бүлэгтээ чиглэсэн төрийн үйл ажиллагааг дэмжихэд голчлон үйл ажиллагаагаа чиглүүлж байна.

Мөн манай улсын ИНБ-ууд хийж болохгүй болон оролцох ёсгүй асуудлынхаа хүрээг дараах байдлаар тодорхойлж саналаа илэрхийлсэн байдаг. Үүнд:

- ИНБ-ууд нь Үндсэн хууль, Төрийн бус байгууллагын тухай хууль болон бусад дүрмийн зорилгодоо нийцээгүй үйл ажиллагаа явуулж болохгүй;
- ИНБ-ууд нь ашгийн төлөө үйл ажиллагаа эрхэлж болохгүй. Өөрөөр хэлбэл ИНБ-ууд нь аж ахуйн шууд ашиг олох зорилгоор ажиллаж болохгүй;
- ИНБ-ууд нь ямар нэг бүлэг, фракцын нөлөөнд автах, ашиг сонирхолд хөтлөгдөхөөс

зайлсхийх нь чухал. Улс төржих (аль нэг нам, эвслийн эрх ашгийг хамгаалах), улс төрийн ямар нэгэн намын эрх ашигт үйлчлэх, аль нэг мөнгөтэй, нөлөөтэй хүний ашиг сонирхолд хөтлөгдөхгүй байх ёстой.

ЭГЭХ ХАРИУЦЛАГА БОЛОН ИЛ ТОД БАЙДАЛ

Монгол Улсад эгэх хариуцлагын талаар ойлголт өгөх, түүнийг хэрэгжүүлэх талаар олон тооны төсөл, судалгаа хэрэгжсэн байна. Ялангуяа үндэсний болон орон нутгийн төрийн байгууллагууд төдийгүй иргэдэд эгэх хариуцлагын талаар өөрсдийн чадавхыг бий болгох талаар сургалтууд орж, эдгээрт дүн шинжилгээ хийсэн талаар судалгаануудад дурджээ. Мөн нийгмийн эгэх хариуцлагын талаар янз бүрийн оролцогч талуудтай ажиллахад хамгийн тулгамдсан хэцүү асуудал бол харилцаа холбоо, хандлага, ойлголтын зөрүүтэй оролцогч талуудтай ажиллах явдал гэдгийг төслийн үр дүнгийн судалгаанууд тодотгожээ.

ИНБ-уудын хувьд иргэд олон нийтийн сайн сайхан аж амьдрал, хөгжлийн төлөө чанартай, шуурхай үйлчилгээ үзүүлэх үүрэг хүлээгээгүй ч, тодорхой асуудлаар санал бодлоо илэрхийлэх, шийдвэр гаргахад оролцох, тодорхой нэг шийдвэр, үйлдлийнх нь төлөө төрийн байгууллага, улс төрчдөд хариуцлага тооцох боломжийг иргэдэд олгодог. Тухайлбал иргэдийн зүгээс эрх барьж байгаа улс төрч, төрийн байгууллагуудын үйл ажиллагаа, нийгмийн үйлчилгээнд гарсан доголдлын талаар бухимдлаа илэрхийлэх, шүүмжлэх, эсэргүүцэн жагсах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр үзэл бодлоо илэрхийлэх зэрэг үйлдэл хийдэг.

Гэвч ИНБ-уудын нийгмийн эгэх хариуцлагын практик нь иргэдийн хувьд дан ганц эсэргүүцэл илэрхийлэхээс татгалзаж, ил тод мэдээлэлтэй, зохион байгуулалттай, төрийн байгууллагуудтай бүтээлчээр харилцах боломж олгож, улмаар зэрэг эерэг өөрчлөлтүүд авчирдаг. Энэ нь төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, улсын төсвийн зарцуулалтыг үр өгөөжтэй болгох, Засгийн газраас амлалтаа хэрэгжүүлэхийг шаардахын тулд иргэд өөрсдөө санаачилга гаргаж зохион байгуулалтад орох, төрийн байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний талаар мэдээлэл, тоо баримт цуглуулах, түүндээ системтэй дүн шинжилгээ хийх, бодит байдлыг баримтжуулан, нотлох замаар хэрэгжүүлдэг нийгмийн хөгжил дэх иргэдийн оролцооны шинэ хандлага юм.

Иргэдийн оролцоо: Зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх чадвар сайтай иргэдийн бүлгүүд, ИНБ-уудын үйл ажиллагаанд иргэдийн оролцоо чухал ач холбогдолтой гэж үздэг шинэчлэлийг дэмжигч хариуцлагатай ИНБ-ууд бий болсноор итгэл, түншлэлд суурилсан ИНБ – зорилтот бүлгийн харилцааны нэг шинэ төрөл бий болсон. Зорилтот бүлгийн оролцоо гэдэг нь иргэдийн бүлгүүд болон ИНБ хоорондоо харилцах, асуудлыг хамтран шийдэхийн тулд холбогдох мэдээлэлд тулгуурладаг, харилцааны үр дүнтэй хэлбэр юм. Эгэх хариуцлагын хувьд зорилтот бүлгийн бүтээлч оролцоо гэдэг нь үйл ажиллагааны цөм болсон олон нийтийн хүчийг ашиглах, аливаа шийдвэр болон гүйцэтгэл дэх иргэдийн хяналтад суурилдаг.

ИНБ-ын үйл ажиллагаанд зорилтот бүлгийн бүтээлч оролцоо нь “ойлголт, харилцаа холбоог нэмэгдүүлэхэд чиглэгдсэн хамтарсан судалгаа”-ны хэлэлцүүлэг болон хамтран мэдээлэл цуглуулах, хэлэлцэх, хувилбаруудыг боловсруулах, асуудлыг системтэй шийдвэрлэх явцыг бий болгодог. Хэлэлцүүлэг хийхэд үр дүнтэй харилцах, мэдээ мэдээлэл боловсруулах, нягтлах, холбогдох хариу хүлээн авах, өгөх зэрэг ур чадвар шаардагддаг. Асуудал шийдвэрлэхийн тулд нөхцөл байдал болон оролцогчдын дүн шинжилгээ хийх, стратеги боловсруулах, ашиг сонирхолд тулгуурлан хэлэлцэх, зөвшилцөлд хүрэх зэрэг дүн шинжилгээний болон шийдвэр гаргах хэрэгслүүд шаардагдана.

Иргэдийн хяналтын ажлыг нарийвчлан төлөвлөж, хэрэгжүүлэх нь нийгмийн эгэх хариуцлагын ажил дахь бүтээлч оролцоог төгс болгоно. Ийм арга хэмжээ нь зорилтот бүлэг олон нийттэй хэлэлцүүлэг хийх, хамтран асуудал шийдвэрлэх, харилцаа холбоогоо сайжруулах, ИНБ – зорилтот бүлгийн бүтээлч хариуцлагыг нэмэгдүүлэхэд иргэдийн бүлгүүдийн гол анхаарлыг хандуулдаг.

ИНБ-ын эгэх хариуцлагыг бүрдүүлэгч:

ИНБ-ын эгэх хариуцлагын орчин бүрдүүлэх 4 тулгуур багана байна. Эдгээр нь “Хариуцлагатай үйл ажиллагаа”, “Мэдээллийн хүртээмж”, “Зохион байгуулалттай, чадваржсан иргэд”, “Нийгэм соёлын тохиромжтой нөхцөл” бөгөөд нийгмийн эгэх хариуцлагыг амжилттай хэрэгжүүлэхэд нөлөөлдөг байна.

1. Хариуцлагатай үйл ажиллагаа гэдэг нь “Иргэдийн оролцооны орон зай, бүтэц систем байна уу?” гэдэг асуултанд хариулагдах үйл ажиллагааг хэлнэ. Нийгмийн эгэх хариуцлагын хүрээнд иргэдийн түншлэлийн таатай орчин гэдэг нь иргэд, иргэдийн бүлгийн төр, засагтай тогтвортой, үр нөлөөтэй түншлэх чадавхид нөлөөлж буй харилцан хамаарал бүхий хүчин зүйлс буюу цогц нөхцлийг хэлнэ. Энэ нь хүний эрхийг хамгаалах, нийгмийн халамжийн үйлчилгээг сайжруулах, ИНБ-ын үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэхэд чиглэсэн төрийн албан хаагчийн үйл ажиллагааныхаа төлөө хариуцан тайлагнах асуудалтай холбоотой.
2. Мэдээллийн хүртээмж гэдэг нь “Хэрэгцээтэй мэдээлэл байна уу? Хэр ашигтай байна? Мэдээлэл иргэдэд нээлттэй, хүртээмжтэй байна уу?” гэдэг асуултанд хариулагдах ба нийгмийн эгэх хариуцлагыг бий болгоход ИНБ-ын үйл ажиллагааны тайлан, дүрэм журам зэрэг баримт бичиг, мэдээллийн нээлттэй, найдвартай байдал чухал суурь болдог. Мэдээлэл нь нийгмийн эгэх хариуцлагын үндэс бөгөөд мэдээллийн чанар, хүртээмж нь эгэх хариуцлагын механизмыг амжилттай болгох гол түлхүүр юм. Мэдээлэл хүртэх боломж гэдгийг зорилтот бүлэг төдийгүй сонирхогч этгээд баримт бичигтэй танилцах бодит боломж, тухайн баримт бичгийн ойлгомжтой байдал гэсэн хоёр утгаар ойлгоно.
3. Зохион байгуулалттай, чадваржсан иргэд гэдэг нь “Үзэл бодлоо илэрхийлэх, хяналт хийх чадвар бүхий зохион байгуулалттай иргэд байна уу?” гэдэг асуултанд хариулагдах ба иргэд олон нийтийн чадавхи нь нийгмийн эгэх хариуцлага амжилттай хэрэгжих үндсэн хүчин зүйл юм. Зорилтот бүлгийн чадавхийн түвшин,

гишүүнчлэлийн хүрээ, төлөөлөх чадвар болон хүлээн зөвшөөрөгдсөн байдал, гишүүдийнхээ өмнө хариуцан тайлагнах болон хариуцлага хүлээх чадварын түвшин, арга зүй болон нөлөөллийн үйл ажиллагаа явуулах ур чадвар, хэвлэл мэдээллийн хэрэгслийг үр нөлөөтэйгөөр ашиглах чадвар зэрэг нь нийгмийн хариуцлагын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэх гол цөм нь болдог.

4. Нийгэм соёлын тохиромжтой нөхцөл гэдэг нь “Нийгэм, соёлын ямар хүчин зүйл нийгмийн эгэх хариуцлагыг хөгжүүлж эсвэл саад болж байна вэ?” гэдэг асуултанд хариулагдах ба эгэх хариуцлагын гол параметр нь улс төрийн агуулга болон соёлоор тодорхойлогддог. Нийгмийн эгэх хариуцлагын санаачилгууд амжилттай хэрэгжих нь улс төрийн дэглэмийн хувьд ардчилсан, олон намын системтэй байх эсэх, улс төрийн болон иргэний эрхүүд нь (мэдээлэл авах, үг хэлэх, эвлэлдэн нэгдэх эрх) хамгаалагдсан эсэх болон улс төрийн соёлоос (шударга, ил тод байдал) хамаарч байдаг.

ЭГЭХ ХАРИУЦЛАГЫН АЧ ХОЛБОГДОЛ:

Иргэдийн итгэл сайжрах:

ИНБ-уудад итгэх иргэдийн итгэл суларсан нь байгууллагын өөрийнх нь дотоод хяналтын систем доголдолтой, хязгаарлагдмал байдалтай холбоотойг ИНБ-уудын судалгаанууд олонтой дурджээ. Эгэх хариуцлага тооцох уламжлалт, суурь механизм болох сонгууль ч сул арга болох нь ажиглагдаж байна. Харин сонгууль хооронд иргэд хариуцлага тооцох боломжийг нийгмийн хариуцлагын аргууд олгодог. Тиймээс нийгмийн эгэх хариуцлагын гол зорилт нь ИНБ-уудын үйлчилгээг үр ашигтайгаар олон нийтэд танилуулах, үйл ажиллагааг түлхүү хөгжүүлэхэд зориулагдсан байна. Эгэх хариуцлагын тогтолцоог бүрдүүлэхэд чиглэсэн ажлын гол үндэс нь мэдээлэл бөгөөд иргэдэд тоо баримтанд дүн шинжилгээ хийх, тэдгээрийг системтэйгээр ашиглаж, үйл ажиллагаанд оролцох боломж өгдөг.

Үйл ажиллагааны үр ашиг нэмэгдэх


ИНБ-ын үйл ажиллагааг сайжруулж, илүү үр өгөөжтэйгээр зорилтот бүлэгт хүргэх замаар үр дүнд хүрдэг. Олон оронд, ИНБ-уудын үйл ажиллагааны хүртээмж нэмэгдэхгүй байх гол шалтгаан нь үйлчилгээнд оролцогч талууд болох үйл ажиллагаа боловсруулах, үйлчилгээ үзүүлэх, үйлчилгээ хүртэгчдийн сонирхол өөр хоорондоо зөрүүтэй, мэдээллийн хомсдол, хоорондын харилцаа холбоо сул байдагтай холбоотой. Нийгмийн эгэх хариуцлагын арга механизмууд нь мэдээллийг хүртээмжтэй болгох, иргэдийн дуу хоолойг хүчтэй болгож, талуудын харилцан зөвшилцлийн механизмыг бий болгож, үр ашигтай ажиллах сонирхол төрүүлдэгээрээ ИНБ-ын үйл ажиллагаа, үйлчилгээний үр ашгийг сайжруулж, шийдвэрийг ил тод, оролцоотой болгоход чиглүүлдэг.

Иргэд олон нийтийг чадваржуулах

Иргэд ИНБ-ын үйл ажиллагаа, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид сэтгэл хангалуун бус байх нь ИНБ нь хариуцлага хүлээдэггүй, иргэдийн санал, эрэлт хэрэгцээнд нь хариу арга хэмжээ авдаггүйгээс үүдэлтэй. Эгэх хариуцлагын

механизмууд нь иргэдийн эрхийн талаар тодорхой мэдээлэл өгөх, иргэдийн санаа бодлыг тогтмол сонсох боломж олгодог учраас эрх нь зөрчигдсөн зорилтот бүлэг болон эмзэг бүлгийнхний дуу хоолойг хүчирхэгжүүлж, тэдний санаа бодлыг төр, засгийн бодлого шийдвэрт тусгах боломж олгодог. Энэ нь иргэдийг чадавхижуулах ба тэдний эрэлт хэрэгцээнд нийцсэн хариу арга хэмжээг төрийн зүгээс авах боломж өгдөг. Иймд иргэд, ялангуяа эмзэг бүлгийнхэн, зорилтот бүлгийн эгэх хариуцлагыг шаардах хүсэл санаачлагыг дэмжиж, тэдэнд тохирсон нийгмийн хариуцлагын арга механизмыг боловсруулах нь үр ашигтай, иргэдэд чиглэсэн нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэх гол хүчин чармайлт юм.

Хариуцлагын тогтолцооны өөрчлөлт:



ИЛ ТОД БАЙДЛЫН АЧ ХОЛБОГДОЛ:

Ардчилсан олон улс оронд иргэдийн мэдээлэл авах эрхийг хангахад баримталж буй гол зарчим нь төрийн байгууллага төдийгүй олон нийтийн төлөө үйл ажиллагаа явуулдаг ИНБ-ууд үйл ажиллагааныхаа явцад цуглуулж хуримтлуулсан, боловсруулсан мэдээллийг нийтийн хөрөнгө гэж үзэн иргэдэд дээд зэргээр ил тод хүргэх учиртай гэж үздэг. Ил тод байдал ба хариуцлагын тухай зарчмууд нь хууль бус санхүү, зүй бус аргаар олж авсан мэдээлэл, эрх мэдлийг урвуугаар ашиглахаас сэргийлэх ач холбогдолтой. ИНБ-уудаас илүү өөрт тохирсон мэдээ мэдээлэл, үйлчилгээ авах нь төрийн байгууллагын шийдвэр болон үйлчилгээнд хяналт тавих, тэдгээрийн зохистой байдлыг шаардахад шууд болон шууд бус нөлөө ихээхэн үзүүлдэг. Төр төдийгүй ИНБ-аас мэдээлэл авах иргэний энэхүү эрхийг зарим тохиолдолд “мэдэх эрх” хэмээн нэрлэдэг. Энэ бол Монгол Улсын иргэдэд Үндсэн хуулиар олгосон суурь эрх билээ.

Мэдээлэл муутай иргэд нотлох баримтгүйгээр, асуудалд өөрсдийн үзэмжээр ханддаг. Харин мэдээлэлтэй иргэд асуудалд ул суурьтай хандаж чадна. Иргэд тэнцвэртэй мэдээлэлтэй, оролцоо сайтай байх нь тэдэнд:

- Авлига, эрх мэдлийг зүй бусаар ашиглах үйлдлээс сэргийлэх;
- Өөрсдийн амьдралын асуудлаар шийдвэр гаргах чадвартай байх;

- Хувь хүний эрхээ эдлэх;
- Өөрийн болон гэр бүлийн гишүүдийнхээ сэтгэлд нийцсэн үйлчилгээг төр төдийгүй бусад нөлөө бүхий албан газраас шаардах;
- Хувь хүн ба нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулах ашиг тустай.

ИНБ-уудын мэдээллийн ил тод байдал нь дээр тэмдэглэснээр олон төрлийн давуу талтай. Гэвч нэн тэргүүнд, тухайн нийгэм, зорилтот бүлэгт тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхийн тулд иргэд ИНБ-ын ил тод мэдээллийг ашиглах замаар төрийн эрх мэдэлтэнтэй хамтран ажиллан, бодлогын өөрчлөлт шинэчлэлд оролцох “Бодлогын нөлөөлөл”-ийн давуу талыг энд дурдъя.

ИНБ-ын үйл ажиллагаа, үйлчилгээ, баримт бичиг зэрэг мэдээ мэдээлэл нь ихэнх тохиолдолд тухайн орон нутгийн иргэдийн өмнө тулгарч буй асуудлыг шийдвэрлэхэд чиглэдэг. Асуудлыг шийдвэрлэхэд тусалж чадах бодлого боловсруулагчидтай амжилтай хамтран ажиллахын тулд иргэд ИНБ-ын ил тод мэдээллийг ашиглах замаар бодлогын нөлөөллийн ажилд оролцох нь чухал. Бодлогын нөлөөлөл нь олон нийтийн анхаарлыг тодорхой чухал асуудал руу хандуулдаг. Бодлогын нөлөөлөл нь олон нийтийн эрх ашгийн төлөө бодлогын шийдвэр гаргуулахын тулд бодлого боловсруулагчдад нөлөөлөх процесс юм. Энэ бол ИНБ, хувь хүн, байгууллагуудтай хамтран ажиллаж тухайн орон нутагт өөрчлөлт авчрах тухай юм.

Бодлогод нөлөөлөх ИНБ-ын мэдээлэл нь хэд хэдэн үе шатаас бүрэлдэх ба эдгээр нь “Бодлогод нөлөөлөх гэж буй асуудлаа тодорхойлох”, “Нөлөөллийн ажлын зорилго, зорилтоо тодорхойлох”, “ИНБ нь шийдвэрлэхээр зорьж буй асуудалд нөлөөлөх эрх мэдлийн зураглал дүн шинжилгээ хийн, нөлөөллийн дараах бодлогын шинэчлэлээс хэн ашиг хүртэх, эсвэл хэн алдах талаар тодорхойлох”, “Нөлөөллийн харилцааны стратеги боловсруулах” юм.

Бодлогод нөлөөлөх гэж буй асуудлаа тодорхойлох гэдэг нь юуны өмнө тухайн ИНБ нь шийдвэрлэхээр төлөвлөж буй, шийдвэрлэхэд тулгамдаж буй асуудлуудын жагсаалт гаргаж, уг жагсаалтаас хамгийн чухал гурван асуудлыг сонгоно. Бодлогын нөлөөлөлд зайлшгүй шаардлагатай асуудлыг тодорхойлохын тулд доорх асуултуудад хариулах хэрэгтэй:

- Яагаад энэ асуудлыг чухал гэж үзэв? Энэ асуудал хэдэн хүнд (их олон эсвэл цөөн хүнд) нөлөөлж байна вэ? Энэ нь хэр ноцтой асуудал вэ?
- Асуудлыг засаж сайжруулахад бодлогын ямар шийдэл хэрэгтэй вэ?
- Энэ асуудлыг шийдэхийн тулд иргэд олон нийтээс дэмжлэг авах нь хялбар уу эсвэл хүндрэлтэй юу?

Нөлөөллийн ажлын зорилго, зорилтоо тодорхойлох гэдэг нь ИНБ-ын ил тод мэдээлэл нь цаашдын үйл ажиллагаанд хүрэхийг хүсэж буй урт хугацаанд үр дүн

авчрах өөрчлөлт юм. Ихэнх тохиолдолд асуудлыг дунд хугацаанд буюу 1-3 жилийн хугацаанд шийдвэрлэх зорилго тавьдаг. Харин зорилт бол урт хугацаанд үр дүн нь гарах зорилгодоо хүрэхийн тулд хэрэгжүүлэх шаардлагатай алхмууд юм. Нөлөөллийн зорилтын хувьд нэг жил орчим хугацааны дотор үр дүн нь харагдах ёстой. Нөлөөллийн зорилго нь тодорхой, хэмжигдэхүйц, хүрч болохуйц, бодитой, тодорхой хугацаатай байх шаардлагатай. Мөн зарим үед зорилгодоо хүрснээр гарах өөрчлөлтийг хэмжих шаардлагатай байдаг.

ИНБ нь шийдвэрлэхээр зорьж буй асуудалд нөлөөлөх эрх мэдлийн зураглал дүн шинжилгээ хийн, нөлөөллийн дараах бодлогын шинэчлэлээс хэн ашиг хүртэх, эсвэл хэн алдах талаар тодорхойлох нь чухал байдаг. Бодлогын нөлөөлөл хийх зорилтот бүлгүүдийг тодорхойлох шаардлагатай ба хоёр ангилан үзэж болно. Үүнд:

- Анхдагч зорилтот бүлэг: Тодорхой асуудлаар эсвэл тухайн ИНБ-тай холбоотой асуудлаар шийдвэр гаргах эрх мэдэл бүхий этгээд
- Хоёрдогч зорилтот бүлэг: Анхдагч зорилтот бүлэгт нөлөө үзүүлж чадах хувь хүн, байгууллага

Энэ нь анхдагч ба хоёрдогч бүлгүүдийг тодорхойлох зорилгоор ИНБ-ууд төрөл бүрийн мэдээлэл, түүний зураглалыг гаргах хэрэгтэй. Ингэхдээ ИНБ-ынхаа үзэл бодол, байр суурийг тань дэмждэг болон эсэргүүцдэг бүлгүүдийн тухай илүү мэдэх хэрэгтэй. Үүний дараа ИНБ-ынхаа байр суурийг дэмждэг бүлгийг эсвэл эсэргүүцдэг бүлэгт бас илүү анхаарах уу эсвэл төвийг сахигч бүлгийн анхаарлыг татах уу гэдэг асуудал гарах ба тухайн бүлэг тус бүрд хандсан мэдээллийг ил тод болгох хэрэгтэй. Зорилтот бүлгүүдийг тодорхойлсны дараа тэднээс ирэх дэмжлэг, эсэргүүцлийн тухайд дүн шинжилгээ хийх нь чухал. Нөлөөлөл хийхийн тулд олон нийтэд өгөх мессеж, зорилтот бүлэгт ашиглах нөлөөллийн стратегийг тодорхойлох нь чухал. Зорилтот бүлгээс хэдий чинээ их дэмжлэг авна, зорилгодоо хүрэх магадлал төдий чинээ нэмэгдэнэ. Зарим тохиолдолд шийдвэрээ хараахан гаргаагүй байгаа төвийг сахигч бүлгүүдэд анхаарал хандуулах нь чухал. Зорилтот бүлэгтэй холбоотой мэдээлэл байнга цуглуулж байх хэрэгтэй. Зорилтот бүлгийн талаар цуглуулсан мэдээлэл нь нөлөөллийн стратеги ба нөлөөллийн мессежээ боловсруулахад чухал ач тустай.

Мэдээллийг ил тод болгосноор нөлөөллийн харилцааны стратеги боловсруулах гэдэг нь бодлогын нөлөөллийн зорилго, зорилтоо тодорхойлж, ИНБ-ынхаа үзэл бодол, байр суурийг дэмжигч эсвэл эсэргүүцдэг бүлгийг тодорхойлсны дараа олон нийттэй харилцах стратегийг боловсруулах нь дараагийн алхам юм. ИНБ-ууд 3 түвшинд иргэдтэй харилцах боломжтой. Юуны өмнө иргэдэд нөлөөлөх асуудлын тухай, асуудлын үр нөлөө, боломжит шийдлийн тухай мэдээлэл өгөх нь чухал. Үүний дараа өөрийн байр суурь, гарах шийдвэрийг илэрхийлсэн мэдээ мэдээллийг хүргэн, дэмжих талаар тэднийг ятгах нь чухал юм. Тухайн ИНБ-ын үзэл бодол, байр суурийг дэмжиж эхэлсэн бол таныг дэмжигчид үйл ажиллагаа явуулах гурав дахь буюу сүүлийн

шат руугаа орно. Зорилтот бүлгийг үйл ажиллагаа руу чиглүүлэхийн тулд өөрийн дэмжигчдийн хүрээг тэлэх шаардлагатай. Үүний тулд мэдээллийн ил тод идэвхтэй байдал нь чухал юм.

Иргэд ИНБ-ын ил тод мэдээллийг ашиглах замаар бодлого боловсруулагчидтай амжилтай хамтран ажиллахын тулд бодлогын нөлөөллийн ажилд оролцох боломжтой. Үүнд дараагийн алхам нь гол шийдвэр гаргагчидтай ажиллах юм.

ИНБ-ууд өөрсдийн хийх гэж буй бодлогын шинэчлэлийг хэн дэмжиж, хэн эсэргүүцэж байгааг мэддэг болон тэдэнтэй харилцах стратегийг тодорхойлж, өргөн хүрээнд дэмжлэг авах зорилгоор дараагийн алхмын үйл ажиллагааг явуулах болно. Бодлогын нөлөөллийн асуудлыг шийдэх зорилгоор бодлогын шинэчлэл хэрэгжүүлэхийн тулд бодлого боловсруулагчдад зөв мэдээлэл өгөх шаардлагатай болно. Эдгээрт нь дараах аргууд орно:

- Шийдвэрлэх гэж буй асуудалд хяналт тавих сум, дүүрэг, баг, хорооны эрх мэдэл бүхий хүмүүстэй уулзан, мэдээлэл өгөн, өөрсдийн байгууллагын байр суурийг танилцуулна. Дээрх хэсэгт өгүүлснээр асуудлыг шийдэх эрх мэдэл бүхий төрийн албан хаагчийг мэдэх нь чухал. Жишээ нь хэрэв нөлөөллийн асуудал нь хог хаягдлын асуудал бол сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга эсвэл Засаг даргатай уулзах хэрэгтэй. Хэрэв сургуультай холбоотой асуудлыг шийдэх хэрэгтэй бол боловсрол хариуцсан дээд удирдлагад мэдээлэл өгөх нь чухал болно.

Аливаа бодлогын өөрчлөлт нь зарим хүмүүст ашигтай боловч зарим хүмүүсийн ашиг сонирхлын эсрэг байдгийг мэдэх нь чухал. Бодлогын нөлөөллийн ажлыг амжилттай хийхийн тулд өмнө дурьдсан алхмуудыг хэд хэдэн удаа давтан хийн, оновчтой мэдээллийг ил тод болгох нь чухал юм.

Албан тушаалтнууд, шийдвэр гаргагчид асуудлыг нэн даруй шийдэхийг хүсэхгүй бол бусад бүлэг, бусад ИНБ-уудад энэ тухай мэдээлэх, байгууллагынхаа байр суурийг дэмжихийг уриалах, мэдээлэл харилцааны стратегийг сайжруулахыг оролдох хэрэгтэй.

3. ӨНӨӨГИЙН БАЙДЛЫГ ТОДОРХОЙЛОХ НЬ:

АРГА ЗҮЙ БОЛОН ҮНЭЛГЭЭНИЙ ХҮРЭЭ

Тус судалгаа нь Монгол Улсын ИНБ-уудын эгэх хариуцлага болон ил тод байдал, мэдээлэл харилцааны төлөвийг тодорхойлж, өнөөгийн нөхцөл байдал, тулгамдсан асуудал гол сорилт, боломжуудад дүн шинжилгээ хийж, тэдгээрийн чадавхийг үнэлэх зорилготой ба үүнд чанарын болон тоон аргыг ашигласан. Мэдээлэл цуглуулалтад баримт бичгийн шинжилгээ, асуумж судалгаа, ганцаарчилсан ярилцлага (ГЯ) зэрэг тоон болон чанарын аргуудаас бүрдсэн холимог аргыг хэрэглэв.


Тоон мэдээлэл цуглуулалт ба түүврийн хэмжээ

Тоон мэдээллийг компьютерын тусламжтайгаар болон биечлэн мэдээлэл цуглуулах аргуудыг ашиглан цуглуулсан ба мэдээлэл цуглуулалтад нийт 124 ИНБ-ын төлөөлөл судалгаанд хамрагдсан.

ҮСХ-ны 2022 оны статистик мэдээллээр Монгол Улсад нийт 7405 ИНБ идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Бүртгэлтэй ИНБ-уудын тоо хэдий олон ч тогтмол, системтэй үйл ажиллагаа явуулдаг ИНБ нь харьцангуй цөөн байна. Санхүүгийн боломж, хүний нөөцийн тогтвортой байдал болон удирдлагын чадавхи зэрэг нь ИНБ-ын оршин тогтнох болон амжилттай ажиллахад гол нөлөө үзүүлдэг. ИНБ-уудын 70 гаруй хувь нь нийслэл хотод, үлдсэн хувь нь орон нутагт бүртгэлтэй. Орон нутагт ажилладаг ИНБ-уудын тоо болон чадавхи жилээс жилд өсөн нэмэгдэж байна. Иймд тус судалгаанд байгуулагдсан цагаас хойш тогтвортой үйл ажиллагаа явуулсан огноо нь төрөл бүр байх ИНБ-уудыг хамруулахыг зорьсон юм. Мөн Улаанбаатар хотод төдийгүй орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ИНБ-уудыг тэгш тоогоор хамрууллаа.

Үйл ажиллагааны чиглэлийн хувьд “Өөр бусад” гэдэг хувилбарыг сонгогсод “Гэр бүл, эмэгтэйчүүд, аавуудад, хөдөөгийн малчин залуучуудад болон малчин эрэгтэйчүүдэд, хөдөлмөрийн харилцаанд ороход хүндрэлтэй иргэд болон ажилгүйчүүд, ахлах ангийн сургачдад, ХДХВ-ын залуу зорилтот бүлэг болон ЛГБТИК+ залуучууд, эрүүл мэндийн чиглэлээр” гэх мэтээр үйл ажиллагаагаа чиглүүлдэг нийгмийн бүлгүүд байна.


Хүснэгт 1. ИНБ-ын идэвхтэй үйл ажиллагаа явуулсан хугацаа (жилээр)




Хүснэгт 2. Түүврийн хэмжээ, газар зүйн байршлаар



Хүснэгт 3. Түүврийн хэмжээ, газар зүйн байршлаар



Хүснэгт 4. Түүврийн хэмжээ, үйл ажиллагааны төрлөөр



Чанарын мэдээлэл цуглуулалт ба түүврийн хэмжээ

Чанарын мэдээлэл цуглуулалтад баримт бичгийн судалгаа, ИНБ болон хэвлэл мэдээллийн байгууллагын гол оролцогч талуудтай хийсэн ярилцлага болон тэдгээртэй хийсэн ганцаарчилсан ярилцлага (ГЯ) хамаарна. Ярилцлагыг Улаанбаатар хот төдийгүй орон нутагт үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудыг хамруулан зохион байгуулсан бөгөөд нийт 20 оролцогч талуудтай ярилцлага хийсэн байна.

2010 оноос хойш Монголын иргэний нийгмийн талаар хэд хэдэн судалгаа хийгдсэн. Иймд бид иргэний нийгмийн чиглэлээр хийгдсэн нэн чухал судалгаануудыг баримт бичгийн шинжилгээнд ашигласан бөгөөд энэхүү үнэлгээ нь иргэний нийгмийн талаарх сүүлийн үеийн судалгаануудад тулгуурласан ба энэ нь бидний анхдагч өгөгдөлд үнэ цэн нэмж өгсөн юм.

МЭДЭЭЛЭЛ ХАРИЛЦААНЫ СУВГУУД

Судалгааны энэ хэсэгт ИНБ-уудын мэдээлэл харилцааны өнөөгийн төлөв байдлын дүн шинжилгээний анхдагч болон хоёрдогч судалгааны үр дүнг танилцуулж байна. Тодруулбал, Монгол Улс дахь ИНБ-ын мэдээлэл харилцааны онцлог, түүнд тулгамдаж буй асуудал, зохицуулалтын орчин зэргийг бусад улсын ИНБ-уудтай харьцуулан тэдгээрийн үйл ажиллагаанд нөлөөлөх хүчин зүйлүүд, цаашдын хэрэгцээ, орчны болон үр дүнгийн давуу, сул талуудыг тодорхойлохыг зорив.

Мэдээлэл харилцааны сувгийг хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй холбон ойлгож болох ба хэвлэл мэдээлэл нь ухагдахууныхаа хувьд хувь хүний бусадтайгаа холбогдох, даган дуурайх, нэгдэх, өргөн утгаараа ижилсэл ондоошлыг бий болгох олон нийтийн харилцааг тогтоож ирсэн. Технологийн тайлбар толинд “Хэвлэл мэдээлэл нь хэвлэмэл цааснаас дижитал өгөгдөл хүртэлх бүх зүйл багтаж болох бөгөөд өгөгдөл мэдээллийг цуглуулах, дамжуулах, хадгалах, сэргээх, төрөл бүрийн хэлбэрээр дүрслэх, түгээх үйл ажиллагаа буюу тэдгээр процессын нэгдэл” хэмээн тэмдэглэжээ. Өөрөөр хэлбэл мэдээлэл хайх, цуглуулах, боловсруулах, нийтлэх, нэвтрүүлэх үйл ажиллагаа эрхэлдэг сонин, сэтгүүл, радио, телевиз, мэдээллийн сайт зэрэг цахим хэвлэлийг тус тодорхойлтод хамруулж болох юм. Манай улсын хууль эрх зүйн хувьд “Зар сурталчилгааны тухай” хуулийн 3 дугаар бүлэгт 3.1.5 дахь хэсэгт “Мэдээлэл хэрэгсэл” гэж телевиз, радио, холбооны шугам сүлжээ, компьютерын сүлжээ, тусгай программ, хэвлэл болон бусад арга хэрэгсэл” гэсэн утгаар ойлгоно гэжээ.

ИНБ-ууд дээрх мэдээлэл харилцааны арга, сувгуудыг ашиглан зорилтот бүлэгт үйл ажиллагаа, өөрсдийн үйлчилгээг оновчтой, хүртээмжтэй хүргэх нь чухал юм. Зорилтот бүлэгтээ хандсан мэдээлэл түгээх нь иргэдийн идэвхтэй оролцоог дэмжих,

²⁵ Бенедикт Андерсон 1983 онд “төсөөллийн бүлэглэл” гэдэг нэр томъёог хэрэглэн, үндэсний ижилсэл болон хэвлэл мэдээллийн нөлөөг судалсан.

Anderson, B. (1983). *Imagined communities: Reflections on the origin and spread of nationalism*. Verso books.

²⁶ <https://www.techopedia.com/definition/1098/media> Хандсан огноо: 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдөр

²⁷ 2002 оны 5 дугаар сарын 30-ны өдөр баталсан.

²⁸ Edwards, V. L. (2013). A theory of participation for 21st century governance. *International Journal of Organization Theory & Behavior*.


түүгээр дамжуулан аливаа асуудлаар хэлэлцүүлэг яриа өрнүүлэх, асуудлыг нээх, зохистой шийдвэр гаргахад нөлөөлөх боломжтой. ИНБ-ууд ч мэдээлэл түгээхийн давуу тал, түүний хэрэгцээ шаардлагын талаар олонтой дурдаж буй бөгөөд судалгаанд оролцсон нийт байгууллагын 61 хувь нь “зайлшгүй хэрэгцээтэй, үүнгүйгээр яагаад ч явахгүй” хэмээн хариулжээ.

Зорилтот бүлэгтээ хандсан мэдээлэл түгээх хэрэгцээ шаардлагын талаар



Харин охид эмэгтэйчүүдийн нийгмийн асуудал, хүчирхийллийн эсрэг үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд төвөгтэй ч хийхээс өөр аргагүй хэмээн ихэнх нь хариулжээ. Эмэгтэйчүүдийн нийгмийн асуудал, хүчирхийллийн эсрэг үйл ажиллагаа явуулдаг ИНБ-уудын төлөөлөл “Хэвлэл мэдээллээс хол байх, бүх талын мэдээллийг чандлан нууцлах нь хохирогч эмэгтэйчүүдийг хамгаалах үүрэг гэж боддог тул зорилтот бүлэгтээ мэдээлэл хүргэхэд хэвлэл мэдээллийн хэрэгслийг сонгох нь төвөгтэй байдаг” гэжээ.

ИНБ-ууд зорилтот бүлэгтээ ямар төрлийн мэдээлэл хүргэдэг талаар 60-аас дээш хувь нь “Зорилтот бүлгийг мэдлэгжүүлэх, чадавхжуулах мэдээлэл”, “Байгууллагын үйл ажиллагааны тухай сүүлийн үеийн мэдээлэл” хэмээн хариулсан байна. Гэвч “Зорилтот бүлгийг мэдлэгжүүлэх, чадавхжуулах мэдээлэл”-ээс илүү “Байгууллагын үйл ажиллагааны тухай сүүлийн үеийн мэдээлэл”-ийг түлхүү хүргэж байгаа нь өмнөх бүлэгт дурдсан мэдээлэл харилцааны хоёр урсгалт тэгш харилцааны загварын дагуу бус буйг харуулж байна. Өөрөөр хэлбэл ИНБ-ууд цаашдаа зорилтот бүлэгт тохирсон мэдээ, мэдээллийг түлхүү хүргэх хэрэгцээ шаардлага байна.




Зорилтот бүлэгтээ хүргэх мэдээллийн хувьд “Өөр бусад” гэдэг хувилбарыг сонгогсод “Хүний эрхийн компанит ажлуудын, гэр бүл, архидалт, гэр бүлийн хүчирхийллийн, ганцаарчилсан болон бүлэг иргэдэд эрх зүйн анхан шатны зөвлөгөө өгөх, төрд нөлөөллийн ажил хийх, хөндлөнгийн үнэлгээ судалгааны дүн, иргэдэд ойлгуулах ёстой шинжлэх ухааны үндэслэлийн талаар” гэх мэтээр зорилтод бүлэгтээ түгээдэг мэдээллийн төрлүүдийг дурджээ.




Мөн судалгаанаас харахад ИНБ-ууд зорилтот бүлэгтэйгээ мэдээлэл солилцохын тулд “Хамтарсан уулзалт, хэлэлцүүлэг”, “Мэдэгдэл, уриалга гаргах”, “Үзэсгэлэн”, “Өдөрлөг” зэргийг түлхүү зохион байгуулж байна. “Жагсаал”, “Цуглаан” зэргийг зохион байгуулдаггүй, зохион байгуулахаас татгалзаж байгаа талаар ганцаарчилсан ярилцлагын оролцогч “Жагсаал, цуглаан нь хууль эрх зүйн орчны хувьд ч зарим зүйл нь ИНБ-ын нэр хүндийг унагах зорилготой. Тэр дундаа олон нийтийн сүлжээгээр зөвхөн ИНБ-ууд руу чиглэсэн халдлагын нийтлэг хэлбэрүүд ажиглагдаж байна. Сүүлийн жилүүдэд ИНБ-ууд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж чадахгүй байна. Зорилтот бүлэгтээ мэдээлэл түгээхэд ч хүндрэлтэй асуудлууд их, цуглаан хийж зорилтот бүлгийн анхаарлыг татах, тэдэнд мэдээлэл өгөх хэрэгцээ байдаг ч, тэр боломжуудыг төрийн зүгээс хаасан хэд хэдэн тохиолдол байна. Мөн төрийн бодлогын шийдвэр гаргах түвшинд ИНБ-уудыг оролцох боломжийг нээж өгсөн эрх зүйн зохицуулалт 2015 оноос эхэлж 2016, 2017 онуудад хэрэгжиж эхэлсэн ч хумигдах хандлагатай байгаа зэрэг хууль эрх зүйн орчинд хүндрэлтэй байна” гэж хариулжээ. Мөн жагсаал цуглаан хийх нь үр өгөөжтэй арга хэрэгсэл биш гэх байр суурьтай ИНБ-уудын төлөөлөл нь “бид өмнө нэг жижиг жагсаал хийж байсан юм. Түүн дээр олон хэвлэл мэдээллийн хэрэгслүүд ирсэн. Эргээд нийтлэгдсэн мэдээллүүдийг судлахад өнцгүүдийн хувьд асар зөрөөтэй. Тухайн редакц бүрийн гаргасан мэдээлэл нь үйл явдлын үндсэн асуудлыг хөндөж чадсан байна уу гэдэг нь харилцан адилгүй байсан. Мөн хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй харилцан ойлголцоход тэдний ажлын онцлогоос шалтгаалаад бэрхшээлтэй байдаг. Ор үндэсгүй мэдээлэл гарсан ч тохиолдол бий” зэрэг хариулсан байна.

Зорилтот бүлэгтэйгээ харилцах, мэдээлэл солилцохын тулд зохион байгуулдаг арга хэмжээний талаар



Сүүлийн жилүүдэд интернэтийн хэрэглээ нь ИНБ-уудын мэдээлэл харилцааны салшгүй чухал хэрэгсэл болжээ. 2010 оны эхэн үеэс нийгмийн сүлжээний вебсайтууд (SNS)-ыг өргөнөөр хэрэглэж, өөрсдийн пэйж хуудас болон группуудыг идэвхжүүлэн, мэдээ мэдээллийг хүргэх болсон. “Датаком” компани 1996 оны 1 дүгээр сарын 17-ны өдөр Манай улсад интернэт нэвтэрснийг албан ёсоор зарласан билээ. Монголын мэдээллийн технологийн анхдугаар чуулганыг 1999 онд зохион байгуулан Монголын мэдээлэл холбооны технологийн хөгжлийн 2010 он хүртэлх үзэл баримтлалыг боловсруулснаар улсын хөгжлийн стратегийн хүрээнд мэдээлэл, харилцаа холбооны технологи нь манай орны хөгжлийн тулгуур хүчин зүйлсийн нэг болохыг тогтоосон билээ. Мэдээллийн технологи нь зөвхөн компьютер, программ хангамж, тоон технологи, интернэтийн сүлжээ төдийгүй сонин, сэтгүүлийн эх бэлтгэх, хэвлэлийн технологийн шинэчлэл, радио, телевизийн дүрс дууг бичих, эвлүүлэх дамжуулах арга зэргийг хамарсан өргөн хүрээтэй ойлголт юм.



Судалгаанд хамрагдсан ИНБ-уудын 95 хувь нь мэдээлэл түгээх сувгуудаас “Фэйсбүүк”-ийг түлхүү ашигладаг гэж хариулжээ. “Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд зориулж бэлдсэн хэвлэлийн мэдээг” 50 орчим хувь нь ашигладаг бол 28 хувь нь “өөрсдийн вебсайтыг” мэдээлэл түгээхэд түлхүү ашигладаг гэжээ. Өөрийн вебсайтай ИНБ-ын 80 хувь нь арваас дээш жил үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагууд байна. Өөрөөр хэлбэл идэвхтэй үйл ажиллагаа болон санхүүгийн тогтвортой байдалтай ИНБ-ууд өөрийн вебсайтыг тогтмол хөтөлж байна.

Мөн хүүхэд, залуучуудын бүлэгт зориулан үйл ажиллагаа явуулдаг ИНБ-ууд мэдээлэл түгээхдээ “Тик ток” ихэвчлэн ашигладаг бол “Youtube”, “Instagram” зэргийг сурч боловсрох эрх, их, дээд сургуульд суралцагчдад чиглэсэн олон талт үйл ажиллагаа, сургууль болон суралцагчтай харилцах зэргээр боловсролын салбарын бодлогын нөлөөлөл хийдэг ИНБ-ууд түлхүү ашиглаж байгаа нь харагдана. Харин орон нутагт үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд “Ихэвчлэн утсаар болон биечлэн уулздаг”, “Өөрөө биечлэн болон утсаар мэдээлэл өгдөг” мөн “Орон нутгийн телевизэд ханддаг” зэргээр хариулсан байна.

Энэ мэт ИНБ-ууд олон янзын хэлбэрээр олон төрлийн суваг ашиглан иргэд, олон нийт болон зорилтот бүлэгтэйгээ харилцаж байгаа ч, мэдээлэл харилцааны сувгуудын үр өгөөжийг “хангалтгүй” хэмээн үнэлжээ. Тухайлбал олон нийт/зорилтот бүлэгтэй харилцах харилцаа чухал боловч тогтвортой харилцаатай байж чаддаггүй. Тиймээс ИНБ-ууд зорилтот бүлэгтэй болон олон нийттэй харилцах харилцаагаа “дундаж” хэмээн үнэлжээ. Харин хэвлэл мэдээлэлтэй харилцах харилцааг “дунджаас доогуур” гэж тодорхойлсон. Түүнчлэн судалгаанд оролцогчид “Хэвлэл мэдээллээр дамжуулан зорилтот бүлэгтэйгээ харилцвал илүү хурдан мэдээлэл авах давуу талтай. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд телевиз, радиог илүүтэй хэрэглэж, цахим орчноос мэдээлэл бага авдаг. Харин сул тал нь хэвлэл мэдээллийн байгууллагаар дамжуулан мэдээллээ гаргах нь төлбөртэй байдаг эсвэл өөр төрлийн мэдээг мэдээлэх шаардлагатай учир боломжгүй зэрэг хариу авдаг тул тэр бүрчлэн холбоотой байдаггүй. Мөн телевиз, радиог хүмүүс төдийлөн үзэх нь бага тул манай үйл ажиллагааг сурталчлан таниулахад онцгой ач холбогдолтой биш” хэмээн хариулсан. Түүнчлэн ИНБ-ууд зорилтот бүлэг тус бүрд тохирсон хэвлэл мэдээллийн сувгуудыг ашиглах хэрэгцээ шаардлага өндөр буйг онцолсон. Зарим ИНБ-ын төлөөлөл “Бидний хувьд хариуцсан чиглэлдээ хүрч, үр дүнтэй ажиллаж чаддаг. Ингэхдээ гол төлөв уламжлалт аргыг ашигладаг. Хийж байгаа ажил маань зорилтот бүлэгтээ хүрч байгаа нь давуу тал болно. Гэвч зорилтот бүлэгтэй харилцахад асар их цаг хугацааг зарцуулдаг” гэжээ. Мөн зарим төлөөлөл “Имэйл илгээгээд араас нь заавал утсаар залгаж баталгаажуулах шаардлагатай болдог” зэргээр хариулсан нь мэдээлэл харилцааны хэд хэдэн аргыг хавсран хэрэглэж буйг харуулж байна.

Мөн ИНБ-уудын мэдээлэл харилцаанд зориулсан төсвийн талаар нийт судалгаанд оролцсон байгууллагуудын 91 хувь нь “Мэдээлэл харилцааны ажилтан эсвэл уг үйл ажиллагаанд зориулсан тогтмол төсөвгүй” хэмээн хариулсан байна. Мөн “Мэдээлэл харилцааны ажилтан эсвэл уг үйл ажиллагаанд зориулсан тогтмол төсөвтэй” хэмээн хариулсан байгууллагууд Улаанбаатарт үйл ажиллагаа явуулдаг, орон нутагт үйл ажиллагаа явуулдаг ИНБ байхгүй байна. Олон нийттэй харилцахад зориулсан төсөв нь ИНБ-уудын санхүүгийн чадамж болоод санхүүгийн таатай орчин гэсэн ойлголттой шууд хамааралтай. Орон нутаг болон Улаанбаатарын зах зээлийн ялгаатай байдал энэхүү санхүүгийн таатай нөхцөлтэй шууд холбогдоно. Мөн ард иргэдийн амьжиргааны түвшин, хүн амын суурьшил, мэдээллийг амьдрал ахуйдаа ашиглах чадвар, дэд бүтцийн хөгжил, хэрэглэгчдийн боловсролын түвшин, нийгмийн

сэтгэл зүйн төлөвшил гээд олон хүчин зүйл шууд бусаар санхүүгийн таатай нөхцөлтэй холбогдох юм.

Зорилтот бүлэгтээ зориулан мэдээлэл түгээх, олон нийттэй харилцахад зориулсан төсвийн талаар




ИНБ-уудын мэдээлэл харилцааны санхүүгийн төсвийн хүндрэл нь тэдгээрийн үйл ажиллагаанд нөлөөлөх олон асуудлыг хөндөж буйг харж болно. Мөн мэдээлэл түгээхэд болон мэдээлэл харилцааны ажил явуулахад гардаг хүндрэлийн талаар дурьдахдаа ИНБ-уудын 67 хувь нь “төсөв санхүүжилт” гэж хариулсан байна. Түүний дараа “Хүний нөөцийн дутагдалтай” байдал гэж 28 хувь нь хариулжээ.



Энэ талаар судалгаанд оролцогчид “ИНБ-уудын үйл ажиллагаа, мэдээлэл зорилтот бүлэгтээ хүрдэг боловч тухайн байгууллагын талаар мэдээлэлтэй цөөн хэдэн хүмүүст л хүрдэг байх магадлалтай. Өөрөөр хэлбэл мэдээлэл харилцааны цар хүрээ нь хумигдмал юм. Илүү өргөн цар хүрээ, харилцаа холбоотой ажиллахад санхүүгийн хүндрэл бэрхшээл голчлон тулгардаг. Харин ИНБ-уудын хэвлэл мэдээлэлтэй харилцах харилцааг тааруухан гэж боддог. Учир нь хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хүний нөөц болон санхүүгийн чадавх байдаггүйтэй холбоотой” гэж хариулсан нь санхүүгийн хүндрэл бэрхшээлийн улмаас мэдээлэл харилцааны ажлын хумигдмал байдлыг улам тодотгожээ. Харин олон нийттэй харилцах мэдлэг ур чадвар, мэдээлэл харилцааны сувгуудыг ашиглах чадамж зэрэг нь хүндрэлтэй гэж судалгаанд оролцогчдын 17 хувь нь хариулан төсөв санхүүжилт, хүний нөөцтэй харьцуулахад асуудал биш болох нь харагдана.

Мэдээлэл түгээхэд болон мэдээлэл харилцааны ажил явуулахад гардаг хүндрэлийн талаар



Өмнөх судалгаануудад гишүүдийн хандив, татвар, иргэн, ААНБ-ын хандив нь ИНБ-уудын орлогын тэргүүлэх түгээмэл эх сурвалжуудаар дурдагдсан байв. Гэвч зарим судалгаанд хамгийн түгээмэл санхүүжилтийн эх үүсвэр нь олон болон хоёр талт хандивлагчдаас ирэх олон улсын тэтгэлэг, төслийн санхүүжилт байна гэж тэмдэглэжээ (“Баасанжав консалтинг” ХХК, 2017). 2000 оны судалгаагаар ИНБ-ын дотоод, гадаад нөөцийн харьцаа 6.7:93.3 буюу ихэнх нь гадаад эх үүсвэрийн хүчинд ажиллаж байжээ. (Удирдлагын Академийн Зөвлөлгөө, бизнесийн төв, 2000). Харин 2005 онд ИНБ-ын санхүүжилтийн 59.5 хувь нь гадаадын донор байгууллага, 27.9 хувь нь өөрсдийн үйл ажиллагааны орлого, 12.6 хувь нь хандив, дэмжлэг гэсэн эх үүсвэрээс бүрдэж байсан байна (Ардчиллын боловсрол төв, 2005). ИНБ-ын санхүүгийн гол эх үүсвэрийн нэг нь хандив юм. Хандивлагч иргэн, аж ахуйн нэгжийг холбогдох татвараас чөлөөлөх, хөнгөлөх зохицуулалтгүйгээс хандив өгөх сонирхол дэмжигдэхгүй байгааг 2017 онд

хийсэн судалгаанд дурджээ. Мөн ИНБ нь үл хөдлөх хөрөнгөтэй тохиолдолд хөрөнгийн татвар ногдуулах нь ТББ-ыг өөрийн байртай болох сонирхолд сөрөг нөлөө үзүүлж байна (“Баасанжав консалтинг” ХХК, 2017). Байгууллагын онцлогоос хамаарч зарим ИНБ төрийн чиг үүргийг гүйцэтгэсэн, эсвэл тендерийн үйл ажиллагаа хэрэгжүүлэх зэрэг хэлбэрээр төрөөс санхүүжилт авах явдал мөн түгээмэл байна.



Үүнээс гадна зарим ИНБ-ууд нь crowdfunding буюу олон нийтээс хөрөнгө босгох, аж ахуйн зарим үйл ажиллагаа, хандивын дуудлага худалдаа зэрэг түгээмэл биш орлогын эх үүсвэрийг мөн үр дүнтэй ашиглаж байна. ААНБ, иргэдийн хандив нь илүү урлаг соёлын, хүмүүнлэгийн болон нийгмийн үйлчилгээний шинжтэй үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудад ажиглагдаж байна. Харин төрд хяналт тавьдаг, иргэний дуу хоолойг хүргэдэг, иргэдийн эрх ашгийг төлөөлдөг, хамгаалдаг чиглэлийн байгууллагуудад иргэд, ААНБ-ын хандивын орлого төдийлөн байхгүй байна гэж тодотгожээ (Иргэний орон зайн төлөв байдал, түүнийг дэмжих эрх зүйн таатай орчны хэрэгцээ шаардлагыг тодорхойлох судалгаа, 2021).

Тус судалгаанд оролцогчид төсөв санхүүжилт дутагдалтай байдал нь ИНБ-ууд орлого олох бизнесийн ур чадвар хангалтгүй байхаас гадна санхүүгийн менежмент, тогтолцоо нь харьцангуй сул тул санхүүгийн эх үүсвэрийг үр дүнтэй ашиглах, санхүүгийн эрсдэлээс хамгаалах хуримтлал босгож чадахгүй байна гэж тэмдэглэжээ.

Мөн “ИНБ-ууд бидний ур чадвар тун хангалтгүй байна. Уг нь энэ чадварыг сайжруулах ёстой юм шиг байна лээ. Гэтэл энэ нь ИНБ-уудын хувьд биеллээ олохгүй байна. Магадгүй судалгаа хийдэг, сургалт явуулдаг ИНБ-ууд чадвараа сайжруулж чаддаг байх. Улаанбаатарт судалгаа хийдэг, сургалт явуулдаг ИНБ-ууд олон байдаг боловч орон нутгийн ИНБ-ууд энэ хүрээнд хөгжиж чадаагүй. Мөн хүний нөөцөөс шалтгаална. Бид олон нийттэй харилцах, мэдээлэл түгээх ажилтан цалинжуулахын


тулд нийгмийн үйл ажиллагаа явуулаагүй. Зорилтот бүлгээ л чадваржуулна, сургана гэхээс биш ажилтныхаа хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах мэдлэг, ур чадварыг сайжруулахыг нэн тэргүүний зүйл гэж бодохгүй байна. Манай хуульд ч асуудал бий. Анхнаасаа ашгийн бус гээд явчихсан. Харин ашиг олоод ажилтныхаа чадварыг дээшлүүлэх болон цаашлаад байгууллагын тогтвортой байдалд зарцуулбал зүгээр гэж ойлгож байгаа. ИНБ-ууд бидний хувьд иргэний нийгмийн салбарт нийгмийн энтрепренёрууд болж хэвлэл мэдээлэлтэй зөв харилцах, мэдээлэл харилцааны сувгуудыг үр ашигтай ашиглах ур чадвараа дээшлүүлэх хэрэгтэй гэдгийг ухаарсан” гэж хариулжээ.

Түүнээс гадна ИНБ-ууд мэдээлэл харилцааны сувгуудын хүртээмжийг сайжруулахын тулд “Подкаст, сургалтууд /хэвлэлийн ажилтантай харилцах/”, “Мэдээлэл харилцааны сувгуудыг хэрэглэх чадамж, мэдлэгт суралцах”, “Мэдээлэл харилцааны сувгуудыг ашиглах чадамж, мэдлэгийн дадлага сургалт”, “Хэвлэл мэдээллийнхэнтэй хэрхэн хамтран ажиллах” гэж 50-аас дээш хувь нь хариулсан байна. Иймд цаашид ИНБ-уудад эдгээр төрлийн сургалтуудын хэрэгцээ шаардлага буйг харуулж байна.

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛТЭЙ ХАРИЛЦАХ НЬ

Судалгааны энэ хэсэгт ИНБ-ууд болон хэвлэл мэдээллийн хэрэгслүүд хэрхэн харилцан ойлголцож буй талаар өнөөгийн байдлын дүн шинжилгээний анхдагч болон хоёрдогч судалгааны үр дүнг танилцуулж байна. Тухайлбал Монгол Улсын ИНБ болон хэвлэл мэдээллийн хэрэгслийн онцлог, тэдгээрийн ойлголцолд тулгамдаж буй асуудал, хүндрэл бэрхшээлийн талаар бусад улсын ИНБ-уудтай харьцуулан тэдгээрийн үйл ажиллагаанд нөлөөлөх хүчин зүйлүүд, цаашдын хэрэгцээ, давуу болон сул талуудыг тодорхойлсноор цаашдын хамтын ажиллагааг сайжруулах арга замыг эрэлхийлэхэд хувь нэмрээ оруулахыг зорив.


Судалгаанд оролцсон ИНБ-ууд байгууллагынхаа үйл ажиллагааг сурталчлан таниулахад ямар төрлийн хэвлэл мэдээлэл хамгийн тохиромжтой гэж үзэж байна гэж үзэж байгаа талаар “Мэдээллийн сайт” гэж талаас илүү хувь нь хариулжээ. Гэвч орон нутагт “сонин” илүү тохиромжтой талаар судалгаанд оролцогчид хариулжээ.





Мөн ИНБ-уудын олонх нь буюу 77-92 хувь нь “Хэвлэл мэдээллийнхэн бидний үйл ажиллагааг сонирхдоггүй”, “Хэвлэл мэдээллээр үйл ажиллагаа сурталчлан таниулахад гарах зардал өндөр”, “Хэвлэл мэдээллийнхэн бидний үйл ажиллагааны гол мөн чанарыг бичиж нийтлэхдээ орхигдуулдаг, өөрчилдөг” гэж хариулсан байна.

Гэвч нөгөө талаар “Хэвлэл мэдээллийнхэн сенсаацийн хойноос хөөцөлдөөд нийгэмд өрнөж буй үйл явдлын гол утгыг ойлгодоггүй” гэдэгт “Огт санал нийлэхгүй байна” гэж хариулсан байна. Мөн “Хэвлэл мэдээлэл эрх мэдлийн хэрэгжилтэд хяналт тавих үүргээ хангалттай биелүүлдэг”, “Хэвлэл мэдээлэл иргэдэд үйлчлэх үүргээ хангалттай биелүүлдэг” гэдэгт 85-аас дээш хувь нь “Бүрэн санал нийлж байна”, “Санал нийлж байна” гэж хариулсан байна.




Энэ нь ИНБ-ууд хэвлэл мэдээллийн хэрэгсэлд итгэдэг боловч хамтарч үйл ажиллагаа явуулахад зардал өндөр болон үйл ажиллагааны талаар бүрэн бус ойлголттой байдаг хэмээн тайлбарлаж байна. Цаашдаа ИНБ-уудын хэвлэл мэдээллийн хэрэгсэлд итгэх

итгэлийг нэмэгдүүлэхийн сацуугаар хэвлэл мэдээллийн хэрэгслийн ИНБ-уудын талаарх ойлголтыг сайжруулах хэрэгцээ шаардлага байна.

Түүнчлэн ИНБ-уудын хэвлэл мэдээллийн хэрэгсэлд итгэх итгэл нэмэгдэх нь ИНБ-ууд үйл ажиллагаагаа олон нийтэд таниулах аргад суралцахтай хамааралтай талаар судалгаанд оролцогчид хөнджээ. Тухайлбал, "ИНБ-ууд өөрсдөө PR хийх тал дээр муу. Үүнийг хийж чадах байгууллага цөөхөн, ихэнх нь үйл ажиллагаагаа олон нийтэд танилцуулах тал дээр төртэй харьцуулахад сул байдаг. Маш сайн үйл ажиллагаа явуулан нийгэмд тустай үйл ажиллагаа явуулж байгаа хэдий ч ИНБ-уудыг хүмүүс төдийлөн мэддэггүй. ИНБ-уудын нэр хүндийг нь унагах гэсэн дайралт цөөнгүй гарч байна. Тиймээс хэвлэл мэдээллийн хэрэгсэлд итгэн тэдэнтэй хамтран ажиллан өөрсдийн үйл ажиллагаагаа зөвөөр таниулмаар байна" гэж хариулжээ.

Мөн ИНБ-ууд үйл ажиллагаагаа таниулан цаашид хамтарч ажиллахад "Мэдээллийн сайт" илүү тохиромжтой (56 хувь) гэж хариулсан бол орон нутагт үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын хувьд "Телевиз" гэж хариулжээ. Мөн хүүхдийн хөгжил, залуучуудын нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, өсвөр үе залуучуудад эрх зүйн болон эрүүл мэндийн боловсрол олгох, зөвлөн туслах үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд бүгд "Мэдээллийн сайт" хэмээн хариулсан байна. Харин хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах, сургалт сурталчилгаа заавар зөвлөгөө, зөвлөмж өгөх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын хувьд "Радио", "Сонин"-ыг үйл ажиллагааг сурталчлан таниулахад хамгийн тохиромжтой гэж хариулсан байна. Иймд цаашид хөдөө орон нутгийн онцлог болон үйл ажиллагааны төрлийг харгалзаж хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй хамтран харилцах арга замыг тодорхойлох хэрэгцээтэй байна.



Энэ талаар судалгаанд оролцсон зарим төлөөлөл “Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд аудиоогоор мэдээллээ гаргавал харааны бэрхшээлтэй иргэдийн хувьд хэрэглээний хүртээмж сайжирна. Мөн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд өөрсдийн нөөц бололцоондоо тулгуурлан эфирийн цаг, сайтын буландаа “Иргэний нийгмийн цаг”-ийг гаргаж өгвөл хамтран ажиллах боломж нэмэгдэх юм” гэжээ. Түүнчлэн, “Хэвлэл мэдээллийн хэрэгслүүдтэй хамтран ажиллахад хэн хэнийхээ боломжийг харах, харилцан ойлголцох чухал. Хэвлэл мэдээлэлтэй хамтарч ажиллах мэргэшсэн бүлгүүд байвал үр дүнтэй болох байх гэж боддог. Жишээлбэл, шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийн чиглэлээр бүтээлийн уралдаан зарлахад сэтгүүлчид асуудлынхаа гол мөн чанарыг мэддэггүй учраас сурвалжилга авсан ч үзэгч, сонсогчийн нэг үгэнд бүдрэх тохиолдол бий. Тиймээс сэтгүүлчдийг сурвалжилж буй сэдвээр нь зохих мэдээлэлтэй болгож, чадавхжуулах нь чухал гэж бодож байна. Өөрөөр хэлбэл сэтгүүлчид салбар салбараар мэргэшвэл сайн. Бид ч энэ талаар сургалт орж болно” зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй хэрхэн хамтрах талаар зарим зөвлөгөө, шинэ санааг дэвшүүлж байв.

Мөн “Үйл ажиллагааныхаа талаар олон нийтэд мэдээлэл хүргэхийн тулд хэвлэл мэдээлэлтэй тогтмол хамтын ажиллагаатай байх шаардлагатай боловч байгууллагуудын хоорондын холбоо, харилцаа дутмаг байдаг учраас энэ тал дээр холбогч гүүр болох дэмжлэг хэрэгтэй болов уу гэж бодож байна” гэж хариулсан нь цаашдаа хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй тогтмол хамтын ажиллагаатай байх төдийгүй тэдгээрийг дэмжих хэрэгцээ шаардлагын талаар дурджээ.

Мөн эдгээр хэвлэл мэдээллийн хэрэгслийг сонгож буй шалтгааны талаар “Танил хүн тэнд ажилладаг”, “Хүртээмжтэй, нэр хүндтэй ХМХ учраас”, “Манай байгууллагын зорилго, үйл ажиллагааг дэмждэг” гэх гурван хариултууд илүү сонгогдсон байна. Танил хүн тэнд ажилладаг хэмээн нийт ИНБ-уудын 21 хувь нь хариулсан ба эдгээр нь орон нутагт үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд байна.



Хэрэглэдэг мэдээллийн хэрэгслийн талаар асуулгад “Өөр бусад” гэдэг хувилбарыг сонгогсод “Өөрсдийн сониноор дамжуулдаг, орон нутагт тогтмол үйл ажиллагаа явуулдаг телевизтэй, бодитой, эх сурвалжтай, хараагүй хүмүүс ихэвчлэн радио сонсдог учраас” гэх мэтээр сонгосон шалтгаанаа дурджээ.

Түүнчлэн хэвлэл мэдээлэлд мэдээлэл өгье, мэдээллээ гаргуулъя гэхэд хэвлэл мэдээллийн байгууллагаас төлбөр мөнгө шаардаж байсан эсэх талаар судалгаанд оролцогчдын 44 хувь нь тийм гэж хариулсан ба “Бид хэвлэл мэдээллийн байгууллагуудтай нягт хамтран ажилладаг. Нэгэнт төсөв санхүүгүй болохоор янз бүрийн томоохон арга хэмжээ болж байхад сэтгүүлчдэд хэрхэн мэдээлэл өгөх вэ? Хэрхэн шаардсан мөнгийг нь өгөх вэ? гэж их боддог. Тиймээс зарим талаар танил талынхаа сүлжээг ашиглан мэдээ, сурвалжилга үнэ төлбөргүй түгээх гэх мэт олон зүйлийг хийдэг. Магадгүй энэ боломж орон нутагт их байх. Нөгөө талаар сэтгүүлчдэд тэдний мэдэхгүй мэдээллийг өгдөг. Зарим мэдээллийн талаар ТББ-уудаар дамжуулан мэдсэн гэж хэлэхийг нь сонссон. Сэтгүүлчдийн хувьд нарийвчилсан хууль тогтоомж, тэдгээрийн өөрчлөлт, юу болж байгааг мэдэхийн аргагүй завгүй байдаг гэж бодож байна” гэж хариулжээ.

Хэвлэл мэдээлэлд мэдээлэл өгье, мэдээллээ гаргуулъя гэхэд тань тэдний зүгээс төлбөр шаардаж байсан тохиолдол байсан уу?



Мөн сэтгүүлчтэй ярилцаж, мэдээлэл өгсний дараа агуулга/нэр/тайлбар зэрэг зүйлийг тэд өөрчилж, нийтэлж нэвтрүүлсэн тохиолдол гарч байсан эсэх талаар охид эмэгтэйчүүд, хүүхдийн эрх хамгаалах, эмэгтэйчүүдийн манлайлал, жендэрийн тэгш байдлыг хангах сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа явуулдаг болон охид, эмэгтэйчүүдийн хөдөлмөрлөх эрхийн төлөө үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд “Тийм, байнга” гэж хариулсан байна. Мөн хэвлэл мэдээллийнхэнд мэдээллээ өгөх, нийтлүүлэх үед ямар хүндрэл, бэрхшээл гардаг талаар “Хэвлэл мэдээллийн байгууллагын боловсон хүчний чадавхыг сайжруулах шаардлагатай санагддаг. Зарим сэтгүүлчид асуудалд хүний эрхийн мэдрэмжгүй хандах, агуулгаа сайн ойлгохгүй байх

нь бий. Жишээ нь, манай тохиолдолд ЛГБТИК хүмүүсийг дэмжих үйл ажиллагаа дээр сэтгүүлчийн субъектив хандлага илэрч гардаг” зэрэг хариултыг өгсөн байна.

Сэтгүүлчтэй ярилцаж, мэдээлэл өгсний дараа агуулга/нэр/тайлбар гэх мэт зүйлийг тэд өөрчилж, нийтэлж нэвтрүүлсэн тохиолдол гарч байсан уу? Газар зүйн байршлаар



Мөн өмнөх хэсэгт дурдсанчлан мэдээлэл түгээхэд болон мэдээлэл харилцааны ажил явуулахад гардаг хүндрэлийн талаар 28 хувь нь “хүний нөөцийн дутагдалтай” байдал гэж хариулсан байна. Энэ талаар ИНБ-уудын төлөөлөл “ИНБ-ууд төсөл хөтөлбөрөөр санхүүжиж байдаг нь нийтэд нэгэнт нээлттэй байдаг. ИНБ-уудын хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдэд олон нийттэй харилцах ажилтны захиргааны болон цалингийн зардлыг дэмждэггүй. Төрөөс болон олон улсын дэмжигч байгууллагаас үйл ажиллагааг олон нийтэд түгээх, түүнийг хэрэгжүүлэхийн тулд шалгуур тавьж магадлан, аудит байдаг хэр нь олон нийттэй харилцах ажилтныг цалинжуулах, тэдгээр хүмүүсийн чадавхийг дэмжсэн зардал огт багтдаггүй нь олон ИНБ-ын үйл ажиллагааг тасалдахад хүргэдэг нь нэгэнт илт” гэж хариулсан байна.

Хэвлэл мэдээлэлтэй харилцах, олон нийтэд мэдээлэл түгээхээр мэргэшсэн/орон тооны ажилтан нийт байгууллагын 93 хувьд нь байхгүй. Ихэвчлэн өөр ажилтай хавсарч хийдэг болон огт байхгүй хэмээн 80-аас дээш хувь нь хариулсан байна. Мөн өөрсдийн хэмжээнд л мэдээллээ нийтлээд түгээгээд явдаг хэмээн хариулсан байгууллагууд цөөнгүй. “Тийм, бүтэн цагийн ажилтан байгаа” хэмээн хариулсан байгууллагууд ихэнх нь ОУБ-ын Монгол Улс дахь салбар болон орон даяар салбар зөвлөлтэйгөөр үйл ажиллагаа явуулдаг байгууллага төдийгүй байгуулагдаад 10-аас дээш жил болсон байгууллагууд байна. Эдгээрээс харахад ИНБ-ууд хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах ажилтантай байх нь санхүүгийн хувьд хүндрэл бэрхшээлтэй ба өөр бусад ажилтай хавсарч хийдэг ажилтныг сургах нь цаашдын үйл ажиллагаанд дөт алхам байх боломжтой.

Танай байгууллагад хэвлэл мэдээлэлтэй харилцах, олон нийтэд мэдээлэл түгээхээр мэргэшсэн/орон тооны ажилтан бий юу?



Хэвлэл мэдээлэл олон нийттэй харилцах ажлыг өөр бусад ажилтай хавсарч хийдэг ажилтныг цаашид мэргэжлийн сургалтад хамруулах шаардлагатай ба 78 хувь нь тийм төрлийн сургалтад хамрагдаагүй гэж хариулжээ.

Мөн ИНБ-ууд цаашид “Хэвлэл мэдээлэлтэй харилцах хамтарч ажиллах”, “Бусдад ойлгуулах, хүргэх мессеж боловсруулах тактик”, “Сонин, вебсайт, телевизийн онцлогт тохирсон мэдээ бичих”, “Олон нийттэй харилцах сошиал сувгаар мэдээлэл түгээх” сургалт зэрэгт хамрагдах хүсэлтэй байгаагаа дурдсан. Түүнчлэн ИНБ-уудын иргэдэд хүргэх мэдээ мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхаарсан сургалтууд шаардлагатай байгааг үүнээс харж болох юм.

Ямар төрлийн мэдлэг, ур чадварыг олж авах/сайжруулах хэрэгцээ байна вэ?



Шаардлагатай мэдлэг ур чадварын талаар “Өөр бусад” гэдэг хувилбарыг сонгогсод “Контент хийх, постер хийх, подкаст хийх, видео хийх, цахим хуудасны хөтлөлт, тохиргоо, бүүст хийх, олон нийтэд мэдээлэл хүргэх аргуудын талаар, төхөөрөмж дээр ажиллаж сурах, төсөл бичих, хөрөнгө босгох, мэдээ, мэдээллээ англи хэлээр хөрвүүлж олон улсад цацах” гэх мэт сургалтын төрлүүдийг дурджээ.



Түүнчлэн судалгаанд оролцогчид, “ИНБ ба хэвлэл мэдээллийн байгууллагуудын хоорондох хамтын ажиллагааны ойлголт харьцангуй сайн ч хэрхэн хамтрах, тэдэнтэй харилцах талаар суралцмаар байна. ИНБ-ууд янз бүрийн судалгаа, хэлэлцүүлэг зохион байгуулахад хэвлэл мэдээллийн байгууллагууд маш идэвхтэй оролцдог. Тэр дундаа хэвлэл мэдээллийнхэн тэдний үйл ажиллагаатай холбоотой шүүмжлэл, хэлэлцүүлгийг идэвхтэй явуулдаг. Хэвлэл мэдээллийн байгууллагад олон залуус ажилладаг ба тэд нэлээд идэвх санаачилгатай гэж хэлж болно. Мөн ИНБ-ууд ч хэвлэл мэдээлэлтэй хамтран ажиллах нь чухал гэдгийг ойлгож байгаа. Иймд хэвлэл мэдээллийн хэрэгсэлд өөрсдийн мэдээллийг өгөх, үйл ажиллагаагаа сурталчлах зэрэг аргуудыг сүүлийн жилүүдэд нэлээд идэвхтэй өрнүүлсэн. Гэвч тогтвортой харилцааг хэрхэн бий болгох вэ гэдэг дээр ер нь зогсоод байна” гэж хариулжээ. Мөн “Таньдаг телевиз, сонин, хэвлэл мэдээллийн байгууллагуудыг төрөл бүрийн арга хэмжээнд урьж оролцуулан, тодорхой чиглэлээр мэдээлэл өгсөн. Хамтарсан харилцааг дэмжих зорилготой урт хугацааны сургалтуудыг зохион байгуулах зэрэг санаачилга гаргаж байсан. Гэвч манай байгууллагын болон таньдаг хүн маань ажиллахаа больсон гэх мэт хэвлэл мэдээллийн хэрэгслийн хүний нөөцийн асуудлууд байсан учир удаан хугацаанд үргэлжлээгүй. Цаашдаа хэвлэлийнхэнтэй ажиллахад асуудал байхгүй гэж бодож байна” гэсэн хариултууд өгсөн байна.

Хэвлэл мэдээллийнхэнтэй салбарын асуудлаар яриа, хэлэлцүүлэг хийх хэрэгцээ, шаардлага бий юу? Ийнхүү зохион байгуулах тохиолдолд танай байгууллага оролцох уу?



Мөн хэвлэл мэдээллийнхэнтэй салбарын асуудлаар яриа, хэлэлцүүлэг хийх хэрэгцээ, шаардлагын талаар асуулгад нийт ИНБ-уудын 77 хувь нь оролцоно гэж хариулсан байх ба “Хэвлэл мэдээлэлтэй харилцах хамтарч ажиллах” үйл ажиллагааг дэмжих, идэвхжүүлэх шаардлагатайг энэхүү асуулгаас харж болох юм. Мөн хэрхэн харилцан хамтран ажиллах арга замын талаар судалгаанд оролцогчид, “тухайн ИНБ стандартад нийцсэн сайн контент нийлүүлбэл хэвлэл мэдээллийн байгууллага үнэ төлбөргүй цацах боломжтой байдаг. Тиймээс ИНБ-ууд хийсэн судалгаагаа хуваалцах, байнгын харилцаатай байх гэх зэргээр хоёр талын хамтын ажиллагааг сайжруулах алхмуудыг хийх нь үр дүнтэй” зэргээр хариулсан байна.


ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАТАЙ ХАРИЛЦАХ НЬ

Судалгааны энэ хэсэгт ИНБ-ууд болон төрийн байгууллагуудын мэдээлэл харилцааны өнөөгийн төлөв байдал, бүтээлч хамтын ажиллагааны дүн шинжилгээний анхдагч болон хоёрдогч судалгааны үр дүнг танилцуулж байна. Тодруулбал төрийн байгууллагуудтай харилцахад тулгамдаж буй асуудал, үр дүнтэй хамтын ажиллагааг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөхөд дөхөм болох дүгнэлтэд хүрэхийг зорив.

Нийт судалгаанд хамрагдсан байгууллагуудын 74 хувь нь төрийн байгууллагатай харилцах, хамтарч ажиллах хэрэгцээ байнга гардаг гэж хариулсан нь ИНБ-уудын үйл ажиллагааг тогтворжуулах, төлөвшүүлэх, хөгжүүлэхэд төрийн байгууллагын оролцоог орхигдуулж болшгүй, салшгүй хэсэг болсон нь харагдана.


Гэвч судалгаанд оролцогчид “Төрийн байгууллагууд ИНБ-ыг “хамтрагч” гэж үзэхгүй байгаа учраас харилцаа нь таагүй харагддаг. Одоогийн хууль эрх зүйн орчин нь ИНБ-уудыг хөгжүүлэх, төлөвших, нийгэмд нөлөөлөхөд илүү таатай байх боломжтой байж магадгүй. Хэрхэн хамтрах талаар ИНБ-ууд төдийгүй төрийн байгууллагууд мөн бодох хэрэгтэй байна. ИНБ-уудыг төрийн үйл ажиллагаанаас “шахах” нь нэлээд давамгайлсан нөхцөлд одоогоор ИНБ-ууд ажиллаж байна. ... ТББ-ын тухай хуульд өөрчлөлт оруулах нэрийн дор Монголын нөхцөлд тохирохгүй хуулийг хөрш орнуудаас хуулбарлан авч, батлах гэж шахаж, хуулийн өөрчлөлт хийх гэж оролдсон. Тиймээс

ИНБ-ууд болон төрийн хамтын ажиллагааг ажил болгосон хуулийн төсөл орж иртэл одоо мөрдөж байгаа хууль дээр гэж харж байна” гэжээ.



Мөн ямар асуудлын хүрээнд харилцаа үүсгэх, хамтарч ажиллах хэрэгцээ байдаг талаар “Төрийн чиг үүргийг ИНБ хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд” гэж 83 хувь, “Зөвшилцөлд суурилсан бодлогын нөлөөлөл хийх” гэж давхардсан тоогоор 81 хувь, “Тодорхой асуудлаар мэдлэг, ойлголтоо нэгтгэх” гэж 80 хувь, “Хууль, эрх зүйн баримт бичгийн боловсруулалт, хэлэлцүүлэг” гэж 75 хувь нь маш их хэрэгцээтэй гэж хариулсан байна. Түүнчлэн зарим ИНБ-ын төлөөлөл “төртэй хамтарч ажиллах гэдэг нь өөр асуудал. Ямар асуудал дээр хамтарч ажиллахаас их шалтгаална. Иргэний нийгэм гэж юу вэ? Бид ямар хүрээнд хамтран ажиллах вэ гэх мэт асуудлууд дээр тодорхой хил зааг гарган, мэдээллийг ил тод болгох хэрэгтэй” гэж хариулсан нь ИНБ-ууд болон төрийн байгууллагын тодорхой асуудлаар мэдлэг, ойлголтоо нэгтгэх шаардлагатай байгааг тодотгоно.

Төрийн байгууллагатай ямар асуудлын хүрээнд харилцаа үүсгэх, хамтарч ажиллах хэрэгцээ байдаг вэ? (Олон хариулт сонгож болно)



Төрийн байгууллагатай харилцаа үүсгэх, хамтарч ажиллах хэрэгцээний талаарх асуулгад “Өөр бусад” гэдэг хувилбарыг сонгогсод “Үйл ажиллагааг нь сурталчлах, хамтран гэрээ байгуулж ажиллах”, “Бусад иргэдийн эрхийг хамгаалах, өмнөөс нь очиж ойлголцох”, “Хуралд нь оролцож эрх зүйн хүрээнд хамгаалах”, “Сургалт мэдээлэл хийх” зэрэг төрийн байгууллагуудтай хамтран ажиллах хэрэгцээ шаардлагуудыг дурджээ.

Түүнчлэн ИНБ-ууд төрийн байгууллагаас мэдээлэл авахад ямар хүндрэл бэрхшээл гардаг талаар “Мэдээлэл ил тод бус” гэж 73 хувь, “Өргөдөл, хүсэлтэд өгсөн хариу нь бүрэн гүйцэд байж чаддаггүй” гэж 60 хувь, “Үл тоох, үл хайхрах” гэж 63 хувь нь хариулсан байна. Эдгээр бэрхшээлийг даван туулахын тулд “Төрийн байгууллагын ажилтнуудад ИНБ-ын хийж буй ажлын үр нөлөөг харьцуулан үзүүлэх, дэмждэг, хамтран ажилладаг болоход чиглэгдсэн арга хэмжээ зохион байгуулах, эрх зүйн орчин бий болгох”, “ИНБ-аар гүйцэтгүүлэх ажлыг нэмэгдүүлэх”, “Төрийн ямар чиг үүргийг ИНБ хэрэгжүүлэх боломжтойг ил тод болгох”, “Төр нь ИНБ-тай хамтран ажиллах боломжтой ажлын жагсаалт гаргах, төлөвлөлтдөө тусгах” зэрэг арга хэмжээг авах хэрэгтэй гэж дурдсан байна. Өмнөх судалгааны дүнгүүдэд, ИНБ-ууд төртэй хамтарч ажиллахын тулд “Хамтарсан уулзалт хийх, өөрсдийгөө таниулах”, “Үйл ажиллагаагаа сурталчлах” зэргийг чухалчилж байсан бол бидний судалгаанд “ИНБ-аар гүйцэтгүүлэх ажлыг нэмэгдүүлэх” зэргийг чухалчилж төртэй хамтарч ажиллахад бэлэн болсон байгааг тус дүнгүүд илэрхийлж байна. Мөн тус асуулгад “Өөр бусад” гэдэг хувилбарыг сонгогсод “Иргэдийн мэдлэг дутмаг, мэдээллийн сувгууд ховор, харааны бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй бус, төрийн байгууллага иргэдийн өөрт нь тааруулж харьцдаг боловсрол өндөр байвал сайн үйлчилдэг, мэдээлэл яаж авах учраа мэдэхгүй хүнд бол муу үйлчилдэг” зэрэг хүндрэл бэрхшээлүүдийг дурджээ.



Цаашид ИНБ-ууд төрийн байгууллагатай бүтээлч хамтын үйл ажиллагааг төлөвшүүлэн өргөжүүлэхийн тулд өөрсдийн зүгээс “Хамтарсан уулзалт, хэлэлцүүлэг санаачлан зохион байгуулах”, “Бодлогын нөлөөлөл хийх, үр дүнтэй зөвшилцөл хийх арга техникт суралцах” зэргийн үйл ажиллагааг явуулах шаардлагатайг онцлон дурдсан байна. Мөн төрийн байгууллагын зүгээс ИНБ-уудтай хамтрах “Урт хугацааны бодлогын баримт бичигтэй болох” зэргийг тус асуулгад дурдсан байна. Мөн төрийн байгууллагууд “Нээлттэй, ил тод, хүнд сурталгүй байгаасай гэж боддог” гэсэн хариултууд байна. Зарим ИНБ-ын төлөөлөл “Төрийн байгууллагуудтай хамтарч ажиллахад эрх мэдлийн хувьд ялгаатай. Өөрөөр хэлбэл, төрийн бус, ИНБ гэж шууд утгаар нь хүлээж авдаг. Төрийн байгууллага, яамд маш хаалттай, хүнд сурталтай. ИНБ учир иргэд олон нийтэд ямар ч зардалгүйгээр үйл ажиллагаа явуулах ёстой, сайн дурын хүмүүс учраас та нарт ямар ч үйл ажиллагааны зардал байх ёсгүй гэж бодсон гэж хэлж байсан” гэж хариулжээ.

Мөн өмнөх судалгааны үр дүнгээс харахад төрийн зарим чиг үүргийг ИНБ-аар гүйцэтгүүлэхэд тулгардаг бэрхшээлийн талаар дараах байдлаар дүгнэсэн нь зарим талаараа тус судалгааг бататгах юм. Нэгдүгээрт, ИНБ-аар төрийн зарим чиг үүргийг гүйцэтгүүлж болно гэсэн шийдвэр, дүрэм, журам байдаг боловч, амьдрал дээр хэрэгжиж байгаа нь тун ховор. Хоёрдугаарт, төрийн яам агентлагууд төсөв, мөнгөтэй ажлыг өөрсдөө хийх, танил талаараа хийлгэх сонирхол нь давамгайлсан, ашиг сонирхлын зөрчил их байдаг. Гуравдугаарт, төр ИНБ-ын түншлэлийн асуудал олон жил яригдаж байгаа боловч, ажил хэрэг болгон үргэлжлүүлэх асуудал дээр төрийн байгууллагын дэмжлэг муу, санаачлага сул. Шуудхан хэлэхэд тэд (яам, агентлагууд) ажлыг өөртөө төвлөрүүлж байх хүсэлтэй. Дөрөвдугаарт, төр засгийн үйл ажиллагаанд дамжлага, хүнд суртал ихтэй. Дэвшүүлсэн саналыг бүрэн гүйцэт санал болгодоггүй, нэр төдий оромддог. Зарим асуудлыг эсэргүүцэн үгүйсгэдэг, түүнийг орхигдуулдаг зэрэг бэрхшээлүүдийг тусгажээ.

Хэдийгээр төр болон ИНБ-ын хамтын ажиллагаа өргөжиж байгаа ч харилцан бие биедээ үл итгэсэн байдал өнөөг хүртэл байгаа ба энэ талаар үр дүнтэй, сайн туршлагад үндэслэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх хэрэгцээтэй нь харагдана.




“Өөр бусад” гэдэг хувилбарыг сонгогсод “Эрх зүйн мэдлэгтэй болох, бичих хэрэг хөтлөх чадвартай болох, санхүүгийн мэдлэгтэй болох, өөрсдийгөө бүрэн илэрхийлэх чадамжтай болох, зөвшилцөх урлагт суралцах гэрээ байгуулж ажиллах, ИНБ-ууд өөрсдөө чадвартай байнга шаардлага тавьдаг байх хэрэгтэй” зэрэг саналуудыг дурджээ.

Судалгаанд оролцогчид төрийн байгууллагатай үр дүнтэй харилцахын тулд ИНБ-ын зүгээс төдийгүй төрийн байгууллагын хүртээмжтэй, үр дүнтэй үйл ажиллагаа явуулах шаардлагатай гэж хариулсан нь доорх хүснэгтээс харагдах ба “төр засаг солигдоход үйл ажиллагаа нь тогтвортой үргэлжлэх асуудлыг шийдэж өгөх хэрэгтэй байна. Төрийн талаас хариуцсан хүн нь байнга солигддог. Төртэй хамтран ажиллах хүсэл ИНБ-д байдаг, нөөц боломжтой хэдий ч өөрсдийнхөө давуу талыг харуулах, мэдээллээ системтэйгээр хуваалцах боломж тогтолцоо байхгүй. Иймд ИНБ-тай үр дүнтэй харилцахын тулд төрийн байгууллагаас ямар үйл ажиллагааг хэрэгжүүлэх талаар илүү нухацтай хиймээр байна” гэж хариулжээ. Мөн зарим төлөөлөл “Төрийн байгууллагатай хамтран ажиллахад нэгнийгээ дутуу үнэлэх, сөргөөр харах хандлагууд байдаг учраас тэр бүр хамтын ажиллагаа сайн байдаггүй. Гэвч сүүлийн үед зарим ИНБ-ууд төртэй нэлээдгүй сайн хамтарч байна. Тийм туршлагаас бусад ИНБ суралцаж, судлах шаардлагатай байна” гэж хариулсан нь цаашдын хамтын ажиллагааны талаар дурджээ.

Иргэний нийгэмтэй үр дүнтэй харилцахын тулд төрийн байгууллагаас ямар үйл ажиллагааг хэрэгжүүлэх хэрэгтэй талаар “Өөр бусад” гэдэг хувилбарыг сонгогсод “Тодорхой зардлаас төсөвт суулгаж өгөх, нээлттэй, сургах, дадлагажуулах, төрийн бодлогыг тайлбарлах, тэгш өрсөлдөх боломжийг бий болгох, гэрээт ажилтантай болох” зэрэг саналуудыг дурджээ.

ИНБ-тай үр дүнтэй харилцахын тулд төрийн байгууллагаас ямар үйл ажиллагааг хэрэгжүүлэх хэрэгтэй вэ?



ИНБ-уудтай хамтрах урт хугацааны бодлогын баримт бичгийн талаар 2021 онд Монгол Улсын Их хурлаас баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-д “...төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшил, мэргэжлийн холбоодод шилжүүлнэ” хэмээн тусгажээ. Мөн “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр”-т “4.2.10. Нийгмийн зөвшилцөлд үндэслэсэн түншлэлийн хүрээнд шийдвэр гаргах бүх шатанд төр, иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн хэвшил зөвлөлдөх, санал авах, гаргасан шийдвэрийн биелэлтэд хяналт тавихад оролцдог оновчтой тогтолцоог бүрдүүлнэ” хэмээн тусгасан нь төрийн байгууллага болон ИНБ-ын бүтээлч хамтын ажиллагааг онцолжээ.



Цаашилбал Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан “Үндэсний хөгжлийн цогц бодлого” (2007-2021), “Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр” зэрэг баримт бичигт иргэний нийгмийн байгууллагуудыг хөгжүүлэх, үйл ажиллагааг нь өргөжүүлэх, төрийн зарим чиг үүрэг, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх талаар тусгасан байна. 2010 онд Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.3.4.2-т “Төрийн бодлого боловсруулах, төрд хяналт тавихад төрийн бус байгууллагын тэгш оролцоо, зөвшилцлийг хангах замаар иргэний нийгмийн төлөвшилийг дэмжинэ. Нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг дэмжсэн эрх зүйн орчныг бүрдүүлж, төр болон ИНБ-ын хамтын ажиллагааны бүтээлч арга, хэлбэрүүдийг хөгжүүлнэ” хэмээн заасан байдаг.

“Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаанд ИНБ-ын тухай дурдахдаа ИНБ-хувийн хэвшил-төрийн гурван талт түншлэлийг бэхжүүлэх замаар үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлт, хэрэгжилтэд холбогдох талуудын оролцоог хангахад зайлшгүй шаардлагатай тогтолцоог бүрдүүлнэ гэж оруулсан байна.

Эдгээр нь нэг талаараа ИНБ-ын зарчим, бодлогын хүрээ, үзэл баримтлалыг

хэрэгжүүлэх, үйл ажиллагааг тогтворжуулан төлөвшүүлэх тогтолцоог хангаж буй мэт боловч, нөгөө талаараа ИНБ-ын үйл ажиллагааны баттай суурь болох хууль эрх зүйн тогтолцоо, дүрэм журмыг сайжруулах зэрэг бодит арга хэмжээнд хүрээгүй байна.

БУСАД ИНБ-ТАЙ ХАРИЛЦАХ НЬ

Судалгааны энэ хэсэгт ИНБ-ууд бусад ИНБ-тай хэрхэн харилцан ойлголцож буй талаар өнөөгийн байдлын дүн шинжилгээг танилцуулж байна. Тухайлбал өнөөдөр идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй ИНБ-уудын онцлог, тэдгээрийн харилцан ойлголцолд тулгамдаж буй асуудал, хүндрэл бэрхшээл, үйл ажиллагаанд нөлөөлөх хүчин зүйлүүд, цаашдын хэрэгцээ, давуу болон сул талуудыг тодорхойлсноор цаашдын хамтын ажиллагааг сайжруулах арга замыг эрэлхийлэхэд хувь нэмрээ оруулахыг зорив.


Судалгаанд оролцсон ИНБ-уудын олонх нь буюу 59-72 хувь нь “Бусад ИНБ бидний үйл ажиллагааг сонирхдоггүй”, “ИНБ-ууд хамтын ажиллагаа, харилцан ойлголцол сул”, “ИНБ-ууд бусдынхаа нэр хүндэд халддаг, үл итгэлцэл өндөр” гэж хариулсан байна. Мөн ИНБ-уудын 60-аас дээш хувь нь “ИНБ-ууд нэгдмэл байдал сул, хамтран бодлогын нөлөөлөл хийх чадамжгүй”, “ИНБ-ууд эрх мэдлийн хэрэгжилтэд хяналт тавих (watch-dog) үүргээ хангалттай биелүүлдэггүй”, “ИНБ-ууд иргэдэд үйлчлэх үүргээ хангалттай биелүүлдэггүй” гэдэгт “Огт санал нийлэхгүй” байна гэж хариулжээ.

Мөн асуулгын судалгаанд оролцсон ИНБ-уудын төлөөлөл нь “ИНБ-ын хувьд судалгаа, төрийн үйл ажиллагаа, үйлчилгээний мониторинг, улсын болон орон нутгийн төсвийн хяналтыг хийхэд бусад ИНБ-тай хамтран хийх хэрэгцээ шаардлага байдаг. Энэ талаар тодорхой хэмжээгээр төрөөс дэмжих хэрэгтэй гэж санагддаг. Төр зарим тодорхой үйлчилгээнүүдээсээ татгалзаж, чиглэл бүрээр гүйцэтгүүлэх байгууллага болох хамтран гүйцэтгүүлэх байгууллагыг зарлах, сонгох шалгуураа тодорхой болгох, системчлэх хэрэгтэй. Энэ нь эргээд ИНБ-ын тайлан болон татварын үүрэгтэй холбогдсон байх талаар ОУ-ын зарим жишиг байдаг. Мөн төрийн зүгээс ИНБ-ыг гаднын улсын ИНБ-тай хамтран ажиллахад нь дэмжлэг үзүүлэх эрхзүйн харилцааг бий болгох ёстой гэж үзэж байна. Яам болгон дээр байсан Иргэний зөвлөл гэдэг шиг тогтолцоо үүнд их хувь нэмэртэй байж магадгүй, цаашид илүү ИНБ-ууд бусад ИНБ-тай хэрхэн харилцан ойлголцож, харилцан хамтрах талаар бодлого боловсруулах, тэдгээрийн боломжийг олгох шаардлагатай санагдана” гэжээ.

Зарим ИНБ-ын төлөөлөл “Бид аль болох бусад ИНБ-тай хамтарч ажиллахыг хичээдэг. Гэвч мөн л ойлголтын зөрүү үүсдэг. Жишээлбэл, шаардлагад нийцсэн орон байрны асуудлын талаар, хүүхдийн байгууллагуудтай хамтран ажиллах шаардлага гардаг боловч асуудлаа ярилцахаар хүүхэд хамгааллын асуудал илүү чухал байгаа талаар нөгөө байгууллага байр сууриа илэрхийлдэг. Тиймээс бусад ИНБ-тай хамтран ажиллахад асуудлыг цогцоор нь харах чадвар дутмаг. Мөн ИНБ-уудын чадавхууд янз бүр байдаг. Тийм учраас хоорондоо нийлэхэд асуудал тулгардаг. ИНБ-ууд нэгдэж чадах нь өөрөө давуу тал юм. Энэ дээр 2021 оны хавар НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс хэрэгжүүлсэн “Архины хамааралтай гэр бүлд үзүүлэх сэтгэл зүйн цогц үйлчилгээ”

төслийн үр дүнг нэрлэж болох юм гэж хариулжээ. Зарим ИНБ-ын төлөөлөл “өмнө нь боловсролын салбарт хэрхэн үр нөлөөтэй хамтын ажиллагаатай байгаагийн сайн жишиг манай улсад байна. Ийм сайн туршлагыг бий болгоход ИНБ-ын өөрсдийн чадавх, нээлттэй байдал зэрэг нь нэн чухал байгаа нь ажиглагдсан. Үүнээс гадна соёл урлаг, хүүхэд хамгааллын чиглэлээр хувийн хэвшил, ОУ-ын байгууллагууд болон олон нийттэй үр дүнтэй хамтын ажиллагааг хөгжүүлж байгаа туршлага ч мөн байна. Иймд цаашид ИНБ-уудын хамтын ажиллагааг дэмжихэд ИНБ-ууд өөрсдийн ур чадвар, мэдээлэл солилцоо хэрэгтэй гэж харж байна” гэж хариулжээ. Түүнчлэн зарим төрлийн ИНБ-ууд хоорондоо нэгдэн үйл ажиллагаа явуулах боломжтой ч, зарим төрлийн ИНБ-уудтай хамтрах боломжгүй талаар дурдсан байна. “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулж үйл ажиллагаа явуулдаг ИНБ-ууд нэгдэж чадахгүй байна. Бид илүү мэргэших шаардлагатай. Бид нэгдэх хэд хэдэн оролдлого хийсэн ч, боломжгүй байна” гэж хариулжээ. Иймд цаашид ИНБ-ууд хоорондын харилцан үйл ажиллагааг дэмжихэд ИНБ-ууд санал нийлж байгаа ба тэдгээрийг нэгтгэх, хамтын үйл ажиллагааг өргөжүүлэх мэргэжлийн арга хэрэгсэл дутмаг байгааг тус судалгааны асуулгаас харж болох юм.

Та дараах зүйлстэй хэр зэрэг санал нийлж байна вэ?




Түүнчлэн судалгаанд оролцсон зарим ИНБ-ын төлөөлөл “ИНБ-уудын хамтын ажиллагаа харьцангуй сайн байдаг. Салбартаа тогтвортой үйл ажиллагаа явуулдаг, ижил зорилго чиглэлтэй ИНБ-ын хувьд эвсэл холбоодоор дамжуулан хамтран ажиллах, цахим орчинд нэгнийхээ үйл ажиллагааг дэмжиж сурталчлах, ИНБ-уудын эв санааны үдэшлэгт оролцож бусад ИНБ-ын үйл ажиллагаатай танилцаж мэдээлэл солилцох зэргээр хамтрах боломж нээлттэй байдаг. Сул тал нь шинэ, залуу ИНБ, эсвэл өөр чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудын хувьд мэдээлэл, эргэх холбоо багатай байдаг. Тухайлбал манай байгууллага иргэний боловсрол, залуучуудын хөгжил, ардчиллын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа учраас ижил чиглэл бүхий байгууллагуудтай хамтран ажиллах боломж нээлттэй байдаг бол экологи, хэвлэл мэдээлэл зэрэг чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудтай хамтран ажиллах хэрэгцээ хомс байдаг талтай”, мөн “Бусад ИНБ-ын шийдвэр, үйл ажиллагааг шүүмжлэхэд цаашид хамтран ажиллахаас татгалзах, хувь хүний хувьд дарамтлах зэрэг хүндрэл бэрхшээл өмнө гарсан. Зөв шүүмжлэл гэдэг ойлголтыг цаашид бусад ИНБ-тай хамтран ажиллахад дүрэм журамд оруулах, хэрхэн харилцан хариу арга хэмжээ авах аргыг ёс зүйн дүрэмд оруулах хэрэгтэй санагдана” гэж хариулжээ. Мөн зарим төлөөлөл “Манай байгууллага ИНБ-уудын консерциум, зөвлөлд байдаггүй ч хамтарсан судалгаа, зөвлөх үйлчилгээ, сургалтуудыг хийгээд хамтран ажиллаад явдаг. Мэдээ мэдээллийг бусад ИНБ-аасаа богино хугацаанд тогтмол аваад явдаг. Мэдээллийн урсгал маш түргэн. Төрийн байгууллагуудтай хамтран ажилласнаас ИНБ-уудтайгаа хамтраад ажил хийх нь илүү ойлгомжтой, хурдацтай, үр дүнтэй байдаг. Өөрсдөө маш сайн чадавхждаг” гэж цаашдын хамтын ажиллагааны талаар дурджээ.

ЭГЭХ ХАРИУЦЛАГА БОЛОН ИЛ ТОД БАЙДАЛ

Судалгааны энэ хэсэгт ИНБ-уудын эгэх хариуцлага болон ил тод байдлын өнөөгийн төлөв байдлын талаар анхдагч болон хоёрдогч судалгааны үр дүнг танилцуулж байна. Тодруулбал, ИНБ-ууд эгэх хариуцлага болон ил тод байдлыг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэн, үр нөлөөг сайжруулах замаар ИНБ-уудын талаарх олон нийтийн ойлголтыг сайжруулах үйл ажиллагааг төлөвлөхөд чиглэхийг зорив.


Судалгаанд оролцсон байгууллагуудын 50-аас дээш хувь нь тухайн байгууллагын зорилго, үйл ажиллагааны чиглэл зэргийг “байгууллагын вебсайт”, “байгууллагын улирлын/жилийн тайлан” зэргээс харах боломжтой гэж хариулжээ. Мөн байгууллагын ажилчид байгууллагынхаа үйл ажиллагааны чиглэл, зорилгыг ухамсарлан, ойлгосон хэмээн 88 хувь нь хариулсан байна.

Танай байгууллагын ажилтнууд байгууллагынхаа зорилго, үйл ажиллагааны чиглэл зэргийг хаанаас, ямар эх сурвалжаас шууд авах/харах боломжтой вэ?



Мөн байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл зэргийг баримт бичиг дээр баталгаажуулсан талаар “Залуучууд голдуу үйл ажиллагаа явуулдаг байгууллагын хувьд зорилго, зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөө тайлан гэх мэтийн тогтвортой байдал маш хүнд байдаг. ИНБ-ууд тогтвортой үйл ажиллагаа явуулахтай холбоотой хамгийн чухал баримт бичиггүй байдаг гэж хэлж болно. Миний бодлоор байгууллагын стратеги төлөвлөлтийн асуудал хамгийн тулгамдсан асуудал юм. Ихэнх байгууллагууд стратеги төлөвлөгөөгүй эсвэл ерөнхийдөө төслийн хүрээнд үйл ажиллагаа явуулж, төслөөс хамааралтай ажилладаг. Гэсэн хэдий ч тухайн төсөл нь байгууллагын өөрийн зорилго, чиглэлтэй нийцсэн байх ёстой. Стратегиа баримталж ажилладаг цөөн хэдэн байгууллага бий. Төлөвлөгөөтэй байгууллагууд цөөн бөгөөд тэрийгээ барьж ажиллан тайлан тооцоо гаргадаг, аудит оруулдаг байгууллага ховор гэж харж байна” гэж судалгаанд оролцогчид хариулжээ.

Танай байгууллагын ажилтан бүр байгууллагынхаа үйл ажиллагааны чиглэл, зорилгыг ухамсарлан, ойлгосон байдаг уу?



Мөн байгууллагуудын 74 хувь нь ажилтнуудын хариуцлагатай, ёс зүйтэй явж буй эсэхийг хянах, зохицуулах дотоод дүрэм журам, ёс зүйн зарчимтай гэж хариулсан ба тэдгээрийн 29 хувь нь “хөдөлмөрийн гэрээнд тусгасан” гэж хариулжээ. Эдгээр байгууллага нь үйл ажиллагаа 8-аас дээш жил болж буй байгууллагууд байх ба “гишүүдээ зохицуулдаг дүрмийн дагуу” хөдөлмөрийн гэрээнд тусгасан гэжээ.

Өнөөдөр хэрэгжиж буй хуулийн дагуу ИНБ-ын удирдлага нь үүсгэн байгуулагчаас бүрдсэн 5 ба түүнээс дээш хүнтэй удирдах зөвлөлтэй байна. Хэрвээ сан бол хяналтын зөвлөлтэй байхыг шаарддаг. Ихэнх тохиолдолд ИНБ нь хувь хүмүүсийн сайн дурын нэгдэл дээр байгуулагддаг. Үүсгэн байгуулагч, удирдах зөвлөлийн талаар 2005 онд Зохистой хөгжлийн жендэр төвөөс хийсэн судалгаанд дүгнэхдээ: Хууль, албан болон албан бус дүрмээр зохицуулагддаг нийгэм, улс төр, эдийн засгийн хүрээн дэх нийтлэг зорилго, ашиг сонирхлын төлөөх иргэдийн хамтын үйл ажиллагааны талбар юм гэж тодорхойлж байжээ (Зохистой Хөгжлийн Жендэр Төв, 2005). Гэвч энэхүү хуулинд дотоод дүрэм журам, ёс зүйн дүрмийн талаар тусгаагүй ба бусад орны ИНБ-уудын талаарх хууль эрх зүйн бичигт ёс зүйн дүрмийг гишүүд нь мэддэг төдийгүй зорилтот бүлэгт ил тод нээлттэй байхыг тодорхой хэмжээгээр тусгасан байдаг.

Судалгаанд оролцсон ИНБ-уудын төлөөлөл “Хөдөлмөрийн гэрээнд тусгаагүй ч, албан бусаар өдөр тутмын бүхий л үйл ажиллагаа, харилцаанд баримтлан явдаг, бичигдээгүй нийтлэг ёс зүйн хэм хэмжээгээр зохицуулаад явдаг” гэж байгууллагуудын 30 хувь нь хариулсан ба тэдгээрийг сайжруулах шаардлагатай талаар ч дурдсан байна.

Танай байгууллага ажилтнуудаа хариуцлагатай, ёс зүйтэй явж буй эсэхийг хянах, зохицуулах дотоод дүрэм журам, ёс зүйн зарчимтай бол ямар хэлбэртэй байдаг вэ?



Ажилтнуудаа болон харилцагч нараа цахим орчныг ёс зүйтэй, зөв ашиглахад туслах/чиглүүлэх удирдамж, гарын авлага байдаг эсэх талаар нийт байгууллагын 75 хувь нь “Үгүй” гэж хариулжээ. Энэ талаар асуулгын судалгаанд оролцсон зарим ИНБ-ын төлөөлөл “төрийн эрх мэдэл бүхий албан тушаалтныг удирдах зөвлөлд урьж оролцуулах нь зөв бөгөөд ингэснээр зарим нэг дүрэм журам албан ёсны болно. Цахим орчинд хэрхэн ёс зүйтэй мэдээлэл түгээх, хэрэглэх талаар зөвлөмж гаргасан байгууллагын талаар сонсож байхад төрийн байгууллагын журмыг дуурайн хийсэн. Ингэхдээ удирдах зөвлөлд байдаг эрх мэдэл бүхий албан тушаалтны нөлөөлөл их байсан. Ийм төрлийн бичиг баримт боловсруулалт дээр төртэй харилцан суралцан ажиллах хэрэгтэй гэж бодож байгаа учир төрийн албан тушаалтныг ИНБ-аас салган ойлгох нь нэг талаараа өрөөсгөл гэж харж байна” гэж хариулжээ.


Байгууллага үйл ажиллагааны чиглэл, зорилгынхоо хүрээнд нийцсэн үйл ажиллагааг явуулж чадаж байгаа эсэх талаар нийт байгууллагын 80 хувь нь зарим талаараа болон бүх талаараа нийцсэн гэжээ. Судалгаанд оролцогчид “Манай байгууллагын үйл ажиллагааны чиглэл нь судалгаа, үнэлгээ, бодлогын нөлөөллийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Мөн сургалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Үүнтэй холбоотой бэрхшээл гарч байсан. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл байнга авдаг. Хоёр жилийн өмнө энэ зөвшөөрлийг авахад сургалтын кодтой байх ёстой гэсэн шалгуур тавьсан. Гэхдээ улсын бүртгэлийн гэрчилгээн дээр нотолгоонд суурилсан бодлого хөтөлбөр боловсруулах чиглэлээр бүртгэгдсэн байхад заавал тусдаа сургалт гэсэн өөр код авах ёстой зэрэг давхардсан юмнууд их байдаг” гэжээ. Иймд ИНБ-ууд зарим талаараа үйл ажиллагааны чиглэл, зорилгынхоо хүрээнд нийцсэн үйл ажиллагааг явуулж чадахгүй байгаа нь тус судалгааны дүнгээс ч харагдаж байна.



Мөн ИНБ-уудын төлөөлөл "...Үйл ажиллагааны төрөл хэлбэрийг ИНБ-ууд нөлөөллийн үйл ажиллагаа явуулдаг, төрд хяналт тавьдаг, төрийн үйл ажиллагааг үнэлдэг болон төрийн үзүүлж чадахгүй байгаа үйлчилгээг үзүүлдэг гэж ангилж ирсэн. Одоо энэ асуудал дээр анхаарах, илүү нарийвчлах ёстой байна. ИНБ-ууд 4 өөр газарт 4 өөр тайлан илгээдэг боловч ач холбогдол нь гардаггүй. Энэ тайлангуудыг судлан, сүүлийн жилийн үйл ажиллагааны тайлан, улсын бүртгэлд бүртгүүлсэн үйл ажиллагааны чиглэлтэй нийцэж байгаа эсэх гэх мэт асуудалд дүгнэлт гаргаж болно. Гэвч зүгээр л тайлан яваад байдаг. ИНБ-ууд 1990-ээд оноос байгуулагдаад хуулиар зохицуулагдаж байх үед улс орны нийгэм, эдийн засгийн байдлаас болоод үйлчилгээ үзүүлэх, шинэ санаа, шинэ загвар оруулах, шинэ хууль, үзэл санаа оруулах чиглэлээр үйл ажиллагаагаа түлхүү явуулж байсан бол одоо улс орны хөгжлийн шаардлагаас болоод илүү төрд хяналт тавих, төрийн эрх мэдлийг хязгаарлах, төрийн хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд үнэлгээ дүгнэлт өгөх, тендер худалдан авалтад мөрдлөг мөшгөлт хийх, авлига хээл хахуулийн түвшнийг хөндлөнгөөс тодорхойлох, үнэлэх, бодлого хэрэгжилтийн үнэлгээг хийж байх чиг үүрэг рүү хөгжиж байх шиг байна. Энэ чиглэл хэлбэрийг хуульд оруулбал зүйтэй" гэж хариулснаас харахад үйл ажиллагааны чиглэлийн талаар хэлэлцэх хэрэгцээ байгаа нь харагдана. Түүнчлэн, "зарим нэг байгууллагад гишүүдэд чиглэсэн үйл ажиллагаа давхар явуулж байна. Гэвч эдгээр ИНБ-уудын зарим нь гишүүнчлэлтэй боловч өмнө хэлж байсанчлан гишүүнчлэл тухайн байгууллагын шийдвэр гаргалт, удирдлага, зохион байгуулалтад хамааралгүй, тодорхой үйл ажиллагаанд хамрагдах, үйлчилгээ авахаар хязгаарлагдаж байна" гэж хариулсан бол зарим төлөөлөл асуулгад "ИНБ-уудын төрөл, хэлбэр маш замбараагүй байна. Гишүүдтэй болохоор гишүүддээ үйлчилдэг ч юм шиг, эрхэлж буй үйл ажиллагаагаа харах нийтэд үйлчилж, ...эрхийн төлөө яваад байгаа ч юм шиг, холбоо, эвсэл гээд аль хэлбэр ангилал, төрөлд хамаараад байгаа нь тодорхойгүй" гэж хариулжээ.

Иймд ИНБ-ууд зарим талаараа үйл ажиллагааны чиглэл, зорилгынхоо хүрээнд нийцсэн үйл ажиллагааг явуулж чадахгүй байгаа ба тэдгээрийн үйл ажиллагааны чиглэлийн талаар дахин хэлэлцэх хэрэгцээ шаардлага байгаа нь харагдана.

Танай байгууллага үйл ажиллагааны чиглэл, зорилгынхоо хүрээнд нийцсэн үйл ажиллагааг явуулж чадаж байгаа юу? (Жишээ: Хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр ажиллахаар байгуулагдсан бол тэр зорилгынхоо хүрээнд бүрэн ажиллаж байна уу?)



Мөн ИНБ-ууд зорилтот бүлэг болон бусад талтай харилцан мэдээлэл солилцсоныхоо дараа тэдгээрийг шийдвэрлэх хариу алхам байнга хийдэг гэж 51 хувь нь хариулжээ. Хариу алхам хааяа хийдэг гэж 35 хувь нь хариулжээ. Тэдгээрт ямар хариу алхам хийдэг талаар “Албан бичиг хүргүүлэх”, “Уулзалт товлох” гэж олонх байгууллагууд хариулсан байна. Энэ талаар судалгаанд оролцогчид “Жил бүр Улсын бүртгэлийн ерөнхий газар Төрийн бус байгууллагын үйл ажиллагааны тайланг хүлээн авдаг. Тайланг хүлээн аваад дүн шинжилгээ хийдэггүй, нэгдсэн тайлагналт байхгүй, тайлангийн ач холбогдлыг харуулсан систем байхгүй. ИНБ-ууд нь нийгмийн даатгалын ерөнхий газарт, улсын бүртгэлийн ерөнхий газарт, татварын албанд, сангийн яаманд гээд албан ёсны 4 төрлийн тайлан өгөх шаардлагатай байна. Хэрвээ гэрээгээр гүйцэтгэсэн бол гэрээт үйл ажиллагааны тайлан энд бас нэмэгдэнэ. Гэвч эдгээр тайланд ИНБ-ууд зорилтот бүлэг болон бусад талтай харилцан мэдээлэл хэрхэн солилцдог болон түгээдэг, мэдээлэл солилцсоныхоо дараа тэдгээрийг шийдвэрлэх хариу алхам хэрхэн хийдэг зэрэг олон нийт ИНБ-уудыг холбосон зүйл шаардмаар санагддаг. Тэгснээр иргэд олон нийтэд хариуцлагатай байх ойлголтыг ИНБ-уудад ч өгөх юм шиг санагддаг” гэж хариулжээ.

Танай байгууллага зорилтот бүлэг болон бусад талуудтай харилцан мэдээлэл солилцсоныхоо дараа тэдгээрийг шийдвэрлэх хариу алхам хийдэг талаар



Тийм бол ямар хариу алхам/хариу үйлдэл ихэвчлэн хийдэг вэ?



Зорилтот бүлэг болон бусад талтай харилцан мэдээлэл солилцсоныхоо дараа тэдгээрийг шийдвэрлэхийн тулд хийдэг алхмын талаар “Өөр бусад” гэдэг хувилбарыг сонгогсод “Холбон зуучлах, асуудлаас шалтгаалан дээр дурдсан арга хэмжээнүүд, хүний эрхийн акц, активизм явуулдаг, тухайн нөхцөл байдал, шийдвэр боломж зэргийг харгалзан үзэж утсаар холбогдох, тодруулах, уулзалт товлох, и-мэйл бичих, албан бичиг илгээх зэрэг алхамуудыг хийдэг, кейс дээр суурилсан нөлөөлөл хийдэг” зэрэг алхмуудыг дурджээ.

ИНБ-ууд өөрсдийн үйл ажиллагааны ил тод байдлыг хэрхэн хангадаг талаар “Сошиал медиад байршуулдаг”, “Үйл ажиллагааны тухай мэдээллээ вебсайтад байршуулдаг” хэмээн хариулсан байна. Мөн олон нийт, зорилтот бүлгээс санал шүүмж хүлээн авдаг эсэх талаар “үгүй” гэж 41 хувь нь хариулсан байна. “Тийм хааяа” гэж 27 хувь нь хариулсан бол “Тийм, байнга” гэж 12 хувь нь хариулсан байна.

Өөрсдийн үйл ажиллагааны ил тод байдлыг хэрхэн хангадаг вэ? (Олон хариулт сонгож болно)



ИНБ-ууд өөрсдийн үйлчилгээний ил тод байдлын талаарх асуулгад “Өөр бусад” гэдэг хувилбарыг сонгосон судалгаанд оролцогчид “Улирал тутам цахим товхимол гаргадаг, улсын бүртгэлийн газарт жил бүр тайлангаа илгээдэг, хаалттай групптээ мэдээллээ оруулдаг, албан бичиг илгээх зэрэг алхамуудыг хийдэг, зорилтот бүлгийг оролцуулан судалгаа, холбогдох мэдээллийг хүргэдэг” зэрэг мэдээлэл хүргэх аргуудыг дурджээ.

Олон нийт, зорилтот бүлгээс санал шүүмж хүлээн авдаг эсэх талаар



Байгууллагынхаа үйл ажиллагааг ил тод байршуулж, мэдээлэхэд ИНБ-ууд “Хэрхэн ил тод болгох тухай зааварчилгаа”, “Ил тод байршуулах платформ” маш их хэрэгтэй гэж 60-аас дээш хувь нь хариулжээ. Мөн ярилцлагын судалгаанд оролцогчид “ИНБ-ын үйл ажиллагааны талаар, хэдэн хүнд хэрхэн хүрсэн зэрэг үйл ажиллагааны чанар, тогтвортой байдлыг үнэлэхэд мэдээллээ ил тод байршуулах нь чухал ач холбогдолтой. Үүнтэй зэрэгцэн, өнөөгийн хууль тогтоомжид тусгагдсан ИНБ-ын тайлангийн төрөл, шалгуур, болзлууд өөр хоорондоо зөрүүтэй, төвөгтэй байгааг эдгээр тайлангаар харуулах хэрэгтэй. Үйл ажиллагаагаа ил тод байрлуулаагүй ИНБ-ууд, үйл ажиллагаа нь идэвхгүй ИНБ-уудыг эдгээр тайлангаар дүгнэж, шүүмжлэлтэй хандаж болох юм” гэж хариулжээ.

Байгууллагынхаа үйл ажиллагааг ил тод байршуулж, мэдээлэхэд танайд дараах зүйлс хэр хэрэгцээтэй вэ?





Funded by
the European Union



DW Akademie



MEDIA
COUNCIL OF
MONGOLIA



Байгууллагынхаа үйл ажиллагааг ил тод байршуулж, мэдээлэхэд хэрэгцээтэй зүйлсийн талаар “Өөр бусад” гэдэг хувилбарыг сонгосон оролцогчид “Мэдээллийг сонирхолтой олон хэлбэрээр хүргэх арга барилд суралцах, платформ хэрхэн ашиглах технологийн мэдлэг, сошиал медиа суваг тус бүрийн онцлог, анхаарах зүйлс, мэдээлэл хүргэх ес зүй, хүний эрх, жендэрийн мэдрэмж, мэдээлэх ур чадвар, ил тод байгаа байдалд нь мониторинг хийх тогтолцоо их хэрэгцээтэй, нийгмийн сүлжээ, олон нийтийн сүлжээнд ажиллах ур чадвар” гэх мэт хэрэгцээ шаардлагуудыг дурджээ.

4. ДҮГНЭЛТ

ИНБ-УУД ӨӨРИЙГӨӨ ХЭРХЭН ҮНЭЛЖ, ОЙЛГОЖ БАЙНА ВЭ?

Олон улсын нийтлэг жишгээр ИНБ-ууд өөрийн байгууллагын үндсэн зорилго, чиг үүргийг хангахын сацуугаар үйлчилгээний ур чадварыг байнга дээшлүүлэх, үйл ажиллагааны хэм хэмжээний түвшинг тогтоож, нийгэмд үйлчлэх мэргэжлийн ёс зүй, ил тод байдал эгэх хариуцлагыг сахиулах нь ИНБ-уудын үндсэн зорилго, чиг үүрэг нь байдаг. Эдгээрийг хангахын тулд хэвлэл мэдээллийн сувгуудыг үр бүтээлтэйгээр ашиглаж буй нь түгээмэл байна. Ингэхдээ ИНБ-ууд хоёр урсгалт тэгш харилцааны загвар ашиглах нь олон нийттэй харилцах хамгийн боловсронгуй, ёс зүйтэй практик гэж үздэг. Өмнөх хэсэгт дурдсанчлан энэ загвар нь ИНБ болон түүний гол оролцогч талуудын хооронд харилцан ашигтай харилцааг бий болгож, тэдгээрийг тогтвортой байлгах яриа хэлэлцээнд төвлөрөн бусад оролцогч талуудын адил нийгэмд хамтдаа үйлчлэх нэгж гэх ойлголт дор мэдээлэл харилцааны үйл ажиллагаа явагддаг.

Судалгааны эхний хэсэгт ИНБ-уудын мэдээлэл харилцааны хүрээнд төрийн байгууллага, хэвлэл мэдээлэл, олон нийт төдийгүй бусад ИНБ зэрэг оролцогч талуудтай харилцахад тулгарч буй бэрхшээл, мэдээлэл харилцааны боломжуудын талаарх ойлголт болоод түүнд тулгуурлан нийгмийн эгэх хариуцлага, ил тод байдлыг хангах арга барилуудыг танилцуулсан. Харин хоёр дахь хэсэг Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй ИНБ-уудын эгэх хариуцлага болон ил тод байдал, мэдээлэл харилцааны төлвийг тодорхойлж, өнөөгийн нөхцөл байдал, тулгамдсан асуудал гол сорилт, боломжуудад дүн шинжилгээ хийж, тэдгээрийн чадавхийг үнэлэх зорилготой ба үүнд чанарын болон тоон аргыг ашигласан. Мэдээлэл цуглуулалтад баримт бичгийн шинжилгээ, нийт 124 ИНБ-ын төлөөлөгчийг хамруулсан асуумж судалгаа, тодорхой тооны төлөөлөлтэй гүнзгийрүүлсэн ганцаарчилсан ярилцлага зэрэг тоон болон чанарын аргуудаас бүрдсэн холимог аргыг ашиглалаа.

Судалгааны дүнгээс харахад ИНБ-уудын дийлэнх нь үндсэн чиг үүргийнхээ хүрээнд үйл ажиллагаа явуулахын сацуугаар үйл ажиллагааныхаа ач холбогдлыг олон нийтэд түгээн таниулах, иргэд олон нийтэд ил тод мэдээлэл түгээх нь дутмаг байна. Түүнчлэн, зорилтот бүлэгт байгууллагын үйл ажиллагааны тухай сүүлийн үеийн мэдээллийг хүргэх зорилтот бүлгийг мэдлэгжүүлэх, чадавхжуулах мэдээллийг түгээх төдийхнөөр мэдээлэл харилцааг хэрэглэж байгаа нь чамламаар дүнг харуулж байна. Ингэхдээ ихэнх нь буюу судалгаанд оролцсон ИНБ-уудын 95 хувь нь мэдээлэл түгээх сувгуудаас “Фэйсбүүк”-ийг түлхүү ашигладаг гэж хариулсан нь мэдээлэл харилцааны сувгуудыг бүрэн дүүрэн ашиглахгүй байгаа нь харагдана. Харин орон нутагт үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд “Ихэвчлэн утсаар болон биечлэн уулздаг”, “Өөрөө биечлэн болон утсаар мэдээлэл өгдөг” мөн “Орон нутгийн телевизэд ханддаг” зэргээр уламжлалт сувгуудыг түлхүү ашиглаж байна.

Мэдээлэл харилцааны сувгуудыг ашиглахад хүндрэл бэрхшээлтэй зүйл ихтэй ч, цаашид өөрсдөө суралцахын хажуугаар хэвлэл мэдээллийн хэрэгслүүдтэй хамтран

ажиллахад хэн хэнийхээ боломжийг харах, харилцан ойлголцох асуудлаар шийдэлд хүрэх нь чухал гэж судалгаанд оролцсон ИНБ-уудын төлөөлөл дурдсан. Энэ нь цаашдын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд олон төрлийн боломж байгаа ба шинэ гарц гаргалгаа чухлыг илтгэнэ. “Хэвлэл мэдээлэлтэй хамтарч ажиллах мэргэшсэн бүлгүүд байвал үр дүнтэй болох байх гэж боддог. Тухайлбал нарийн төвөгтэй нөхцөл байдлын үед сэтгүүлчид сурвалжилга авсан ч асуудлынхаа гол мөн чанарыг мэддэггүй учраас үзэгч, сонсогчийн нэг үгэнд бүдрэх тохиолдол бий. Тиймээс сэтгүүлчдийг сурвалжилж буй сэдвээр нь зохих мэдээлэлтэй болгож, чадавхжуулах нь чухал гэж бодож байна. Өөрөөр хэлбэл сэтгүүлчид салбар салбараар мэргэшвэл сайн. Бид ч энэ талаар сургалт орж болно” зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй хэрхэн хамтрах талаар зарим зөвлөгөө, шинэ санааг дэвшүүлж байв.

Сүүлийн жилүүдэд Фэйсбүүк зэрэг олон нийтийн сүлжээнд иргэдийн оролцоо нэмэгдэхийн хирээр Монголын улс төрд сүүлийн жилүүдэд үгүйлэгдээд байсан сөрөг хүчний үүрэг ролийг иргэний нийгэм гүйцэтгэх болсон нь ИНБ-уудын хувьд олон нийттэй харилцах нэг төрлийн боломж юм. 2023 онд 2.6 сая интернэт хэрэглэгч буюу Монголын нийт иргэдийн 80 орчим хувь нь дата холболттой хэдий ч, нийгмийн сүлжээнд суурилсан ИНБ-уудын цахим оролцооны нөлөөллийг тодорхойлох нэгдсэн мэдээлэл, өмнө хийгдсэн судалгаа байхгүй байна. Гэвч олон нийтийн сүлжээгээр дамжуулан иргэд олон нийтэд өөрсдийн үйл ажиллагааг танилцуулан, тэдгээрийн дэмжлэгтэйгээр төр, засгийн болон холбогдох байгууллагуудын шийдвэрүүд өөрчлөгдсөн тохиолдлууд бий.

Түүнчлэн Монгол Улсын Засгын газраас цахим шилжилтийг дэмжиж, хөгжүүлэх “Цахим үндэстэн” хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Төрийн үйлчилгээний ихэнх нь цахим платформ руу шилжиж байгаа өнөө үед төрийн үйлчилгээтэй холбоотой дагалдах ажлууд ч ар араасаа цахимжсаар холбогдох ажилтны ур чадварыг нэмэгдүүлэх шаардлага төрд ч гарч байна. Судалгааны хүрээнд ИНБ-ууд үйл ажиллагааны мэдээлэл түгээхдээ Фэйсбүүк ашигладаг хэмээн хариулсан авч судалгаанд хамрагдсан нийт ИНБ-уудын бараг 95 хувь нь цахим ур чадвараа сайжруулах шаардлагатай гэж хариулжээ. Энэ нь өөрсдийн цахимаар болон интернэтээр мэдээлэл түгээхэд ашиглах ур чадвар хангалттай бус байгааг илтгэж байна.

ИНБ-ууд бусад ИНБ-тай бүрэн хамтарч ажиллах боломжтой байгаа ч, энэ талаар дорвитой алхам, нэгдсэн систем байдаггүй гэж дүгнэжээ. Өмнөх судалгааны дүнгүүдтэй харьцуулахад өмнө тулгарч байсан бэрхшээлүүд өнөөдөр ч хэвээрээ байгааг тус судалгаанаас харж болох юм. Бусад ИНБ-тай харилцах харилцааны хувьд шинэ, залуу ИНБ, эсвэл өөр чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудын хувьд мэдээлэл солилцох, эргэх холбоо багатай байдаг. Зарим төрлийн ИНБ-тай чиг үүргийн хувьд хамтрах боломжгүй байдаг бөгөөд зарим ИНБ-тай хамтрах нь үйл ажиллагааг илүү чанаржуулах, үг өгөөжтэй болгох байгууллагууд түгээмэл байна. Гэвч “Бусад ИНБ-ын шийдвэр, үйл ажиллагааг илүү сайжруулах зөвлөмж өгөхөд, сөргөөр хүлээн авах, цаашид хамтран ажиллахаас татгалзах, хувь хүний хувьд дарамтлах зэрэг хүндрэл бэрхшээл өмнө гарсан. Зөв шүүмжлэл гэдэг ойлголтыг цаашид бусад ИНБ-

тай хамтран ажиллах дүрэм журамд оруулах, хэрхэн харилцан хариу арга хэмжээ авах аргыг ёс зүйн дүрэмд оруулах хэрэгтэй санагдана” гэж хариулжээ. Иймд бусад ИНБ-тай хамтран ажиллахад анхаарах зүйл болон ёс зүйн дүрэм журмын талаар мэдлэг ойлголтыг (бусад улсын мэдээлэл харилцаанд баримтлах жишиг ёс зүйн дүрэм зэрэг) өгөх сургалтууд хэрэгцээтэй байна.

Мөн төрийн байгууллагатай харилцаа болон хамтын үйл ажиллагаа өргөжиж байгаа ч харилцан бие биедээ үл итгэсэн байдал өнөөг хүртэл байсаар байна. Гэвч ИНБ-ууд төрийн ажлыг гэрээгээр хийх бүрэн боломжтой гэж өөрсдийгөө үнэлж байгаа ба цаашлаад “ИНБ-аар гүйцэтгүүлэх ажлыг нэмэгдүүлэх”, “Төрийн ямар чиг үүргийг ИНБ хэрэгжүүлэх боломжтойг ил тод болгох”, “Төр нь ИНБ-тай хамтран ажиллах боломжтой ажлын жагсаалт гаргах, төлөвлөлтдөө тусгах” зэрэг арга хэмжээг авах хэрэгтэй гэж дурдсан байна. Энэ нь одоо байгаа хамтын ажиллагааг дахин нэг шат өргөжүүлэх хэрэгцээтэй талаар өнөөгийн нөхцөл байдлыг харуулах ба ИНБ-ууд өөрсдийгөө төрийн чиг үүргийг гүйцэтгэх боломж бололцоо, ур чадвар, мэдлэг нь сайжран нэмэгдсэн гэж үнэлжээ. Мөн төртэй байнгын харилцааг өргөжүүлэхийн тулд, “Тогтмол яриа хэлэлцээр өрнүүлдэг платформуудтай болох”, “Бодлогын нөлөөлөл хийх, үр дүнтэй зөвшилцөл хийх арга техникт суралцах” нь чухал гэж хариулсан байна. Иймд төслийн багийн зүгээс ИНБ-уудад төрийн байгууллагуудтай үр дүнтэй зөвшилцөл хийх арга техникт суралцах, мэдээлэл харилцааны ур чадварын сургалт орох нь чухал гэж харж байна.

ИНБ-ууд төр болон бусад ИНБ-тай харилцахад нэн тэргүүнд авах арга хэмжээний талаар ИНБ-уудын чиг үүрэг, зорилтот бүлгээс хамааран харилцан адилгүй саналтай байгааг ч тус судалгааны дүнгүүдээс харж болох юм. Энэ талаар ИНБ-ууд өөрсдийгөө тухайлбал, “Хөгжлийн бодлогоо зөв тодорхойлох шаардлагатай байна. Төртэй хамтрах болон төрөөс ангид байх, бусад ИНБ-тай хамтрах болон ангид байх мэргэжлийн чиглэлүүдийг тодорхойлж, урт хугацаанд хамтарч төлөвлөх нь хамтран ажиллах үйл ажиллагааны хүрээг тодорхойлоход чухал ач холбогдолтой” гэж дүгнэжээ.

Байгууллагынхаа үйл ажиллагааг ил тод байршуулж, эгэх хариуцлагыг нэмэгдүүлэхэд, ИНБ-ууд “Хэрхэн мэдээллээ ил тод болгох тухай зааварчилгаа”, “Ил тод байршуулах платформ” маш их хэрэгтэй гэж 60-аас дээш хувь нь хариулжээ. Мөн ярилцлагын судалгаанд оролцогчид “ИНБ-ын үйл ажиллагааны талаар хэдэн хүнд хэрхэн хүрсэн зэрэг үйл ажиллагааны чанар, тогтвортой байдлыг үнэлэхэд мэдээллээ ил тод байршуулах нь чухал ач холбогдолтой. Үүнтэй зэрэгцэн өнөөгийн хууль тогтоомжид тусгагдсан ИНБ-ын тайлангийн төрөл, шалгуур, болзлууд өөр хоорондоо зөрүүтэй, төвөгтэй байгааг эдгээр тайлангаар харуулах хэрэгтэй. Үйл ажиллагаагаа ил тод байрлуулаагүй ИНБ-ууд, үйл ажиллагаа нь идэвхгүй ИНБ-уудыг эдгээр тайлангаар дүгнэж, шүүмжлэлтэй хандаж болох юм гэж хариулжээ. Иймд үйл ажиллагааг ил тод байршуулах платформ хэрэгтэй байхын сацуугаар ямар төрлийн мэдээллийг хэрхэн зөвөөр ил тод байрлуулах сургалт хэрэгцээтэй байна.

5. ЗӨВЛӨМЖ

Олон улсад хүний эрхийг хангасан, иргэдийн оролцоо, хяналт бүхий иргэний нийгмийг цогцлоохын тулд нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс ИНБ-ыг байгуулах, иргэний чөлөөтэй эвлэлдэн нэгдэх эрх хангагдсан байх нь нэн чухал гэж үздэг. Өөрөөр хэлбэл “Ардчилал”-ын суурь зарчим болох төрийн эрх мэдлийн хуваарилалт, хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилт, төрийн үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хараат бус хяналтын төлөвшилт нь сайн дураар эвлэлдэн нэгдсэн нийтлэг эрх ашиг, үнэт зүйлсийн төлөөх ИНБ-уудын идэвхтэй оролцооноос шууд хамаардаг.

Бидний судалгааны хүрээнд хамрагдсан ИНБ-уудын төлөөлөл мэдээлэл харилцааны сувгаар дамжуулан үйл ажиллагаагаа сурталчлан таниулан, иргэдэд мэдээлэл түгээж улмаар иргэдийн оролцоог нэмэгдүүлэн төр, засгийн болон холбогдох байгууллагуудын шийдвэрт нөлөөлөх оролдлого хийж байгаа нь түгээмэл байна. Мөн төрийн байгууллага болон бусад ИНБ-тай идэвхтэй харилцан, үйл ажиллагаагаа хөгжүүлэхийн сацуугаар өргөтгөх ажлуудыг оролдож байгаа нь харагдана. Ингэхдээ иргэд олон нийтэд ил тод мэдээлэл өгөн, санал, шүүмж хүсэлтэд олон нийтэд нээлттэй хариулах зэргээр эгэх хариуцлагыг тодорхой хэмжээнд хэрэгжүүлж байна. Гэсэн хэдий ч зарим нэг анхаарах асуудал, дутагдал, хүндрэл байсаар байгааг тус судалгааны дүгнэлт хэсэгт бид тоймлон оруулсан.

ИНБ-уудын цаашдын хөгжлийг тодорхойлон, үйл ажиллагааг өргөжүүлэхэд олон төрлийн боломж харагдах ба тэдгээр гарц гаргалгааг доор багцлан оруулав.

НЭГ. ИНБ-УУДЫН МЭДЭЭЛЭЛ ХАРИЛЦААНЫ СУВГУУДЫГ ХЭРЭГЛЭХ ЧАДАМЖ, МЭДЛЭГИЙГ САЙЖРУУЛАХ

- ИНБ-уудын хэвлэл мэдээлэл, мэдээллийн боловсрол, хэвлэлийн мэдээ бичих, баримтыг нягтлан шалгах зэрэг сэдвийн хүрээнд мэдээлэл харилцааны сувгуудыг ашиглах ур чадварыг нэмэгдүүлэх
- Мэдээлэл харилцааны сувгуудыг байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагааны явцтай уялдуулан, тухайн нөхцөлд тохирох сувгийг хэрэглэх, ашиглах тухай ИНБ-ын дотоод журамд тусгах
- Хэвлэл мэдээллийнхэнтэй тогтмол харилцаа холбоо тогтоох харилцааны ур чадварыг нэмэгдүүлэх
- ИНБ болон ХМБ-н хамтарсан менторшип хөтөлбөр хэрэгжүүлэх
- ИНБ-уудын үйл ажиллагааны чиглэл, зорилтот бүлгийн онцлогт тохирсон мэдээлэл харилцааны ажлын урт хугацааны төлөвлөгөө боловсруулах
- Олон нийттэй харилцах ажилд шаардлагатай харилцааны урлагт суралцах

ХОЁР. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА БОЛОН БУСАД ИНБ-ТАЙ ХАРИЛЦАХ ХАРИЛЦААГ САЙЖРУУЛАХ

- ИНБ-ын ажилтан бүр байгууллагынхаа үйл ажиллагааны чиглэл, зорилгыг ухамсарлан, ойлгосон байх, хариуцлагын төдийгүй ёс зүйн дүрэмтэй байх
- Бусад ИНБ-тай хамтран ажиллах дүрэм журам боловсруулах, хэрхэн харилцан хариу арга хэмжээ авах аргыг ёс зүйн дүрэмд оруулах
- Төртэй хамтран ажиллах боломжтой ажлын жагсаалт гаргах, төлөвлөлтдөө тусгах
- Тогтмол яриа хэлэлцээр өрнүүлэх платформтой болох
- Бусад ИНБ болон төртэй харилцахад нэн тэргүүнд шаардлагатай хууль эрх зүйн мэдлэгийг (Засгийн газрын мөрийн хөтөлбөр, ИТХ-ын тэмдэглэл, Шүүхийн шийдвэр зэрэг) олж авах арга хэрэгсэлд суралцах
- Төртэй хамтрах болон төрөөс ангид байх, бусад ИНБ-уудтай хамтрах болон ангид байх мэргэжлийн чиглэлүүдийг төр болон ИНБ-уудтай хамтран тодорхойлох
- Төртэй хамтрах болон төрөөс ангид байх, бусад ИНБ-уудтай хамтрах болон ангид байх үйл ажиллагааны жагсаалтыг "Хөгжлийн бодлого"-доо тусгах
- Бусад оролцогч талууд болох төр, ИНБ, иргэд олон нийттэй харилцах мэдээлэл харилцааны ажлын асуудлаар нэгдсэн заавар, чиглэл гаргах, мэдээ мэдээллийг нийтлэх ажиллагаанд жигдрээгүй, нэгдсэн үйл ажиллагаа хэвшээгүй бусад ИНБ-уудад мэргэжил, арга зүйн тусламж тогтмол үзүүлэх, нийтлэх ажиллагаанд гарч буй алдаа дутагдлыг байнга хамтран судлах.

ГУРАВ. ИНБ-УУДЫН ЭГЭХ ХАРИУЦЛАГА ИЛ ТОД БАЙДЛЫГ НЭМЭГДҮҮЛЭХ

- ИНБ-ууд мэдээ мэдээллийг "нээлттэй" болон "хаалттай" байхаар ангилах
- Дотоод журамдаа ямар мэдээллийг хэрхэн ил тод болгох тухай оруулах, нэг стандартаар мөрдүүлж хэвшүүлэх
- ИНБ-ууд мэдээллийг хэрхэн ил тод болгох арга хэрэгсэлд суралцах
- Мэдээ мэдээллийг журам, дүрэмд заасан шаардлагад нийцүүлэн, хугацаанд нь бүрэн байршуулах
- Веб хуудас зэрэгт мэдээ мэдээллийг байршуулж буй дэд зохицуулагч буюу "админ"-ы эрхийг зөвхөн мэргэшүүлж сургасан олон нийттэй харилцах мэргэжилтэнд олгох
- ИНБ-уудад мэргэшүүлж сургасан олон нийттэй харилцах мэргэжилтний орон тоо байхгүй нөхцөлд, хэрхэн хавсран хийх талаар дотоод дүрэм журамд оруулах



Funded by
the European Union



DW Akademie



MEDIA
COUNCIL OF
MONGOLIA



ДӨРӨВ. БОДЛОГО БОЛОВСРУУЛАХ ТҮВШИНД ИНБ-УУДЫН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ

- Төр/орон нутгийн захиргааны байгууллагын ИНБ-уудын талаар ойлголтыг дараагийн түвшинд хүргэх, оролцоог нэмэгдүүлэхэд нөлөөлөх кампанит ажил
- ИНБ-уудын оролцоо, бодлогын нөлөөллийг нэмэгдүүлэх шийдлийг эрэлхийлэх
- ИНБ-уудын дуу хоолойг иргэдэд хүргэх цахим кампанит ажил

6. ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. Anderson, B. (1983). Imagined communities: Reflections on the origin and spread of nationalism. Verso books.
2. Brugnoli, E., Gravino, P., & Prevedello, G. (2023, September). Moral values in social media for dis-information and hate speech analysis. In International Workshop on Value Engineering in AI (pp. 67-82). Cham: Springer Nature Switzerland.
3. Draft Concept on the Development of Civil Society in Mongolia https://www.uih.mn/upload/sudal-gaa/files/68_8413326.pdf, 2024 он 5 сарын 14
4. Edwards, V. L. (2013). A theory of participation for 21st century governance. International Journal of Organization Theory & Behavior.
5. Harvey, B. L. (2010). Speaking to power: The discursive shaping of Southern communities and institutions in international development cooperation.
6. Harvey, L., Mason, S., & Ward, R. (1995). The role of professional bodies in higher education quality monitoring. Birmingham: QHE.
7. Kutay, A. (2015). after governance: a normative reflection on civil society participation in policy processes. Tidsskriftet Politik, (2), 24-32.
8. Kutay, A. (2021). Global Governance, Public Sphere, and CSOs. In NGOs, Civil Society and Structural Changes (pp. 153-180). Cham: Springer International Publishing.
9. Liu, B. F., & Horsley, J. S. (2007). The government communication decision wheel: Toward a public relations model for the public sector. Journal of Public Relations Research, 19(4), 377-393.
10. PRSA Code of Ethics, <https://www.prsa.org/about/prsa-code-of-ethics>, 2024 он 7 сарын 1
11. Reed, S. R. (2010). Japanese prefectures and policymaking. University of Pittsburgh Pre.
12. SPJ Code of Ethics, <https://www.spj.org/ethicscode.asp>, 2024 он 7 сарын 1
13. Theunissen, P., & Rahman, K. A. (2011). Dialogue and two-way symmetrical communication in public relations theory and practice. In Australian and New Zealand Communication Association Annual Conference (pp. 1-20).
14. Walzer, M. (1995). The concept of civil society. Toward a global civil society, 7.
15. Zyl, Albert. "How civil society organizations close the gap between transparency and accountability." Governance 27.2 (2014).
16. МУИС, Конрад Аденауэрын сан, Монгол дахь Ардчилал, иргэний нийгмийн өнөөгийн байдлын талаарх нийгэм-улс төрийн судалгааны үр дүн, бодлогын зөвлөмж, 2020 он
17. СИВИКУС олон улсын байгууллагаас гаргасан иргэний нийгмийн төлөв байдлын тайлан – 2023, <https://www.civicus.org/index.php/state-of-civil-society-report-2023/>, 2024 он 6 сарын 2
18. Тогтвортой хөгжлийн зорилго. <https://sdg.1212.mn/>. 2024 он 5 сарын 12
19. Үндэсний статистикийн хороо, "Эс Ай Си Эй" ХХК (SICA LLC), Иргэний нийгмийн Консорциум. "Иргэний орон зайн төлөв байдал, түүнийг дэмжих эрх зүйн таатай орчны хэрэгцээ шаардлагыг тодорхойлох судалгаа", 2021 он, Улаанбаатар
20. Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим, <https://www.mediacouncil.mn/p/7>, 2024 он 7 сарын 1
21. Цэрэндорж.Д, Ариунаа.Л, Алтайбаатар.Ж, Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллага, хувийн хэвшилд шилжүүлэх нь, 2010 он
22. ШУТИС-ийн Нийгмийн технологийн сургууль. Олон нийттэй харилцах ажил, 2013 он

7. ХАВСРАЛТ

ХАВСРАЛТ 1: ТООН СУДАЛГААНЫ АСУУЛГА

Монголын иргэний нийгмийн байгууллагуудын эгэх хариуцлага, ил тод байдал, мэдээлэл харилцааны өнөөгийн нөхцөлийг тодорхойлох судалгаа

Сайн байна уу?

Энэхүү судалгааг Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс ХБНГУ-ын Дойче Велле Академитай хамтран Европын Холбооны дэмжлэгээр хэрэгжүүлж буй “Өөрчлөлтийн дуу хоолой: ИНБ-ууд эгэх хариуцлага, ил тод байдал, олон нийтийн ойлголтыг сайжруулахын төлөө хүчээ нэгтгэх нь” төслийн хүрээнд явуулж байна.

Судалгаанд хамрагдсанаар та иргэний нийгмийн хэрэгцээ шаардлага, хүндрэл бэрхшээл, нөөц чадавхыг тодруулах, улмаар уг чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэхэд үнэтэй хувь нэмрээ оруулах юм.

Судалгааны үр дүнд үндэслэн төслийн зүгээс ИНБ-уудыг чадавхжуулах зураглалыг Монголын болон олон улсын экспертүүдийн чиглүүлэгт тулгуурлан боловсруулж, хэрэгжүүлнэ. Эдгээр нь:

- Сургалтын арга зүй, хэвлэл мэдээлэл, мэдээллийн боловсрол, баримтыг нягтлан шалгах зэрэг сэдвийн хүрээнд чадавх бэхжүүлэх
- Иргэний нийгмийг хөгжүүлэх улс төр, эрх зүйн таатай орчныг бүрдүүлэхийн тулд төрийн байгууллага, хэвлэл мэдээлэл зэрэг оролцогч талуудтай хамтрах, харилцан нөлөөлөх
- Иргэний нийгмийн үйл ажиллагааг олон нийтэд таниулахын тулд хэвлэл мэдээлэл, иргэний нийгэм хамтран ажиллах
- Иргэний нийгмийн үйл ажиллагааг тогтвортой хөгжлийн зорилтуудтай нийцүүлэн хөгжүүлэхэд дэмжлэг авах
- Иргэний нийгмийн үйл ажиллагаанд тохирсон цахим шийдлийг бий болгох зэрэг болно.

Иймд, ИНБ-уудыг Монгол дахь иргэний нийгмийг чадавхжуулан бэхжүүлэх үйлсэд санаачилга гаргаж, хамтран ажиллахыг урьж байна

Дээр дурдсан үйл ажиллагаа нь 2024-2026 онд хэрэгжинэ.

Судалгааны хүрээнд бүрдүүлсэн мэдээллийг төсөлд оролцогч ИНБ-ыг чадавхжуулахад зориулна. Судалгааны хүрээнд бүрдүүлсэн мэдээллийг нэг бүрээр бус нэгдсэн дүн байдлаар гаргах бөгөөд та энэхүү судалгаанд оролцсоноор уг нөхцөлийг хүлээн зөвшөөрсөнд тооцогдоно.

Хамтран ажиллаж буйд баярлалаа.

Нэг. Ерөнхий мэдээлэл

1. Байгууллагын нэр
2. Байгуулагдсан он
3. Идэвхтэй үйл ажиллагаа явуулсан хугацаа (жилээр)
4. Үйл ажиллагааны чиглэл
-
-
5. Ажиллагсдын тоо
 Үүнээс байнгын тогтмол цалинтай ажлын байрны/ажиллагсдын тоо
 Тогтмол бус, түр/гэрээгээр ажиллаж буй ажлын байрны/ажиллагсдын тоо
 Сайн дурын ажилтны тоо (цалингүй)
6. Байгууллагын хаяг, имэйл, утас:

ХОЁР. МЭДЭЭЛЭЛ ХАРИЛЦААНЫ СУВГУУД

Эдгээр асуулт нь танай байгууллагын мэдээлэл харилцааны ажил, цаашдын хэрэгцээг тодорхойлоход чиглэж буй. Уг асуулгын дүнд үндэслэн иргэний нийгмийн байгууллагууд мэдээлэл харилцааны ажлын үр дүн, нөлөөг сайжруулах боломжтой.

1. Танай байгууллагын үйл ажиллагаа нийгмийн ямар бүлэгт чиглэдэг вэ? (Олон хариулт сонгож болно)

1. Олон нийт
2. Хүүхэд, залуучууд
3. Хөдөө орон нутгийн иргэд
4. Шийдвэр гаргагч, бодлого боловсруулагчид
5. Хэвлэл мэдээлэл
6. Ахмад настан
7. Хөгжлийн бэрхшээлтэй болон нийгмийн бусад бүлгийн иргэд
8. Багш, судлаач, эрдэмтэд
9. Өөр бусад /бичнэ үү/

2. Танай байгууллагад зорилтот бүлэгтээ хандсан мэдээлэл түгээх хэрэгцээ хэр зэрэг байдаг вэ? (Нэг хариулт сонгоно)

1. Зайлшгүй хэрэгцээтэй, үүнгүйгээр яагаад ч явахгүй
2. Бусад ажилтай харьцуулахад чухалдаа орно
3. Түвэгтэй ч хийхээс өөр аргагүй ажил юм
4. Ийм ажил хийх цаг байхгүй

3. Ямар төрлийн мэдээллийг зорилтот бүлэгтээ түгээдэг вэ?**(Олон хариулт сонгож болно)**

1. Байгууллагын үйл ажиллагааны тухай сүүлийн үеийн мэдээлэл
2. Цаг үеийн шинжтэй мэдээлэл (сошиал медиад хэлэлцэгдсэн сэдэв гм)
3. Улс төр, эрх зүйн орчны өөрчлөлттэй холбоотой мэдээлэл
4. Салбарт өрнөж буй дотоодын үйл явдал, шинэ мэдээ мэдээлэл
5. Олон улсад өрнөж буй үйл явдал, чиг хандлага
6. Зорилтот бүлгийг мэдлэгжүүлэх, чадавхжуулах мэдээлэл
7. Судалгаа, сурах бичиг, дата сан гэх мэт
8. Сайн туршлага
9. Өөр бусад /бичнэ үү/
10. Дээрхийн аль нь ч биш

4. Танай байгууллага мэдээлэл түгээх дараах сувгуудаас алийг нь ихэвчлэн ашигладаг вэ?

1. ХМХ-д зориулж бэлдсэн хэвлэлийн мэдээ
2. Ньюслеттер
3. Өөрийн вэб сайт
4. Фэйсбүүк
5. Youtube
6. Инстаграм
7. Твиттер (X)
8. Тик ток
9. Подкаст
10. Өөр бусад
11. Дээрхийн аль нь ч биш

5. Танай байгууллага зорилтот бүлэгтэйгээ харилцах, мэдээлэл солилцохын тулд дараах биечилсэн/танхимын арга хэмжээг зохион байгуулдаг уу?

1. Хамтарсан уулзалт, хэлэлцүүлэг
2. Мэдэгдэл, уриалга гаргах
3. Сэдэвчилсэн форум, симпозиум
4. Жагсаал, цуглаан гм
5. Үзэсгэлэн
6. Өдөрлөг
7. Бусад
8. Дээрхийн аль нь ч биш

6. Танай байгууллагад зорилтот бүлэгтээ зориулан мэдээлэл түгээх, олон нийттэй харилцахад зориулсан төсөв байдаг уу?

1. Мэдээлэл харилцааны ажилтан эсвэл уг үйл ажиллагаанд зориулсан тогтмол төсөвтэй
2. Онцгой тохиолдолд (жишээлбэл донор байгууллагын санхүүжилтээр) олон нийттэй харилцах ажилд төсөв зарцуулдаг
3. Олон нийттэй харилцах, мэдээлэл түгээх сувгуудыг үнэ төлбөргүй ашигладаг
4. Олон нийттэй харилцах ажлыг явуулах чадавх, нөөц байхгүй
5. Өөр бусад

7. Танай байгууллагын зүгээс мэдээлэл түгээхэд болон мэдээлэл харилцааны ажил явуулахад ямар хүндрэл бэрхшээл гардаг вэ?

1. Хүний нөөц дутагдалтай
2. Ажилтны хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах мэдлэг, ур чадвар
3. Төсөв санхүүжилт
4. Техник хэрэгсэл дутмаг, ашиглах чадамж сул
5. Мэдээлэл харилцааны сувгуудыг хэрэглэх чадамж, мэдлэг
6. Өөр бусад

8. Танай байгууллагын мэдээлэл харилцааны сувгуудын хүртээмжийг сайжруулахын тулд ямар төрлийн сургалт/үйл ажиллагаа явуулбал хэрэгцээтэй байна вэ?

ГУРАВ. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛТЭЙ ХАРИЛЦАХ НЬ

Энэ хэсэг дэх асуултуудад хариулснаар та хэвлэл мэдээлэл болон иргэний нийгмийн байгууллагуудын харилцан ойлголцолд тулгарч буй хүндрэл, бэрхшээлийг тодорхойлж, түүнийг даван туулах, хамтын ажиллагааг сайжруулах арга замыг эрэлхийлэхэд хувь нэмрээ оруулна.

1. Танай байгууллагын үйл ажиллагааг сурталчлан таниулахад ямар төрлийн хэвлэл мэдээлэл хамгийн тохиромжтой гэж үзэж байна вэ?

1. Сонин (бичих)
2. Сэтгүүл (бичих)
3. Мэдээллийн сайт (бичих)
4. Телевиз (бичих)
5. Радио (бичих)

2. Яагаад энэ мэдээллийн хэрэгслийг сонгосон бэ?

1. Танил хүн тэнд ажилладаг

2. Хүртээмжтэй, нэр хүндтэй ХМХ учраас
3. Хамтран ажиллах гэрээтэй
4. Бидний мэдээллийг үнэ төлбөргүй гаргахыг зөвшөөрсөн
5. Дуудахад ирсэн учраас
6. Манай байгууллагын зорилго, үйл ажиллагааг дэмждэг
7. Өөр бусад

3. Та дараах зүйлстэй хэр зэрэг санал нийлж байна вэ?

	Бүрэн санал нийлж байна	Зарим талаар санал нийлж байна	Огт санал нийлэхгүй байна	Хэлж мэдэхгүй
Хэвлэл мэдээллийнхэн бидний үйл ажиллагааг сонирхдоггүй				
Хэвлэл мэдээллээр үйл ажиллагаа сурталчлан таниулахад гарах зардал өндөр				
Хэвлэл мэдээллийнхэн бидний үйл ажиллагааны гол мөн чанарыг бичиж нийтлэхдээ орхигдуулдаг, өөрчилдөг				
Хэвлэл мэдээллийнхэн сенсацийн хойноос хөөцөлдөөд нийгэмд өрнөж буй үйл явдлын гол утгыг ойлгодоггүй				
Хэвлэл мэдээлэл эрх мэдлийн хэрэгжилтэд хяналт тавих үүргээ хангалттай биелүүлдэггүй				
Хэвлэл мэдээлэл иргэдэд үйлчлэх үүргээ хангалттай биелүүлдэггүй				

4. ХМХ-д мэдээлэл өгье, мэдээллээ гаргуулъя гэхэд тань тэд төлбөр шаардаж байсан тохиолдол байсан уу?

1. Тийм, байнга
2. Тийм, цөөн удаа
3. Үгүй

5. Сэтгүүлчтэй ярилцаж, мэдээлэл өгсний дараа агуулга/нэр/тайлбар гм зүйлийг тэд өөрчилж, нийтэлж нэвтрүүлсэн тохиолдол гарч байсан уу?

1. Тийм, байнга
2. Тийм, цөөн удаа
3. Үгүй

6. Хэвлэл мэдээллийнхэнд мэдээллээ өгөх, нийтлүүлэх үед гардаг өөр ямар хүндрэл, бэрхшээл байдаг вэ?

.....

7. Хэвлэл мэдээлэлтэй үр дүнтэй хамтарч ажиллахын тулд та бүхэнд ямар төрлийн дэмжлэг хэрэгтэй байна вэ?

.....

8. Танай байгууллагад хэвлэл мэдээлэлтэй харилцах, олон нийтэд мэдээлэл түгээхээр мэргэшсэн/орон тооны ажилтан бий юу?

1. Тийм, бүтэн цагийн ажилтан
2. Тийм, хагас цагийн ажилтан
3. Орон тоо байхгүй ч хавсарч хийдэг
4. Огт байхгүй
5. Өөр бусад

9. Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах ажилтан тань мэргэжлийн мэргэшлийн сургалтад хамрагдсан уу?

1. Тийм
2. Үгүй

10. Хэрэв сургалтад хамрагдах хэрэгцээ байгаа бол ямар төрлийн сургалтад хамрагдахыг хүсэж байна вэ?

.....

11. Ямар төрлийн мэдлэг, ур чадварыг олж авах/сайжруулах хэрэгцээ байна вэ?

	Маш их хэрэгцээтэй	Дунд зэрэг хэрэгцээтэй	Огт хэрэгцээгүй
Мэдээ, нийтлэл бичих			
Хэвлэл мэдээлэлд ярилцлага өгөх			
Сошиал медиад пост бичих			
Сошиал медиад зураг, видео оруулж сурах			
Өөр бусад			

12. Сургалтаас гадна ямар үйл ажиллагаа байвал хэрэгцээтэй байна вэ?

.....

13. Хэвлэл мэдээллийнхэнтэй салбарын асуудлаар яриа, хэлэлцүүлэг хийх хэрэгцээ, шаардлага бий юу? Ийнхүү зохион байгуулах тохиолдолд танай байгууллага оролцох уу?

1. Хэрэгцээ бий, оролцоно
2. Хэрэгцээ бий, оролцож магадгүй
3. Хэрэгцээ бий, оролцохгүй
4. Хэрэгцээ байхгүй, оролцохгүй

ДӨРӨВ. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАТАЙ ХАРИЛЦАХ НЬ

Судалгааны энэ хэсэг нь төрийн болон иргэний нийгмийн бүтээлч хамтын ажиллагаанд тулгарч буй хүндрэл, бэрхшээлийг тодорхойлж, түүнийг даван туулах, үр дүнтэй хамтын ажиллагааг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөхөд зорьж байна.

1. Танай байгууллагад төрийн байгууллагатай харилцах, хамтарч ажиллах хэрэгцээ гардаг уу?

1. Тийм, байнга
2. Тийм, хааяа
3. Гардаггүй

2. Хэрэв тийм бол ямар асуудлын хүрээнд харилцаа үүсгэх, хамтарч ажиллах хэрэгцээ байдаг вэ?

1. Хууль, эрх зүйн баримт бичгийн боловсруулалт, хэлэлцүүлэг
2. Тодорхой асуудлаар мэдлэг, ойлголтоо нэгтгэх
3. Зөвшилцөлд суурилсан бодлогын нөлөөлөл хийх
4. Хөгжлийн бодлого, төлөвлөлтөд хамтран ажиллах
5. Нийтийн мэдээлэлд хяналт, үнэлгээ, мониторинг хийх
6. Төрийн чиг үүргийг ТББ хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд
7. Санхүүгийн тогтвортой хөгжлийг хангах хүрээнд
8. Өөр бусад
9. Дээрхийн аль нь ч биш

3. Таны бодлоор төрийн байгууллагаас мэдээлэл авахад ИРГЭДЭД ямар хүндрэл бэрхшээл гардаг вэ?

1. Өргөдөл, хүсэлтэд хуулийн хугацаанд хариу өгдөггүй
2. Өргөдөл, хүсэлтэд өгсөн хариу нь бүрэн гүйцэд байж чаддаггүй
3. Мэдээлэл ил тод бус
4. Мэдээлэл ойлгомжтой бус
5. Үл тоох, үл хайхрах/ аюул занал
6. Өөр бусад

4. Эдгээр бэрхшээлийг даван туулахын тулд танай байгууллагаас ямар арга хэмжээг авах хүсэлтэй байна вэ?

5. Төрийн байгууллагатай үр дүнтэй харилцахын тулд иргэний нийгмийн байгууллагын зүгээс ямар үйл ажиллагааг хэрэгжүүлэх хэрэгтэй вэ?

1. Хамтарсан уулзалт, хэлэлцүүлэг санаачлан зохион байгуулах
2. Тогтмол яриа хэлэлцээр өрнүүлдэг платформуудтай болох
3. Бодлогын нөлөөлөл хийх, үр дүнтэй зөвшилцөл хийх арга техникт суралцах
4. Өөр бусад

6. Иргэний нийгэмтэй үр дүнтэй харилцахын тулд төрийн байгууллагаас ямар үйл ажиллагааг хэрэгжүүлэх хэрэгтэй вэ?

1. Урт хугацааны бодлогын баримт бичигтэй болох
2. Хамтын ажиллагааны ойлгомжтой, үр нөлөөтэй арга хэлбэрүүдээ тогтох
3. Тогтмол харилцаа холбоог дэмжих эрх бүхий албан тушаалтантай байх
4. Иргэний нийгэм хөгжих эрх зүйн таатай орчин бүрдүүлэх
5. Санхүүгийн тодорхой дэмжлэг, тэтгэлэг бий болгох
6. Өөр бусад

ТАВ. ЭГЭХ ХАРИУЦЛАГА БОЛОН ИЛ ТОД БАЙДАЛ

Судалгааны сүүлийн хэсэг нь нийгмийн эгэх хариуцлага, ил тод байдлыг тодотгох замаар иргэний нийгмийн байгууллагуудын талаарх олон нийтийн ойлголтыг сайжруулах үйл ажиллагааг төлөвлөхөд чиглэлээ.

1. Танай байгууллагын ажилтнууд байгууллагынхаа зорилго, үйл ажиллагааны чиглэл зэргийг хаанаас, ямар эх сурвалжаас шууд авах/харах боломжтой вэ?

1. Хананд хэвлэмэл байдлаар байрлуулсан хэсгээс
2. Байгууллагын вэб сайтаас
3. Байгууллагын улирлын/жилийн тайлангаас
4. Өөр бусад хэлбэр
5. Шууд олж харах боломжгүй

2. Танай байгууллагын ажилтан бүр байгууллагынхаа үйл ажиллагааны чиглэл, зорилгыг ухамсарлан, ойлгосон байдаг уу?

1. Бүгд маш сайн ойлгож, ухамсарласан
2. Ихэнх нь маш сайн ойлгож, ухамсарласан
3. Зарим нь ойлгож, ухамсарласан
4. Бүгд ойлгож, ухамсарлаагүй
5. Хэлж мэдэхгүй

3. Танай байгууллагад ажилтнуудаа хариуцлагатай, ёс зүйтэй явж буй эсэхийг хянах, зохицуулах дотоод дүрэм журам, ёс зүйн зарчим бий юу?

1. Тийм
2. Үгүй
3. Хэлж мэдэхгүй

4. Хэрэв тийм бол энэ нь ямар хэлбэртэй байдаг вэ?

1. Хөдөлмөрийн гэрээнд тусгасан
2. Ил харагдахуйцаар байрлуулсан
3. Бичигдээгүй нийтлэг ёс зүйн хэм хэмжээгээр зохицуулаад явдаг
4. Өөр бусад

5. Танай байгууллагад ажилтнуудаа болон харилцагч нараа цахим орчинг ёс зүйтэй, зөв ашиглахад туслах/чиглүүлэх удирдамж, гарын авлага байдаг уу?

1. Тийм
2. Үгүй

6. Танай байгууллага үйл ажиллагааны чиглэл, зорилгынхоо хүрээнд нийцсэн үйл ажиллагааг явуулж чадаж байгаа юу? (Жишээ: Хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр ажиллахаар байгуулагдсан бол тэр зорилгынхоо хүрээнд бүрэн ажиллаж байна уу гэдэг үүднээс хариулах)

1. Бүх үйл ажиллагаа байгууллагын зорилго, чиглэлд нийцсэн
2. Зарим үйл ажиллагаа дутагдалтай
3. Зарим үйл ажиллагаа нь байгууллагын үндсэн зорилго чиглэл дээр нэмэлтээр орж ирсэн
4. Өөр бусад

7. Танай байгууллага иргэний нийгмийн бусад байгууллагуудтай хэрхэн харилцан мэдээлэл солилцдог вэ?

- 1.
- 2.
- 3.

8. Та дараах зүйлстэй хэр зэрэг санал нийлж байна вэ?

	Бүрэн санал нийлж байна	Зарим талаар санал нийлж байна	Огт санал нийлэхгүй байна	Хэлж мэдэхгүй
Бусад иргэний нийгэм бидний үйл ажиллагааг сонирхдоггүй				
Иргэний нийгмийн байгууллагуудад хамтын ажиллагаа, харилцан ойлголцол сул				
ИНБ-ууд бусдынхаа нэр хүндэд халддаг, үл итгэлцэл өндөр				
ИНБ-ууд нэгдмэл байдал сул, хамтран бодлогын нөлөөлөл хийх чадамжгүй				
ИНБ-ууд эрх мэдлийн хэрэгжилтэд хяналт тавих (watchdog) үүргээ хангалттай биелүүлдэггүй				
ИНБ-ууд иргэдэд үйлчлэх үүргээ хангалттай биелүүлдэггүй				
Өөр бусад				

9. Танай байгууллага зорилтот бүлэг болон бусад талуудтай харилцан мэдээлэл солилцсоныхоо дараа тэдгээрийг шийдвэрлэх хариу алхам хийдэг үү?

1. Тийм, байнга
2. Тийм, хааяа
3. Тийм, цөөн удаа
4. Үгүй
5. Хэлж мэдэхгүй

10. Тийм бол ямар алхам/хариу үйлдэл ихэвчлэн хийдэг вэ?

1. Албан бичиг хүргүүлэх
2. Мэдэгдэл гаргах
3. Утсаар холбогдох
4. Уулзалт товлох
5. Олон нийтэд мэдээлэх
6. Өөр бусад

11. Өөрсдийн үйл ажиллагааны ил тод байдлыг хэрхэн хангадаг вэ?

1. Үйл ажиллагааны тухай мэдээллээ вэб сайтдаа байршуулдаг
2. Сошиал медиад байршуулдаг
3. Хэвлэл мэдээлэлд гаргуулдаг/нийтлүүлдэг
4. Зорилтот бүлгийн төлөөллийг оролцуулсан тайлангийн хурал хийдэг
5. Өөр бусад
6. Дээрхийн аль нь ч биш

12. Танай байгууллага олон нийт, зорилтот бүлгээс санал шүүмж хүлээн авдаг уу?

1. Тийм, байнга
2. Тийм, хааяа
3. Тийм, цөөн удаа
4. Үгүй

13. Хэрэв тийм бол ямар төрлийн санал, шүүмжийг, ямар сувгаар хүлээн авдаг вэ?

Хамгийн сүүлийн 3 хүртэлх жишээг бичнэ үү.

Санал хүсэлт /шүүмж	Суваг
.....	
.....	
.....	

14. Байгууллагынхаа үйл ажиллагааг ил тод байршуулж, мэдээлэхэд танайд дараах зүйлс хэр хэрэгцээтэй вэ?

	Их хэрэгцээтэй	Дунд зэрэг хэрэгцээтэй	Хэрэгцээгүй	Хэлж мэдэхгүй
Хэрхэн ил тод болгох тухай зааварчилгаа				
Ил тод байршуулахад шаардагдах ур чадвар				
Ил тод байршуулах платформ				
Өөр бусад				

ХАВСРАЛТ 2: ЯРИЛЦЛАГЫН СУДАЛГААНЫ АСУУЛГА

1. ИНБ-уудын олон нийт/зорилтот бүлэг болон хэвлэл мэдээлэлтэй харилцах харилцааг та хэр үнэлдэг вэ? Тэдний давуу болон сул тал юу вэ?
2. Хэвлэл мэдээлэлтэй үр дүнтэй хамтарч ажиллахын тулд та бүхэнд ямар төрлийн дэмжлэг хэрэгтэй байна вэ?
3. Хэвлэл мэдээллийнхэнд мэдээллээ өгөх, нийтлүүлэх үед ямар хүндрэл, бэрхшээл байдаг вэ?
4. Эдгээр бэрхшээлийг даван туулахын тулд танай байгууллагаас ямар арга хэмжээг авах хүсэлтэй байна вэ?
5. Төрийн байгууллагатай үр дүнтэй харилцахын тулд иргэний нийгмийн байгууллагын зүгээс ямар үйл ажиллагааг хэрэгжүүлэх хэрэгтэй вэ?
6. Танай байгууллага иргэний нийгмийн бусад байгууллагуудтай хэрхэн хамтарч ажилладаг вэ? Давуу болон сул тал нь юу вэ?

